МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

ADB

IRIM
INDEPENDENT RESEARCH INSTITUTE OF MONGOLIA

# “ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН



Хараат Бус Судалгааны Хүрээлэнгээс боловсруулав

УЛААНБААТАР, 2019 ОН

## Мэдэгдэл

Энэхүү судалгааг Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) 2019 оны 2 дугаар сараас 9 дүгээр сарыг дуусталх хүртэл хугацаанд Азийн Хөгжлийн Банкны захиалгаар хийж гүйцэтгэлээ. Уг тайлангийн үр дүн, дүн шинжилгээ, зөвлөмж нь зөвхөн IRIM судалгааны хүрээлэнгийн бие даасан зөвлөх багийн санал бодлыг тусгасан бөгөөд Азийн хөгжлийн банк болон Боловсрол шинжлэх ухаан спортын яам (БСШУСЯ) болон уг судалгаанд хамрагдсан бусад оролцогч талуудын санал бодлыг тусгаагүй болно.

## Судалгааны баг

| | |
|---|---|
| Жүгдэрийн Мөнхбадар | Багийн удирдагч |
| Дандийгийн Одгэрэл | Зөвлөх |
| Шагдарын Ариунболд | Түүврийн мэргэжилтэн |
| Чүлтэмсүрэнгийн Тамир | Ахлах судлаач |
| Базарсадын Мягмарсайхан | Ахлах судлаач |
| Доржнямбуугийн Бямбасүрэн | Ахлах судлаач |
| Дулмаагийн Лхагвацэрэн | Статистикч |
| Ганзоригийн Жаргалмаа | Зохицуулагч |
| Хатанбаатарын Баярцэцэг | Туслах судлаач |
| Алтансүхийн Очбадрал | Туслах судлаач |

## Талархал

Судалгааны багийн зүгээс Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн салбар дахь Нийгмийн салбар хариуцсан мэргэжилтэн Карин Шэлзиг (Karin Schelzig), БСШУСЯ-ны Тэгш хамруулан суралцуулах бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Б.Гэрэлтуяа нарт судалгааны бүх үе шатанд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан явдалд талархлаа илэрхийлье. Мөн судалгааны дизайныг боловсруулахад өөрийн үнэтэй зөвлөгөө, хувь нэмрээ оруулсан Казахстаны Назарбаевын их сургуулийн профессор, тэгш хамруулах боловсролын мэргэжилтэн Сулучино Патер болон Азийн хөгжлийн банкны зөвлөх У.Мандал нарт талархлаа.

Мөн судалгаанд өөрийн үнэтэй цагаа зарцуулж үзэл бодол, туршлагаа хуваалцсан нийт судалгаанд оролцогчид болон судалгаанд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн багш, ажилтнуудад судалгааны багийн зүгээс талархсанаа илэрхийлж байна.

## Товчилсон үгсийн жагсаалт

| | |
|---|---|
| АДХХЭ | Анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг |
| АНУ | Америкийн нэгдсэн улс |
| АХЭ | Аутизмын хүрээний эмгэг |
| БСШУСЯ | Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам |
| ГБЗХГ | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗГ | Засгийн газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МСҮТ | Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв |
| МУБИС | Монгол Улсын Боловсролын Их Сургууль |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| НТБТ | Насан туршийн боловсролын төв |
| НТБҮТ | Насан туршийн боловсролын үндэсний төв |
| НҮБХС | Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан |
| НҮТС | Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа |
| ОУ | Олон улс |
| ОУБ | Олон улсын байгууллага |
| ОУҮҮА | Олон Улсын Үйл ажиллагааны ангилал |
| СӨББ | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| СЭМҮТ | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТХЗ | Тогтвортой хөгжлийн зорилго |
| УБ | Улаанбаатар хот |
| УИХ | Улсын их хурал |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ХБ | Хөгжлийн бэрхшээл |
| ХБХ | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд |
| ХИС | Хүүхдийг ивээх сан |
| ХНХЯ | Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам |
| ХТУ | Хүүхдийн тусламжийн утас |
| ХЭҮК | Хүний эрхийн комисс |
| ШУБЯ | Шинжлэх Ухаан, Боловсролын Яам |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| ЮНЕСКО | Нэгдсэн үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага |

# Агуулга


ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ ........ 2
АГУУЛГА ........ 3
ХҮСНЭГТ, ДҮРСИЙН ЖАГСААЛТ ........ 5
**ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ ........ 8**
**1. МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД БА ТЭДНИЙ БОЛОВСРОЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ ........ 9**
1.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллага дахь ХБХ-ийн нөхцөл байдал ........ 10
1.2 Ерөнхий боловсролын сургууль дахь ХБХ-ийн нөхцөл байдал ........ 12
1.3 Ерөнхий боловсролын тусгай сургууль дахь ХБХ-ийн нөхцөл байдал ........ 13
1.4 Насан туршийн боловсролын төвд суралцаж буй ХБХ-ийн нөхцөл байдал ........ 14
1.5 Тусгай төвүүдэд харьяалагдаж буй ХБХ-ийн өнөөгийн нөхцөл байдал ........ 15
1.6 Сургууль завсардсан ХБХ-ийн өнөөгийн нөхцөл байдал ........ 16
**2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ ........ 18**
**3. ИЛРҮҮЛЭХ ҮНЭЛГЭЭ, ТҮҮНИЙ ҮР ДҮН ........ 20**
3.1 Илрүүлэлтийн үйл явц ........ 20
3.2 Хандалтын үе шат ........ 21
3.3 Үр дүн ........ 22
4. ХҮҮХДИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ........ 29
4.1 Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтын шинж байдал ........ 29
4.2 Оношлогдсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдал ........ 32
4.3 Сургууль завсардалт, түүний шалтгаан ........ 34
5. ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ОРЧИН ........ 36
5.1 Тэгш хамруулсан соёлын орчин ........ 39
5.1.1 Сургуулийн орчин дахь тэгш хамруулах соёлын түвшин ........ 42
5.1.2 Цэцэрлэг дэх тэгш хамруулсан соёлын орчин ........ 46
5.2 Боловсролын бодлогын орчин ........ 51
5.2.1 Хууль, бодлогын баримт бичигт хийсэн шинжилгээ ........ 51
5.2.2 Яамны бодлого шийдвэр, арга хэмжээ ........ 54
5.2.3 Бодлогын орчны эцэг эх ба багш нарын үнэлгээ ........ 56
5.3 Боловсролын материаллаг орчин ........ 59
5.3.1 Сургууль, цэцэрлэгийн материаллаг орчны үнэлгээ ........ 59
5.3.2 Хүртээмжтэй материаллаг орчин бүрдсэн эсэх ........ 61
5.4 Боловсролын практик орчин ........ 73

ДҮГНЭЛТ .......... 76
САНАЛ ЗӨВЛӨМЖ.......... 78
НОМ ЗҮЙ.......... 84
ХАВСРАЛТ 1- СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.......... 85
1. Өрхийн нийгмийн байдал.......... 85
1.1 Өрхийн бүтэц ба шинж байдал.......... 85
1.2.Өрхийн гишүүдийн насны бүтэц .......... 87
1.3.Өрхийн хүүхдийн шинж байдал.......... 87
1.4. 2-17 настай хүүхдүүдийн нийгмийн эмзэг байдал .......... 89
2. Өрхийн эдийн засгийн шинж байдал .......... 95
2.1.Өрхийн аж байдлын түвшин .......... 95
2.2. Өрхийн сууц.......... 96
2.3.Өрхийн эд зүйлс .......... 100
2.4.Өрхийн бусад хөрөнгө.......... 101
2.5.Өрхийн орлого ба орлогын эх үүсвэр .......... 102
3. Хүүхдийн эх/асран хамгаалагчийн мэдээлэл.......... 104
3.1 Эх, асран хамгаалагчийн үйлдлийн чадвар .......... 104
3.2.Эх, асран хамгаалагчийн шинж байдал.......... 106
ХАВСРАЛТ 2-ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ БУСАД ҮЗҮҮЛЭЛТ .......... 109
2.1 Хүүхдийн хүмүүжил .......... 109
2.2 Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт.......... 112

## Хүснэгт, дүрсийн жагсаалт

Хүснэгт 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын төрөл, тоо, 2018-2019................. 10
Хүснэгт 2. ХБХ-ийн сургуулийн өмнөх насны боловсролд хамрагдалт, 2012-2019............... 11
Хүснэгт 3. 2017-2018 оны хичээлийн жилд тусгай сургуульд суралцаж буй ХБХ-ийн тоо... 13
Хүснэгт 4.Тусгай сургуульд суралцаж буй ХБХ, бэрхшээлийн төрлөөр.................................. 14
Хүснэгт 5.НТБТ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл .......................................................... 15
Хүснэгт 6. Судалгааны үе шат, ашигласан арга зүйн тойм..................................................... 18
Хүснэгт 7. Үйлдлийн чадварууд, үйл ажиллагааны ангиллаар ............................................... 20
Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан өрх болон мэдээлэл цуглуулсан хүүхдийн тоо .............. 21
Хүснэгт 9.  2-17 настай хүүхдийн үйлдлийн чадвар .................................................................. 22
Хүснэгт 10. 2-17 настай хүүхдийн үйлдлийн чадвар, ҮСХ-ны аргазүйгээр ............................. 23
Хүснэгт 11.Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 насны хүүхдүүдийн насны ангилал........... 23
Хүснэгт 12. Үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны хүүхдүүдийн насны ангилал ........ 24
Хүснэгт 13. Хүүхдийн үйлдлийн чадвар (2-5 нас) ...................................................................... 26
Хүснэгт 14.  Хүүхдийн үйлдлийн чадвар (6-17 нас) ................................................................... 27
Хүснэгт 15.  Туслах хэрэгслийн хэрэглээ (6-17 нас) ................................................................... 28
Хүснэгт 16. Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт ........................................................................................................................................ 30
Хүснэгт 17. Үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалт......................................................................................................................... 31
Хүснэгт 18. ХБХ, онош тогтоосон байгууллагаар ....................................................................... 32
Хүснэгт 19. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр.................. 33
Хүснэгт 20. Сургууль завсардсан хүүхдүүд эргэн сургуульд ороход тулгарч буй бэрхшээл35
Хүснэгт 21.  ХБХ-ийн боловсролын хэрэгцээг тодорхойлоход судалгаанд ашигласан индикаторын хүрээ ........................................................................................................... 36
Хүснэгт 22. Зорилтот цэцэрлэг, сургуулийн соёлын орчны индекс оноо ................................ 40
Хүснэгт 23. Сургуулийн соёлын орчны индекс (үйлдлийн чадварын төрлөөр)....................... 41
Хүснэгт 24. Сургуулийн орчинд хамтын бүлэг бүрдсэн эсэх үзүүлэлт ..................................... 42
Хүснэгт 25. Тэгш хамруулах үнэт зүйлийн төлөвшлийг хэмжсэн индикаторын үр дүн ........ 44
Хүснэгт 26. Цэцэрлэгийн орчинд хамтын бүлэг бүрдсэн эсэх үзүүлэлт.................................. 47
Хүснэгт 27. Цэцэрлэгийн соёлын орчныг илтгэх шалгуур асуултуудын үр дүн...................... 48
Хүснэгт 28. Тэгш хамруулсан үнэт зүйлийн төлөвшлийг хэмжсэн индикаторын үр дүн...... 48
Хүснэгт 29.Цэцэрлэгийн соёлын орчин (n=110) ........................................................................ 49
Хүснэгт 30. Баян-Өлгий аймгийн мэдээлэл ................................................................................ 53
Хүснэгт 31. Цэцэрлэгийн орчин дахь бодлогын орчны  индекс үзүүлэлт, эцэг эх/асран хамгаалагчийн хариултаар ...................................................................................................... 56
Хүснэгт 32. Сургуулийн орчин дахь бодлогын орчны индекс үзүүлэлт.................................... 57
Хүснэгт 33. Боловсролын орчин дахь бодлогын орчны индекс үзүүлэлт, багш нарын хариултаар ..................................................................................................................................... 58
Хүснэгт 34. Гадаад дотоод материаллаг орчны үнэлгээ, хувиар .............................................. 60
Хүснэгт 35. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн боловсролыг дэмжих чиглэлээр хамтран ажилласан байгууллага /үйл ажиллагааны тоо/ .......................................................... 60

Хүснэгт 36. Сургуулийн материаллаг орчны хүртээмж........................................................ 69
Хүснэгт 37. Цэцэрлэгийн материаллаг орчны хүртээмж............................................................. 71
Хүснэгт 38. Тэгш хамруулсан практик туршлага бүрдсэн эсэх, индекс үзүүлэлт, цэцэрлэг 73
Хүснэгт 39. Тэгш хамруулсан практик туршлага бүрдсэн эсэх, индекс үзүүлэлт, сургууль 74
Хүснэгт 40.Өрхийн бүтэц ба шинж байдал ............................................................................ 86
Хүснэгт 41.Өрхөд амьдардаг хүн амын насны бүтэц, хүйсээр ................................................... 87
Хүснэгт 42.Өрхийн хүүхдийн шинж байдал ............................................................................ 88
Хүснэгт 43. 2-17 настай хүүхдийн нийгмийн эмзэг байдал Хүүхдийн эцэг, эхтэйгээ амьдарч буй байдал ба өнчин хүүхдүүд ................................................................................................ 90
Хүснэгт 44. Хүүхдийн эцэг, эхийн амьдарч буй газар .................................................................. 92
Хүснэгт 45. Эцэг, эхийн хараа хяналтгүй хүүхдүүд......................................................................... 93
Хүснэгт 46. Өрхийн аж байдлын түвшин, өрхийн тоогоор............................................................. 95
Хүснэгт 47. Өрхийн аж байдлын түвшин, байршлаар .................................................................. 96
Хүснэгт 48. Өрхийн сууцны шинж байдал ................................................................................... 97
Хүснэгт 49. Өрхийн сууцны материал............................................................................................. 99
Хүснэгт 50. Өрхийн болон өрхийн гишүүдийн эд зүйлс............................................................... 100
Хүснэгт 51. Өрхийн бусад хөрөнгийн шинж байдал .................................................................... 101
Хүснэгт 52. Дундаж малын тоо....................................................................................................... 102
Хүснэгт 53. Өрхийн сарын дундаж орлого ................................................................................... 102
Хүснэгт 54. Өрхийн орлогын эх үүсвэрийн төрлүүд..................................................................... 103
Хүснэгт 55. Эх, асран хамгаалагчийн үйлдлийн чадвар ............................................................ 105
Хүснэгт 56. Эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдал ............................................... 107
Хүснэгт 57. Хүүхдэд ашиглаж буй хүмүүжлийн арга, аймгаар................................................... 109
Хүснэгт 58. Хүүхдийг хүмүүжүүлэхэд ашиглаж буй арга, үйлдлийн бэрхшээлийн төрлөөр ........................................................................................................................................... 110
Хүснэгт 59. Эцэг эхчүүдийн бие махбодын шийтгэлд хандах хандлага .................................. 111

Дүрс 1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагат хамрагдаж буй ХБХ-ийн тоо ............ 11
Дүрс 2. Сургуульд хамрагдаж буй ХБХ-ийн тоо .......................................................................... 12
Дүрс 3.Сургууль завсардсан хүүхдүүдийн тоон мэдээлэл ........................................................... 17
Дүрс 4. Өрхүүдтэй холбогдсон үе шатууд .................................................................................... 21
Дүрс 5. 2018/2019 оны хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан хүүхдийн хувь Дүрс 6. 2018/2019 оны хичээлийн ЕБС-д хамрагдсан хүүхдийн хувь.............................................................................................................................................. 29
Дүрс 7.Хөгжлийн бэрхшээлийн зэрэг............................................................................................. 32
Дүрс 8.Тэгш хамруулсан боловсролын.......................................................................................... 37
. Дүрс 9.Тэгш хамруулсан боловсролын орчны индекс тооцсон дэд индикаторууд.............. 37
Дүрс 10. Сурагчдыг ялгаж хандах байдал, хувиар (N=565)......................................................... 44
Дүрс 11. Хүүхдүүд хоорондын хүндэтгэлтэй харилцаа, хувиар (N=520)................................... 45
Дүрс 12.ХБХ-ийг сургах үйл ажиллагаанд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл (N=76) ........... 59
Дүрс 13. Сургууль, цэцэрлэгийн гадаад орчны бэрхшээл, бэрхшээлийн төрлөөр................. 62

IRIM
INDEPENDENT RESEARCH INSTITUTE OF MONGOLIA

Дүрс 14.Автобусны буудлаас сургууль хүртэлх замаар тэргэнцэртэй хүүхэд зорчих боломжгүй байдал ... 62
Дүрс 15. Автобусны буудлаас сургууль хүртэлх замаар харааны бэрхшээлтэй хүүхэд зорчих боломжгүй байдал ... 63
Дүрс 16. Сургууль, цэцэрлэгийн хашааны болон барилгын хаалганы хувьд тэргэнцэртэй хүүхэд орох боломжгүй байдал ... 63
Дүрс 17. Сургууль, цэцэрлэгийн дотоод орчны бэрхшээл, бэрхшээлийн төрлөөр ... 64
Дүрс 18. Сургууль, цэцэрлэгийн дотор талд аюулгүй зорчих боломжгүй байдал ... 64
Дүрс 19. Сургуулийн материаллаг орчны хүрэлцээ (n=556) ... 66
Дүрс 20. Сургууль, цэцэрлэгийн орчны хүртээмжийг сайжруулах арга хэмжээ ... 67
Дүрс 21. Сургууль гадаад, дотоод материаллаг орчны хувь аюулгүй эсэх, эх, асран хамгаалагчийн үнэлгээ (n=556) ... 67
Дүрс 22. Ангийн орчин хүртээмжтэй эсэх, багшийн үнэлгээ (n=76) ... 67
Дүрс 23. Өрхийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын хүрээ ... 85
Дүрс 24.Өрхийн хүүхдийн бүтэц, байршлаар ... 85
Дүрс 25.Өрхийн сууцны төрөл, хувиар ... 96
Дүрс 26. Байшинтай өрхүүдийн шалны дулаалга (n=386) ... 98
Дүрс 27. Байшингийн дээврийн дулаалгын байдал (n=386) ... 98
Дүрс 28. Байшингийн ханын дулаалгын байдал (n=386) ... 98
Дүрс 29.Эх, асран хамгаалагчдын гэрлэлтийн байдал, (n=657) ... 106
Дүрс 30. Эх, асран хамгаалагчдын гэрлэлтийн байдал, хүүхдийн насны ангиллаар, % ... 106
Дүрс 31. Эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдал, (n=657), % ... 107
Дүрс 32. Цалин хөлстэй ажиллагч эх, асран хамгаалагчдын ажилладаг байгууллагын төрөл, (n=301) ... 107
Дүрс 33. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал ... 113
Дүрс 34. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүйсээр ... 114
Дүрс 35. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, байршлаар, хувиар ... 114
Дүрс 36. 6-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт сургуульд хамрагдалтаар, хувиар ... 115

# Тэгш хамруулах боловсрол

Хүүхэд бүрийн сурч боловсрох хэрэгцээг хангахад баримтлах суурь ойлголт нь тэгш хамруулах боловсролын зарчим билээ. Тус зарчмыг авч үзсэн олон янзын тайлбар, тодорхойлолт гарсан хэдий ч гол санааг тоймловол бүх хүүхэд өөрийн тусгай хэрэгцээндээ нийцсэн дэмжлэг туслалцаатайгаар үе тэнгийнхэнтэйгээ хамт, адил тэгш суралцах боломжоор хангагдаж байх боловсролын үйл явц юм (SCJ, 2016).

Нэгдсэн үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) тэгш хамруулах боловсролыг **"Бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаа дахь тэгш оролцоог хангах, боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц"** (UNESCO, 2008) хэмээн тодорхойлсон байна. Дээрх тайлбарууд боловсролын тогтолцоо бүхэлдээ бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг, хүн бүрийн тусгай хэрэгцээнд нийцсэн, сурагч бүр өөрийн мэдлэг чадвараа ахиулан амжилттай суралцах боломжтой сургалтын орчныг бүрдүүлэх нь боловсролын гол зорилго байх ёстойг харуулж байна.

Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх явцад энэ нь зөвхөн нийгмийн маргиналь бүлгийн[1] эрх ашигт төвлөрсөн зарчим мэтээр хязгаарлагдмал утгаар ойлгогдох хандлага түгээмэл байдаг. Гэвч энэ нь зөвхөн тодорхой нэг бүлгийн асуудлыг хөндсөн бус, бүх нийтэд боловсролыг хүртээмжтэй болгоход чиглэсэн хүмүүнлэг, хүний эрхийг дээдэлсэн үзэл санаа, зарчим юм.

Тогтвортой хөгжлийн 4 дэх зорилго болох "Тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол, бүх нийтийг насан туршийн боловсролоор хангах", түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бусад дэд зорилтуудын хэрэгжилтийг үнэлэхдээ тухайн улс орны хамгийн маргиналь бүлэг боловсролын үйлчилгээг авч чадаж буй эсэх шалгуур үзүүлэлтийг авч үздэг. Угтаа боловсролын үйлчилгээний гадна үлдэх хамгийн өндөр эрсдэл бүхий бүлгүүдэд боловсрол үйлчилгээ хүрч чадаж байвал тухайн улсын боловсролын үйлчилгээ бүх иргэддээ хүртээмжтэй байна гэж дүгнэдэг. Боловсрол бүх нийтэд хүртээмжтэй байх нь Тогтвортой хөгжлийн бусад зорилтыг хангах суурь, хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл юм.

Эцэст нь тэмдэглэхэд, тэгш хамруулан сургах боловсрол нь боловсролын салбарын урт хугацааны бодлого, түүний хэрэгжилт бөгөөд боловсролын хүртээмж, оролцоо, сургалтын үр дүнгийн ялгаатай болон тэгш бус хандлага, ялгаварлан гадуурхалт, хязгаарлагдмал байдлын бүх хэлбэрийг шийдвэрлэхэд бүх оролцогч талууд тасралтгүй хамтран ажиллах үйл явц юм.

[1] "Маргиналь бүлэг- Бүлгийн тодорхой нэг шинж чанараасаа үүдэн нийгмийн амьдралд оролцох хууль ёсны эрх мэдэл, боломж нь хязгаарлагдмал бүлэг" Нийгэм дэх шилжилт хөдөлгөөн, О.Мөнхбат, 2017

# 1. Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ба тэдний боловсролын нөхцөл байдлын тойм

Монгол Улс засаглалын хувьд ардчилсан тогтолцоотой болж нийгмийн олон салбарт өрнөсөн өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд зорилтот, цөөнх бүлэгт хандах нийгмийн хандлага цаг үеэ даган хувьсан өөрчлөгдсөөр ирсэн. Үндэсний болон олон улсын өмнө хүлээсэн үүргээрээ боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэхэд чиглэсэн оролдлогууд 2003 оноос хойш тасралтгүй хийгдсээр байна. Гэсэн хэдий ч 2018 онд хэрэгжүүлсэн Хүүхдийг ивээх сан (ХИС)-ийн "Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь" төслийн хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнгээр, тэгш хамруулах боловсролыг ойлгох багш нарын ойлголт зөвхөн "Бие махбодын бэрхшээлтэй, эмгэг согогтой хүүхдийг ердийн сургуульд хамруулах" гэдэг ойлголтоор хязгаарлагдсан хэвээр, тэгш хамруулах боловсролын үзэл санаа, зарчмыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөөгүй, бэлэн бус байгаа үр дүн гарсан (IRIM, 2018). Ийм хандлага төлөвшихөд нэг талаар монгол хэлнээ "хөгжлийн бэрхшээл" гэх нэр томьёо нь "хөгжих саад бэрхшээлтэй" буюу бие махбодын хувьд  өвчтэй, согогтой гэж ойлгогдохоор орчуулагдсан үгийн алдаатай сонголт, нэр томьёоны нөлөөлөл бий. Тухайлбал, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлийг зөвхөн бие махбодын эмгэг согог талаас нь авч үзсэн зургаан төрлийн ангилал (хараа, сонсгол, хэл яриа, оюуны, тулгуур эрхтний бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй болон хавсарсан) ашиглагддаг. Хууль эрхзүйн баримт бичгийн хүрээнд ийнхүү хязгаарлагдмал хүрээнд авч үзсэнээр иргэд олон нийт, салбарын мэргэжилтнүүдийн дунд хүртэл тус хязгаарлагдмал ойлголт, хандлага төлөвшсөн нь дээрх судалгааны үр дүнгээр харагдаж байна.

Нийгмийн олон салбар, тэр дундаа боловсролын салбарын статистик мэдээлэл өнөөдрийг хүртэл энэхүү хязгаарлагдмал тодорхойлолт, ангилалд тулгуурлан боловсруулагдаж байна. Статистик мэдээлэлд зөвхөн бие махбодын эмгэг согогтой хүүхдүүдийг авч үзсэнээр үүний цаана үлдэх бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд төрийн бодлого, хөтөлбөрийн харааны гадна үлдэх, тусгай хэрэгцээндээ нийцсэн чанартай боловсролын үйлчилгээг авахад саад учрах эрсдэлтэйг анхаарвал тус тодорхойлолт, ангиллыг дахин авч үзэх шаардлага харагдаж байна.

Дараах дэд бүлгүүдэд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (ХБХ)-д үзүүлж буй боловсролын үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг, тоо мэдээллийн хамт боловсролын байгууллагын шатлал, хэлбэр тус бүрээр тоймлон харуулахыг хичээлээ.

## 1.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллага дахь ХБХ-ийн нөхцөл байдал

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад сургуулийн өмнөх боловсролын байгууллага (СӨББ) нь зургаан хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн хичээлийн жилийн байдлаар (2018-2019) улсын хэмжээнд 1435 СӨББ үйл ажиллагаагаа явуулсан. Эдгээр СӨББ-дад нийт 1087 ХБХ хамрагджээ. СӨББ-ын төрөл тус бүрийн тайлбарыг нийт байгууллагын тооны хамт Хүснэгт 1-д харууллаа:

Хүснэгт 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын төрөл, тоо, 2018-2019

| № | Төрөл | Тодорхойлолт | СӨББ-н тоо |
|---|---|---|---|
| 1 | Ердийн цэцэрлэг | Хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага | 1330 |
| 2 | Тусгай цэцэрлэг | Хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллага | 4 |
| 3 | Сувиллын цэцэрлэг | Хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны биеийн өсөлт, оюун ухааны хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллага | 5 |
| 4 | Асрамжийн цэцэрлэг | Эрүүл мэндийн доройтолтой, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий өрхийн хүүхдүүдийн хэрэгцээг хангах зорилготой тусгайлсан үйлчилгээ | |
| 5 | Гэр цэцэрлэг | Алслагдсан сум, баг, хорооны цэцэрлэгт хамрагдаагүй хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх цэцэрлэгт түшиглэсэн асрах, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагаа | 93 |
| 6 | Асрамжийн цэцэрлэг | Хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны эцэг, эх, асран хамгаалагчгүй болох нь албан ёсоор тогтоогдсон өнчин, хагас өнчин хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллага | 3 |
| | **Нийт** | | **1435** |

Эх сурвалж: Сургуулийн өмнөх боловсролын салбарын статистик мэдээ, 2018-2019

Дээр дурдсан 1435 СӨББ-д 2018-2019 оны хичээлийн жилд нийт 261,354 хүүхэд хамрагдсаны 0,41 хувь нь ХБХ байна. Сүүлийн 7 жилийн хугацаа дахь СӨББ-т хамрагдаж байгаа хүүхдүүд дунд ХБХ-ийн эзлэх хувийг авч үзэхэд жил ирэх тусам хамран сургалт буурсан дүнтэй, сүүлийн нэг жилийн хугацаанд огцом унасан байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт байв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. ХБХ-ийн сургуулийн өмнөх насны боловсролд хамрагдалт, 2012-2019

| Хичээлийн жил | Нийт суралцагчдын тоо | ХБХ-ийн тоо | Нийт суралцагчдад эзлэх хувь |
|---|---|---|---|
| 2012-2013 | 180.969 | 1.300 | 0,71 |
| 2013-2014 | 193.672 | 1.368 | 0,7 |
| 2014-2015 | 206.636 | 1.438 | 0,69 |
| 2015-2016 | 225.388 | 1.369 | 0,6 |
| 2016-2017 | 243.432 | 1.513 | 0,62 |
| 2017-2018 | 256.720 | 1.597 | 0,62 |
| 2018-2019 | 261.354 | 1.087 | 0,41 |

Эх сурвалж: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас авсан мэдээллээр

Хамран сургалт буурсан нь СӨББ-н хүрэлцээтэй хамаарал бага харагдаж байгаа юм. Учир нь Дүрс 1-ээс харахад Улсын хэмжээнд СӨББ-ын тоо жил бүр тогтмол нэмэгдэж байгаа хэдий ч түүнд хамрагдаж байгаа ХБХ-н тоо жил ирэх тусам буурсан харагдаж байна.

Дүрс 1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагат хамрагдаж буй ХБХ-ийн тоо




Эх сурвалж: Сургуулийн өмнөх боловсролын салбарын статистик мэдээ, 2012-2018

Боловсролын хамран сургалтыг цэцэрлэг, сургуулийн түвшинд харьцуулж харвал 2018-2019 оны хичээлийн жилд нийт 2-5 настай хөгжлийн бэрхшээлтэй 1900 хүүхдийн 57,2% нь цэцэрлэгт хамрагдсан бол 6-18 насны 8,351 хүүхдийн 78% нь сургуульд хамрагджээ (ХНХЯ, 2019). Дээрх тоо баримтуудаас үзэхэд манай улсад сургуулийн өмнөх боловсролын түвшинд ХБХ-ийг хүлээн авах, хамран сургах байдал сүүлийн жилүүдэд ахиц бага, харьцангуй сул хэрэгжиж байна гэж дүгнэж болохоор байна.

СӨББ дахь ХБХ-ийн хамран сургалт буурахад дараах хүчин зүйлүүд нөлөөлөх боломжтойг судалгааны баг онцолж байна.

Нэгдүгээрт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.9-д зааснаар "Хөнгөн хэлбэрийн ХБХ-ийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэлх тооны хүүхэд нэг бүлэгт байж болно" гэж заасан. Энэ нь цэцэрлэгт ХБХ-ийг бусад үе тэнгийн хүүхдүүдийн хамт сургахыг дэмжсэн заалт боловч боловсролын салбар дахь үнэлгээ, оношилгооны чадавх сул байгаа нь дээрх заалтын хэрэгжилтийг дэмжихэд тулгарч буй гол бэрхшээл болж байна. Энэ тохиолдолд

албан ёсны үнэлгээ, оношилгоо дутмаг байгаагаас хүүхдийн бэрхшээлийн хүнд, хөнгөн эсэхийг тухайн цэцэрлэгийн багш, мэргэжилтнүүд өөрсдөө дүгнэх болдог. Үүнээс үүдэн багш мэргэжилтнүүд ХБХ-ийг дотор нь бэрхшээлийн төрөл, зэрэг зэргээс хамааран ялгаварлах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын СӨББ-ын нэг ангид ноогдох хүүхдийн ачаалал өндөр. Улсын цэцэрлэгийн нэг бүлэгт дунджаар 35-40 хүүхэд хамрагддаг. Ихэнх цэцэрлэгүүд хүчин чадлын хувьд хамран сургах тойргийнхоо хүүхдүүдэд хүрч үйлчилж чаддаггүй. Нэг багшид ноогдох ажлын ачаалал өндөр, туслах багшийн хүрэлцээ бага зэрэг шалтгаанаар багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг ердийн бүлэгт хамруулахаас цааргалах хандлага түгээмэл байна.

Мөн Монгол Улсад хүүхдийн бэрхшээлийн эрт илрүүлэг зөвхөн эрүүл мэндийн байгууллага (өрхийн эрүүл мэндийн төв)-д суурилж явагддагаас анхаарал төвлөрөл, зан авир, танин мэдэхүй, суралцах бэрхшээл зэрэгтэй холбоотой хөгжихүйн бусад бэрхшээлийг сургуулийн өмнөх боловсролын шатанд эрт илрүүлэх боломж хязгаарлагдмал байна. Иймд хөгжлийн хоцрогдолтой, бэрхшээлтэй олон хүүхдүүд илрээгүй байх, илэрсэн хүүхдүүдийг үнэлж оношлох тогтолцоо дутагдалтай байх зэрэг дээр дурдсан шалтгаанууд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй ХБХ-ийн тоо бага байхад нөлөөлж байх боломжтой.

## 1.2 Ерөнхий боловсролын сургууль дахь ХБХ-ийн нөхцөл байдал

2016 оноос эхлэн БСШУСЯ нь ЕБС болон их, дээд сургуулиудад **боловсролын салбарын мэдээллийн систем**ийг (www.esis.edu.mn) нэвтрүүлж эхэлсэн (БСШУСЯ, 2016). Тус системд аймаг, дүүргийн боловсролын хэлтсийн мэргэжилтнүүд тухайн бүсийнхээ хамран сургах тойрогт багтах ХБХ-ийн мэдээллийг нэгтгэн оруулж байна.

БСШУСЯ-ны ерөнхий боловсролын статистик мэдээгээр, сүүлийн 5 жилд сургуульд хамрагдаж байгаа ХБХ-ийн тоо огцом буурч байгааг доорх графикаас харж болно. Гэвч ХБХ-ийг тодорхойлох аргачлал тодорхой бус байгаагаас ХБХ-ийн хамран сургалт буурч байгаа, эсвэл тус тоог гаргаж буй багш нарын ойлголт хандлагад өөрчлөлт орсон эсэхийг дүгнэх боломжгүй хэвээр байна.

Дүрс 2. ЕБС-д хамрагдаж буй ХБХ-ийн тоо, 2012-2018




Эх сурвалж: Ерөнхий боловсролын салбарын статистик мэдээ, 2012-2018

Хөгжлийн бэрхшээлийн ерөнхий ангиллын (хараа, сонсгол, хэл яриа, хөдөлгөөн, оюуны бэрхшээл, сэтгэц) дагуух тоон мэдээллийг багш нар эмнэлгийн магадалгаа болон эцэг эхийн мэдээлэлд үндэслэн тодорхойлдог бол аутизмын хүрээний эмгэг (АХЭ), анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг (АДХХЭ), суралцахуйн бэрхшээл зэрэг танин мэдэхүй, зан авирын өөрчлөлттэй холбоотой бэрхшээлтэй хүүхдүүдийг багш нар өөр өөрсдийн ялгаатай ойлголтдоо үндэслэн тодорхойлж байна. Тухайлбал, багш нар сурлагын хоцрогдолтой, сурлага муутай сурагчдыг суралцахуйн бэрхшээлтэй гэж үзэх, хөдөлгөөн ихтэй, тогтвортой сууж чаддаггүй хүүхдүүдийг АДХХЭ-тэй гэж үзэн дээрх статистикт оруулдаг тухай сургалтын менежерүүд дурджээ (IRIM, 2018). Дээрх нөхцөл байдал нь Монгол Улсад боловсролын тусгай хэрэгцээ, түүний төрлийн талаарх нэгдсэн ангилал, тодорхойлолт байхгүйтэй холбоотой юм.

2016 оны Улсын их хурлаар баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хуулийн 16.2-р зүйлд багш нарын ур чадварын талаар "Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь ХБХ-тэй ажиллах мэдлэг, арга зүйг эзэмшсэн байна" гэж заажээ. Гэвч энэхүү хуулийн заалт болон бодит байдал дээрх сургуулийн үйл ажиллагаа ихээхэн зөрүүтэй байна. ХБХ-тэй ажиллах багш нарын бэлэн байдлыг үнэлэх судалгааны дүнгээс харахад ердийн ЕБС-ийн багш нарын 88% нь ХБХ-тэй ажиллахад хангалттай бэлтгэгдээгүй гэж өөрсдийгөө үнэлсэн нь дээрх үр дүнг баталж байгаа юм (IRIM, 2018).

## 1.3 Ерөнхий боловсролын тусгай сургууль дахь ХБХ-ийн нөхцөл байдал

Монгол Улсад анх 1964 оны 10 сарын 1-нд анхны сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р тусгай сургууль байгуулагдсанаар тусгай боловсрол хөгжиж эхэлсэн гэж мэргэжилтнүүд үздэг. Түүхэн талаас нь авч үзвэл, Монгол Улсын тусгай боловсролын багш, мэргэжилтнүүд анх Зөвлөлт Холбоот Улсад бэлтгэгдсэнээс тусгай боловсролын үзэл санаа илүү дефектологи буюу согог судлалын үзэл санаанд суурилж дэлгэрсэн. Тухайлбал, олигофренопедагоги (оюуны бэрхшээлтэй хүүхдийг сургах боловсрол) хүрээнд оюуны бэрхшээлийг тархины гэмтэл, хүлээн авах, ойлгох, анхаарал төвлөрөх, тогтоох, хэл зүй, хийсвэрлэн төсөөлөх болон нэгтгэн дүгнэх ур чадварт үүссэн саатал гэж тодорхойлдог.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд хараань бэрхшээлтэй хүүхдийн нэг, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн нэг, оюуны бэрхшээлтэй хүүхдийн дөрөв, нийт зургаан тусгай сургууль үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээр сургуулиудад 2017-2018 онд нийт 1637 хүүхэд суралцаж байна.

Хүснэгт 3. 2017-2018 оны хичээлийн жилд тусгай сургуульд суралцаж буй ХБХ-ийн тоо

| № | Тусгай сургуулиуд | Төрөл | Бүгд | Эмэгтэй сурагч | Эрэгтэй сурагч | Бага анги | Дунд анги | Ахлах анги |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 55-р сургууль | Оюун ухааны | 478 | 200 | 278 | 247 | 182 | 49 |
| 2 | 63-р сургууль | Оюун ухааны | 233 | 97 | 136 | 116 | 117 | - |
| 3 | 29-р сургууль | Сонсголын | 315 | 140 | 175 | 133 | 120 | 62 |
| 4 | 116-р сургууль | Харааны | 104 | 42 | 62 | 65 | 34 | 5 |
| 5 | 25-р сургууль | Оюун ухааны | 208 | 83 | 125 | 106 | 103 | - |
| 6 | 70-р сургууль | Оюун ухааны | 299 | 113 | 186 | 189 | 110 | - |

| Нийт | | 1637 | 675 | 962 | 856 | 665 | 116 |
|---|---|---|---|---|---|---|---|

Эх сурвалж: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас авсан мэдээллээр

Хүснэгт 4.Тусгай сургуульд суралцаж буй ХБХ, бэрхшээлийн төрлөөр

| Он | Хараа | Сонсгол | Хэл яриа | Оюун ухаан | Тулгуур эрхтэн | Хавсарсан | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2013 | 255 | 59 | 232 | 110 | 354 | 290 | 1300 |
| 2014 | 246 | 71 | 242 | 118 | 389 | 302 | 1368 |
| 2015 | 242 | 82 | 288 | 119 | 514 | 192 | 1437 |
| 2016 | 218 | 81 | 252 | 151 | 390 | 277 | 1369 |
| 2017 | 241 | 102 | 282 | 170 | 451 | 267 | 1517 |

Эх сурвалж: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас авсан мэдээллээр

Тусгай сургуульд суралцаж буй хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, түвшин нь сургуулиудад харилцан адилгүй байна. Тухайлбал, 25 болон 63-р тусгай сургууль хүнд хэлбэрийн ХБХ-д хамрагддаг бол 55-р тусгай сургууль сэтгэхүйн хөгжлийн хоцрогдолтой (задержка психического развития) хүүхдүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулж байна.

## 1.4 Насан туршийн боловсролын төвд суралцаж буй ХБХ-ийн нөхцөл байдал

Насан туршийн боловсролын төв (НТБТ) нь сургууль завсардалтыг бууруулах, сурах эрх нь хязгаарлагдсан эмзэг өрхийн хүүхдүүдэд бичиг үсгийн болон бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгохын зэрэгцээ ажил мэргэжилгүй, өрхийн орлого багатай эмзэг бүлгийн өрхийн залуусыг мэргэшүүлэх, иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажиллаж буй багш нарыг чадваржуулах, амьдрах ухаан, экологи, эрүүл мэнд, иргэний болон тогтвортой хөгжлийн боловсрол олгох зэрэг үйл ажиллагаа зохион байгуулдаг төрийн байгууллага юм.

2019 оны байдлаар улсын хэмжээнд 21 аймаг, Улаанбаатар хотын 8 дүүрэгт 355 НТБТ ажиллаж байна. Тэдгээр төвүүдэд 2018-2019 оны хичээлийн жилд 7296 суралцагч элсэн суралцсаны 12.8 хувь (933) нь ХБХ байна (НТБҮТ, 2018). Эдгээр суралцагчдаас бага боловсролыг 42.1 хувь (393), суурь боловсролыг 47.2 хувь (440) , бүрэн дунд боловсролыг 10.7 хувь (100) нь тус тус эзэмшжээ.

НТБТ нь **насан туршийн боловсролын хөтөлбөр, дүйцсэн сургалтын хөтөлбөр** гэсэн үндсэн хоёр чиглэлийн сургалтыг явуулдаг. Дүйцсэн сургалтын хөтөлбөр нь ерөнхий боловсролын агуулгын 70-аас доошгүй дүйцүүлж ордог[2]. Тухайлбал, НТБТ-ийн бага боловсролын сургалтын агуулга нь "Монгол хэл", "Математик", "Зураг, урлан бүтээх хөдөлмөр", "Хүн ба байгаль, эрүүл мэнд" гэсэн 4 багц дүйцсэн хичээлээс бүрддэг байна. НТБТ-ийн хөтөлбөрийн үндсэн чиглэлийг Хүснэгт 5-д харуулав.

[2] Албан бус боловсролын сургалтын талаар баримтлах бодлого, үлгэрчилсэн хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм батлах тухай, БСШУ-ны сайдын тушаал, #556, 2010

Хүснэгт 5.НТБТ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл[3]

| Насан туршийн боловсролын хөтөлбөр | Дүйцүүлсэн сургалтын хөтөлбөр[4] |
|---|---|
| • Амьдрах ухааны боловсрол<br>• Гэр бүлийн боловсрол<br>• Иргэний боловсрол<br>• Ёс суртахуун-төлөвшлийн боловсрол<br>• Гоо зүй-мэдрэмжийн боловсрол<br>• Шинжлэх ухааны боловсрол | • Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалт<br>• Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн хөтөлбөр |

Эх сурвалж: https://www.ncle.mn/

Дээрх агуулгын сургалтыг НТБТ-д холимог бүлгийн сургалтаар ордог. Холимог бүлгийн сургалт нь багш нэг ангид өөр өөр түвшний суралцагсдад зориулан явуулж буй сургалтын хэлбэр бөгөөд нэг ангид суралцагчдын тоо жирийн анги үүсгэх боломжгүй, багшийн нөөц дутмаг, тархан суурьшсан, хөдөө орон нутагт болон сургууль завсардсан, нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй байх зэрэг тусгай хэрэгцээтэй бүлгийн боловсролын хэрэгцээг хангахад зориулагдсан сургалтын өвөрмөц хэлбэр юм.

Сургалтын холимог бүлгийн хэлбэрээс гадна, НТБҮТ 2018 оноос эхлэн гэрийн сургалтын хэлбэрийг туршиж байна. Орон нутгийн найман аймаг, Нийслэлийн хоёр дүүргийн НТБТ-д хүнд хэлбэрийн ХБХ-дэд зориулан гэрийн сургалт зохион байгуулах хувилбарт үйлчилгээг явуулж байна. Уг сургалтад нийт 131 ХБХ хамрагдаж байгаагийн 55 хувь буюу 72 нь эрэгтэй, 45 хувь буюу 59 нь эмэгтэй байна (НТБҮТ, Жилийн тайлан, 2018).

Манай улсад сургууль завсардсан болон бусад тусгай хэрэгцээтэй олон сурагчдад боловсролын үйлчилгээг нөхөн олгоход НТБТ-үүд чухал үүрэг оролцоотой байгаа хэдий ч одоогийн үйл ажиллагаа явуулж буй нөхцөлөөс дүгнэхэд ихэнх тохиолдолд багш нарын ажлын туршлага, ТХХ-тэй ажиллах чадвар, арга зүй эзэмшсэн байдал мөн төвийн байр, сургалтын орчин, материаллаг орчны хангамж зэргээс хамааран төв бүрийн үйл ажиллагаа харилцан адилгүй явагдаж байна.

## 1.5 Тусгай төвүүдэд харьяалагдаж буй ХБХ-ийн өнөөгийн нөхцөл байдал

Хүнд хэлбэрийн ХБХ болон амьдралын янз бүрийн нөхцөлөөс шалтгаалан тусгай байгууллагуудад урт хугацаагаар байрлаж байгаа хүүхдүүд бий. Тухайлбал, хорих газарт ял эдэлж байгаа, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (СЭМҮТ)-д урт хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа, асрамжийн газарт байгаа ХБХ-үүд нь боловсролын үйлчилгээний гадна үлдэх өндөр эрсдэлтэй тул дээрх хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг үзүүлж буй нөхцөл байдлыг энэхүү бүлэгт авч үзлээ.

---

[3] https://www.ncle.mn/

[4] "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам"-д "Иргэдэд тодорхой хугацааны боловсролыг нөхөх, бие даах хэлбэрээр эзэмшүүлэх зорилго бүхий бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад нийцсэн албан бус сургалтыг дүйцсэн хөтөлбөрийн сургалт гэнэ" тодорхойлсон.

**Асрамжийн газарт байгаа хүүхдүүд:** Монгол Улсад 2017 оны байдлаар 32 халамж, асрамжийн байгууллагад нийт 1000 гаруй хүүхэд амьдарч байгаа гэсэн тоо баримт байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлээр нь гаргасан нарийн мэдээлэл одоогоор байхгүй байна (ГБЗХГ, 2018). Эдгээр хүүхдүүдийн хувьд тухайн асрамжийн газрынхаа харьяа хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуульд элсэн суралцдаг.

**Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдүүд:** Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг одоогийн байдлаар зөвхөн СЭМҮТ-д үзүүлж байна. Сүүлийн жилүүдэд хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал нэмэгдэж, тулгамдсан асуудал болоод байгаа талаар энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажлуудад олон дурджээ. Тухайлбал, "Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж"-нд 2018 онд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайланд дурдсанаар "Судалгааг хийх үеэр СЭМҮТ-ийн 30 ортой өсвөр үе хүүхдийн клиникийн ор нь дүүрсэн байсан ба хамгийн сүүлд таван настай хүүхэд утасны донтолтоор эмчлэгдээд гарсан" гэжээ. Хүүхэд, өсвөр үеийнхэн ихэнхдээ дэлгэцийн дон (компьютер тоглоом, гар утас), сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ (газ, мансууруулах бодисын хэрэглээ), гэр бүлийн хүчирхийлэл, дарамтын улмаас сэтгэл гутрал, айдас түгшилттэй хүүхдүүд ихэвчлэн хэвтэн эмчлүүлдэг байна (МУНЭХБТ, 2018).

СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн эмчилгээ, зөвлөгөө, засал, сэргээн засах үйлчилгээг үзүүлдэг. Дээрх үйлчилгээг авч буй хүүхдүүдийг эрүүл мэндийн ноцтой шалтгаантай гэж үздэг тул төвд тусгай боловсролын үйлчилгээг хүргэж буй туршлага өнөөдрийн байдлаар байхгүй байна.

**Хорих ял эдэлж байгаа хүүхдүүд:** Улсын хэмжээнд 2018 оны 5 сарын байдлаар насанд хүрээгүй 59 хүүхэд хорих ангид ял эдэлж байна (ХЗҮХ, 2018) гэсэн мэдээлэл байгаа боловч үүнээс хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр ангилж гаргасан бүртгэл мэдээлэл одоогоор байхгүй. Ял эдэлж байгаа хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг шүүхийн шийдвэртэй засан хүмүүжиж байх хугацаанд тасалдуулалгүйгээр хүргэх бодлогыг Монгол Улс барьж байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 411-р хүүхдийн хорих анги нь өөрийн харьяа 110-р бүрэн дунд сургуулиар дамжуулан эрх нь хязгаарлагдсан хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг хүргэж байна.

## 1.6 Сургууль завсардсан ХБХ-ийн өнөөгийн нөхцөл байдал

Бага дунд боловсролын тухай хуулийн 20.2.8.-д "Сургууль, цэцэрлэгийн захирал нь хамран сургах тойргийн бүх хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, тэдэнд суурь боловсрол заавал эзэмшүүлэх, иргэдэд нийтийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах үүрэгтэй" гэж заажээ. Тухайн бүсийн хамран сургах тойргийг Нийслэлийн болон аймгийн Боловсролын газраас тогтоодог. Өөрөөр хэлбэл боловсролын байгууллагууд хамран сургах тойргоо багтсан ХБХ-ийг тэгш хамруулан сургах үүргийг дээрх хуулийн дагуу хүлээж байна. Харьяа хамран сургах тойргийнхоо сургууль завсардсан хүүхдүүдийн мэдээллийг сургууль, цэцэрлэгүүд хороодын бүртгэл мэдээлэлд үндэслэн авдаг (IRIM, 2018) хэдий ч хорооны бүртгэл тогтмол шинэчлэгддэггүй нь сургууль завсардсан хүүхдүүдийг илрүүлэхэд тулгарч буй гол бэрхшээл болж байна.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээллээр 2018-2019 оны хичээлийн жилд сургууль завсардсан 759 хүүхэд байна. Тэдгээр хүүхдүүдийн ойролцоогоор 70 орчим хувь нь өмнө нь огт сургуульд хамрагдаж байгаагүй, үлдсэн хувь нь сургуульд суралцаж байгаад завсардсан хүүхдүүд байна (ҮСХ, 2018).

Дүрс 3.Сургууль завсардсан хүүхдүүдийн тоон мэдээлэл




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан,ҮСХ www.1212.mn

Гэвч НТБҮТ, ХИС хамтран 2019 онд 2 аймаг, 3 дүүргийн хэмжээнд гүйцэтгэсэн "Сургуулийн гадна буй сургуулийн насны хүүхдийг илрүүлэх судалгаа"-аар зөвхөн 5 байршлын хэмжээнд 340 хүүхэд илэрснээс үзэхэд үндэсний хэмжээнд дээрх тоо нь ҮСХ-нд албан ёсоор бүртгэгдсэн тоон мэдээлэл (Дүрс 3)-ээс харьцангүй их байгааг илтгэж байна. Насны хувьд сургууль завсардсан хүүхдүүдийн ихэнх нь 6-10 насны хүүхдүүд байгаа нь бага боловсролын түвшинд завсардалт илүү их байгааг харуулж байна (НТБҮТ, Судалгааны тайлан, 2019).

Хүний эрхийн комиссоос 2018 онд гүйцэтгэсэн баримт бичгийн судалгааны дүнгээр (ХЭҮК, 2018) нийт сургууль завсардсан хүүхдүүдийн хувьд сургууль завсардахад хүргэсэн гол шалтгаанд (1) хөгжлийн бэрхшээл түүнээс үүдсэн эрүүл мэндийн нөхцөл байдал, 2) ар гэрийн гачигдал, ядуурал зэрэг шалтгаанууд дурдагджээ.

Харин ХИС-ийн 2018 оны Хэрэгцээ тодорхойлох судалгаагаар, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн (ХБХ-ийг оролцуулаад) сургууль завсардалтын гол шалтгаан нь (1) Ар гэрийн санхүүгийн боломжгүй байдал, эцэг эхийн анхаарал халамж сул, 2) Сургуулийн дэд бүтэц, анги танхим, сургалтын материалын хүрэлцээ, хүртээмжгүй байдал, 3) Хөгжлийн бэрхшээлээс үүдсэн эрүүл мэндийн нөхцөл байдлууд байна гэжээ (IRIM, 2018).

Хөгжлийн бэрхшээлээс үүдсэн эрүүл мэндийн нөхцөл байдал гэдэгт ихэвчлэн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй болон хэвтрийн ХБХ-д багтдаг. 2018 онд НТБҮТ-өөс зохион байгуулсан бүртгэл судалгаагаар үндэсний хэмжээнд 6-18 насны 3372 хэвтрийн болон хүнд хэлбэрийн ХБХ байна (НТБҮТ, 2018). Дээрх хүүхдүүдийн 3.8 хувь нь (131) НТБТ-өөс гэрээр сургах үйлчилгээ авч байна.

## 2. Судалгааны арга зүй

Судалгааны гол зорилго нь төслийн сонгогдсон цэцэрлэг, сургуулийн орчинд бүх хүүхдийг тэгш хамруулан сургах орчин нөхцөл бүрдсэн эсэх, түүнийг бүрдүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж БСШУСЯ-ны цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал зөвлөмжийг боловсруулахад оршсон.

Хүүхдийн боловсролын хэрэгцээг судлахдаа судалгааны баг төслийн зорилтот орон нутагт амьдарч буй 2-17 насны "үйлдлийн чадварын хүндрэлтэй" буюу "хөгжлийн бэрхшээлтэй байх өндөр эрсдэлтэй" хүүхдүүдийг илрүүлэн боловсролд хамрагдалтын нөхцөл байдал, боловсролын хэрэгцээ шаардлагыг судлав. Ингэхдээ судалгааны бэлтгэл шатанд хийгдсэн баримт бичгийн шинжилгээний үр дүнд үндэслэн ОУ-д тэгш хамруулах боловсролыг дэмжих чиглэлээр ашиглагдаж буй хүний эрхийг дэмжсэн жишиг аргачлалуудыг үндэсний контекстэд нийцүүлэн өөрчилж ашигласан. Зорилтот өрхүүдийн нийгэм эдийн засаг, соёлын үзүүлэлтүүдийг тооцохдоо улсын хэмжээний томоохон түүвэр судалгаа болох ҮСХ-ны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018-ын үр дүнтэй харьцуулагдахуйц байдлаар ижил төстэй аргазүйг баримталж ажиллав. Судалгааны үе шат тус бүр, тэдгээрт ашигласан аргачлалын тоймтой Хүснэгт 6-аас танилцана уу.

Хүснэгт 6. Судалгааны үе шат, ашигласан арга зүйн тойм

| № | Судалгааны үе шат | Хийгдсэн үйл ажиллагаа | Ашигласан аргачлал |
|---|---|---|---|
| 1 | Бэлтгэл шат | • Тэгш хамруулан сургах боловсролын орчныг хэмжих чиглэлээр хийгдсэн судалгааны аргазүйд шинжилгээ хийх<br>• ХБХ-ийн сургалтын нөхцөл байдлыг баримт бичгийн шинжилгээнд үндэслэн судлах<br>• Судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүнийг боловсруулж турших, сайжруулах, эцэслэв | Баримт бичгийн шинжилгээ |
| 2 | 1-р шатны мэдээлэл цуглуулалт: Тоон | Төслийн зорилтот орон нутгийн сонгогдсон сум, хорооны 2-17 насны хүүхдүүдийн дунд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийг "илрүүлэх үнэлгээ"-г зохион байгуулсан | ОУ-ын Вашингтон бүлгийн Хүүхдийн үйл ажиллагаа модуль 2-5, 6-17 насны хувилбар |
| 3 | 2-р шатны мэдээлэл цуглуулалт: Тоон болон чанарын | Илрүүлэх үнэлгээнээс нэг болон түүнээс дээш үйлдлийн чадвар дээр хүндрэлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтын нөхцөл байдал, боловсролын хэрэгцээ шаардлагыг тодруулах тоон болон чанарын мэдээлэл цуглуулсан | Мэл Аинсков, Тони Буут нарын "Тэгш хамруулах боловсролын индекс"-д үнлэслэн боловсруулсан 7 төрлийн хэрэглэгдэхүүн |
| 4 | Датаг цэвэрлэх, нэгтгэх шинжлэх үе шат | Нийт хоёр шатнаас цугларсан мэдээлэлд 3 үе шаттай чанарын хяналт гүйцэтгэж, нэгтгэх, цэвэрлэх, боловсруулсан | Дескриптив болон харьцуулсан шинжилгээ |
| 5 | Тайлан боловсруулах үе шат | Үр дүнд шинжилгээ хийж тайлан боловсруулан, үр дүнг оролцогч талуудад танилцуулав. | |

Судалгааны тоон мэдээлэл цуглуулалт төслийн зорилтот цэцэрлэг, сургуулийн хамран сургах тойргийн орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд явагдсан. Үүнд,

- Дархан-Уул аймгийн Дархан сум,
- Ховд аймгийн Жаргалант сум,
- Дундговь аймгийн Мандалговь сум ,
- Хөвсгөл аймгийн Цагааннуур сум,
- Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нийт 9 байршил (баг, хороо)-д зохион байгуулагдсан.

Нэгдүгээр шатны илрүүлэх үнэлгээгээр нийт 5,328 өрхөөр зочилж 2-17 насны 9,555 хүүхдийн мэдээллийг амжилттай цуглуулсан. Нэгдүгээр шатны мэдээлэл цуглуулалтаас илэрсэн 865 (нийт нэгдүгээр шатны мэдээлэл цуглуулалтад хамрагдсан хүүхдийн 9.1 хувь) үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эцэг эхийг хоёрдугаар шатны мэдээлэл цуглуулалтад хамруулахыг зорьсон. Нийт илэрсэн түүврийн хэмжээнд хоёр дахь шатны хандалтыг гүйцэтгэж нийт түүврийн 78.1 хувиас мэдээлэл цуглуулалт гүйцэтгэв.

Үүн дээр нэмж, соёлын цөөнх, алслагдмал орон нутгийн иргэд, малчин өрх зэрэг судалгаанд дуу хоолой нь бага тусах магадлалтай бүлгүүдийг тэгш хамруулах зорилгоор Баян-Өлгий, Баянхонгор, Орхон, Сэлэнгэ, Дорноговь, Дорнод аймгийн 8 суманд 54 ганцаарчилсан ярилцлага хийж чанарын мэдээлэл цуглууллаа.

Уг судалгааны түүврийн дизайныг боловсруулах явцад мэдээллийн хязгаарлагдмал байдал, судалгааны төсөв зэрэг хүчин зүйлээс шалтгаалан магадлалт түүврийн аргын оронд зорилтот түүврийн аргыг ашигласан. Энэ нь судалгааны эх олонлогийн хүрээг тодорхой байдлаар хумьж өгсөн бөгөөд тогтсон нэгжийн түвшинд screening буюу илрүүлэх үнэлгээ хийж өөрсдийн сонирхсон зорилтот эх олонлогийг бүрдүүлж нэлэнхий ажиглалтын аргаар судалгааг хийж гүйцэтгэв.

Эцсийн шатанд бүрдүүлсэн мэдээллийн сангууд нь үндсэндээ зорилтот эх олонлогийн нэгжүүдээс бүрдсэн. Иймд тус судалгааны үр дүнг боловсруулахдаа ямар нэгэн төлөөллийг илтгэх түүврийн жин ашиглаагүй бөгөөд зөвхөн сонгогдсон нэгжийн түвшинд судалгааны үр дүнгийн боловсруулалт хийгдсэн болно.

# 3. Илрүүлэх үнэлгээ, түүний үр дүн

Илрүүлэх үнэлгээний зорилго нь Нэгдсэн үндэстний байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц”, түүнтэй нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” зэрэг баримт бичгүүдийн агуулгат тусгагдсан үзэл санааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлтэй болж болзошгүй (цаашид үйлдлийн чадварын хүндрэлтэй гэх) эрсдэлтэй хүүхдүүдийг төслийн сонгогдсон орон нутгийн хэмжээнд илрүүлэх явдал юм.

Илрүүлэх үнэлгээнд **хүүхдийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг бие махбодын эмгэг согогоос гадна нийгмийн оролцоо, орчны хүчин зүйлсийн хамт** цогцоор нь авч үзэж тодорхойлох зорилготой Олон Улсын Вашингтон бүлгийн “Хүүхдийн үйл ажиллагаа” модулийг гол хэрэглэгдэхүүнээр ашиглалаа. Уг модуль нь 2-17 насны хүүхдийн үйлдлийн чадварын хэвийн үйл ажиллагааг анхан шатны түвшинд шалгадаг. Хүүхдийн насны онцлогоос хамааран 8-12 төрлийн үйлдлийн чадварыг шалгах хоёр ялгаатай хувилбартай (Хүснэгт 7). Эдгээр үйлдлийн чадвар нь нийгмийн хүртээмжгүй орчин нөхцөлд (материаллаг болон соёлын орчин аль алинд) хүүхдийн оролцоо, сурч боловсрох боломжийг хязгаарлах боломжтой өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагддаг гол үйлдлийн чадварууд болно (WG, 2018).

Хүснэгт 7. Үйлдлийн чадварууд, үйл ажиллагааны ангиллаар

| № | 2-5 настай хүүхдийн асуулга | № | 6-17 насны хүүхдийн асуулга |
|---|---|---|---|
| 1 | Харах | 1 | Харах |
| 2 | Сонсох | 2 | Сонсох |
| 3 | Алхах | 3 | Алхах |
| 4 | Жижиг булчингийн үйл ажиллагаа | 4 | Өөртөө үйлчлэх |
| 5 | Харилцаа, холбоо | 5 | Хэл яриа, харилцаа |
| 6 | Суралцах | 6 | Суралцах |
| 7 | Тоглох | 7 | Сэргээн санах |
| 8 | Зан авираа удирдах | 8 | Анхаарлаа төвлөрүүлэх |
| | | 9 | Өөрчлөлтөд дасан зохицох |
| | | 10 | Зан авираа удирдах |
| | | 11 | Харилцаа холбоо тогтоох |
| | | 12 | Сэтгэл хөдлөл (сэтгэл гутрал, түгшүүр) |

Эх сурвалж: Module on Child Functioning, Manual for Interviewers, Washington Group, UNICEF, 2018

Судалгааны тайлангийн энэ хэсэгт илрүүлэх үнэлгээний судалгаанд хамрагдалт, хандалтын аргууд зэрэг асуудлаас гадна илрүүлэх үнэлгээний үр дүнгийн талаар дэлгэрэнгүй авч үзлээ.

## 3.1 Илрүүлэлтийн үйл явц

Төслийн зорилтот байршил болох Дорнод, Дархан, Дундговь, Хөвсгөл, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 9 байршлаас нэгдүгээр шатны тоон мэдээллийг цуглууллаа. Мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж нь өрх байв. Өрхийн сургуульд сурдаг болон сурдаггүй (завсардсан, огт сургуульд хамрагдаагүй) 2-17 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийг илрүүлэх зорилгоор төслийн зорилтот сургууль, цэцэрлэгийн хамран сургах

тойргийг төлөөлөх хороо, багийн бүх өрхөөр зочилж илрүүлэх үнэлгээг зохион байгуулсан. Судалгаанд хамрагдалтын түвшнийг Хүснэгт 8-д үзүүлэв.

Судалгаанд хамрагдах боломжтой өрхийн тоог ҮСХ-ны сум, хороодын албан ёсны мэдээлэл дээр үндэслэн гаргасан хэдий ч мэдээлэл цуглуулалтын явцад зөрүү их байсан тул судалгааны баг тухайн баг, хорооны нийт айл өрхөөр нэг бүрчлэн зочилж хамрагдвал зохих нийт өрхийн тоог гаргасан. Нийт судалгаа авах боломжтой 7,563 өрх байснаас 5,296 нь хамрагдаж, хамрагдалтын түвшин 70.4 хувь байв[5]. Эдгээр өрхөөс 2-17 насны 9,555 хүүхдийн мэдээллийг амжилттай цуглууллаа.

Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан өрх болон мэдээлэл цуглуулсан хүүхдийн тоо

| | Бүгд | Байршил | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Дорнод | Дархан | Дундговь | Хөвсгөл | УБ-СХД |
| **Өрх** | | | | | | |
| Хамрагдвал зохих | 7,563 | 2,141 | 2,272 | 965 | 179 | 2,006 |
| Бүрэн хамрагдсан | 5,296 | 1,518 | 1,437 | 615 | 162 | 1,564 |
| Хамрагдалтын түвшин, хувиар | 70.4 | 66.3 | 64.9 | 65.7 | 95.0 | 81.3 |
| **Хүүхдийн тоо** | | | | | | |
| Хамрагдсан | 9,555 | 2,521 | 2,713 | 1,065 | 291 | 2,965 |

## 3.2 Хандалтын үе шат

Хамрагдвал зохих өрхүүдтэй холбогдохдоо хандалтыг дараах гурван үе шаттайгаар зохион байгуулав.

Дүрс 4. Өрхүүдтэй холбогдсон үе шатууд




[5] 29.6 хувь нь холбогдож чадаагүй болон татгалзсан өрхүүд юм. Баяр наадам, зуны амралт, орон нутгийн өрхүүд зусландаа гарсан зэрэг шалтгаанаар өрхүүд эзгүй байх, судалгаанд хамрагдах боломжгүй байв. Эдгээр өрхтэй холбогдохоор дунджаар нэг өрх рүү 3 удаагийн хандалт хийсний дараа авах боломжгүй өрхийн жагсаалтад оруулсан.

IRIM INDEPENDENT RESEARCH INSTITUTE OF MONGOLIA

## 3.3 Үр дүн

Илрүүлэх үнэлгээнд хамрагдсан 5,296 өрхийн 2-17 насны 9,555 хүүхдээс нийт 874 буюу 9.1 хувь нь наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй буюу эрсдэлтэй бүлэгт орсон. Үүнээс 106 нь 2-5 насны хүүхдүүд, 768 нь 6-17 насны хүүхдүүд байна. Байршлаар авч үзвэл наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн хувь Улаанбаатар хотод хамгийн өндөр (12.9 хувь) байгаа бол Дорнод аймагт хамгийн бага (6.3 хувь) байна.

**Хүснэгт 9. 2-17 настай хүүхдийн үйлдлийн чадвар**

Хүүхдийн эзлэх хувь, байршлаар, IRIM судалгааны хүрээлэнгийн үнэлгээний аргазүйгээр

| | Наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 насны хүүхдийн хувь | 2-5 настай хүүхдийн тоо | Наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны хүүхдийн хувь | 6-17 настай хүүхдийн тоо | Наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-17 насны хүүхдийн хувь | 2-17 настай хүүхдийн тоо |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 3.4 | 3136 | 12.0 | 6419 | 9.1 | 9555 |
| Байршил | | | | | | |
| Дорнод | 2.0 | 794 | 8.2 | 1727 | 6.3 | 2521 |
| Дархан-Уул | 3.3 | 855 | 9.6 | 1858 | 7.6 | 2713 |
| Дундговь | 1.9 | 359 | 13.6 | 706 | 9.7 | 1065 |
| Хөвсгөл | 3.7 | 109 | 11.0 | 182 | 8.2 | 291 |
| УБ-СХД | 5.0 | 1019 | 17.0 | 1946 | 12.9 | 2965 |

2018 онд ҮСХ-ны Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа (НҮТС)–д мөн ижил Вашингтон бүлгийн "Хүүхдийн үйл ажиллагаа" модулийг ашиглан мэдээлэл цуглуулсан. НҮТС-ний үр дүнтэй харьцуулахад тус илрүүлэх үнэлгээний үр дүн даруй 4 хувиар өндөр гарсан. Энэ нь тоололт хийсэн аргазүйн ялгаатай байдлаас үүдэлтэй[6] бөгөөд хэрвээ НҮТС-д ашигласан аргазүйгээр[7] тооцвол ижил үр дүн гарч байна. Тухайлбал, ҮСХ-ны аргазүйгээр тооцоход 2-17 насны хүүхдүүдийн 5.1 хувь наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй байна (Хүснэгт 10).

---

[6] Тус судалгаа нь үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийг илрүүлж, тэдгээр хүүхдүүдэд боловсролын орчинд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилготой тул ҮСХ-ны аргачлалаас арай өргөн хүрээнд тоололтоо хийсэн.

[7] ҮСХ нь 6-17 настай хүүхдийн хувьд сэтгэл түгших, гуниглах байдлыг **өдөр бүр** илэрдэг бол сэтгэл түгших бэрхшээлтэй гэж үнэлсэн бол IRIM судалгааны хүрээлэнгийн баг уг үзүүлэлтийг **өдөр бүрээс гадна долоо хоног бүр** илэрдэг бол сэтгэл түгших бэрхшээлтэйд тооцсон. Түүнчлэн ҮСХ нь 2-5 настай хүүхдийн хувьд бусдыг **маш ихээр** өшиглөж, хазаж, цохидог бол зан авираа удирдах бэрхшээлтэй гэж тооцсон бол IRIM-ын баг уг үзүүлэлт "**маш их**"-ээс гадна "**их**" гэсэн хариултыг сонгосон бол хүүхдийг зан авираа удирдахдаа хүндрэлтэй гэж тооцсон.

Хүснэгт 10. 2-17 настай хүүхдийн үйлдлийн чадвар, ҮСХ-ны аргазүйгээр

| Хүүхдийн эзлэх хувь, байршлаар, ҮСХ-ны үнэлгээний аргазүйгээр | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 насны хүүхдийн хувь | 2-5 настай хүүхдийн тоо | Наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны хүүхдийн хувь | 6-17 настай хүүхдийн тоо | Наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-17 насны хүүхдийн хувь | 2-17 настай хүүхдийн тоо |
| **Бүгд** | **2.1** | **3136** | **6.5** | **6419** | **5.1** | **9555** |
| **Байршил** | | | | | | |
| Дорнод | 1.4 | 794 | 5.7 | 1727 | 4.4 | 2521 |
| Дархан-Уул | 1.9 | 855 | 5.5 | 1858 | 4.3 | 2713 |
| Дундговь | 1.1 | 359 | 6.2 | 706 | 4.5 | 1065 |
| Хөвсгөл | 1.8 | 109 | 7.1 | 182 | 5.2 | 291 |
| УБ-СХД | 3.1 | 1019 | 8.3 | 1946 | 6.5 | 2965 |

*Вашингтон бүлгийн аргачлалаар "сэтгэл гутрал" болон "сэтгэлийн түгшүүр"-ийн домэйнийг хэмжихдээ тухайн шинж тэмдэг 1) Өдөр бүр, 2) Долоо хоног бүр 3) Сардаа нэг удаа 4) Жилдээ цөөн давтамжтай илэрдэг эсэх гэсэн 4 шкалаар хэмждэг. Эрсдэлтэй хүүхдийг тооцохдоо 1 болон 2-р хариултыг сонгосон утгаар тооцох эсэхийг судалгааны зорилго, контекст, арга зүй зэргээс хамааран тооцохыг Вашингтон бүлгийн аргазүйгээр зөвлөдөг. ҮСХ-ны НҮТС-ны аргазүйд тус домайныг зөвхөн 1 буюу өдөр тутам илэрдэг хүүхдүүдийг тооцсон бол тус судалгаанд 1 болон 2 хариултыг сонгосон хүүхдүүдийг эрсдэлтэй хүүхдүүдэд тооцсон. Энэ нь хүүхдүүдийн боловсролын тусгай хэрэгцээ, суралцахад тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг илүү тодруулахыг зорьсон судалгааны зорилготой холбоотойгоор ийнхүү өргөн хүрээнд тооцсон болно.

### 3.3.1 Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн насны бүтэц

Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 насны хүүхдүүдийн хувьд 2-3 насныхан бусад насныхнаас 5 орчим хувиар олон, хөвгүүдийн тоо охидоос 20 хувиар илүү, олонх нь Улаанбаатар хот болон Дархан-Уул аймагт оршин сууж байна. Улаанбаатар хотын үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн дунд 2-3 насныхан эзлэх хувь өндөр байгаа бол Дархан-Уул, Дорнод аймагт 3-4 насныхан, Дундговь аймагт 2 ба 5 насныхан, Хөвсгөл аймагт 3 настай хүүхдүүдийн эзлэх хувь өндөр байна.

Хүснэгт 11.Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 насны хүүхдүүдийн насны ангилал

| Хүүхдийн хувь, хүйсээр, байршлаар | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | | Хүйс, хувиар | | Байршил, хувиар | | | | |
| | Тоо | Хувь | Эр | Эм | Дорнод | Дархан | Дундговь | Хөвсгөл | УБ-СХД |
| **Бүгд** | 106 | 100 | 60.0 | 40.0 | 15.1 | 26.4 | 6.6 | 3.8 | 48.1 |
| **Хүүхдийн нас** | | | | | | | | | |
| 2 нас | 29 | 27.4 | 18.8 | 11.3 | 2.8 | 4.7 | 2.8 | 0.9 | 16.0 |
| 3 нас | 30 | 28.3 | 21.3 | 7.5 | 4.7 | 7.5 | 0.9 | 1.9 | 13.2 |
| 4 нас | 25 | 23.6 | 15.0 | 7.5 | 5.7 | 8.5 | 0.9 | 0.9 | 7.5 |
| 5 нас | 22 | 20.8 | 5.0 | 13.8 | 1.9 | 5.7 | 1.9 | 0.0 | 11.3 |

Үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны хүүхдүүдийн хувьд 8-10 настай хүүхдүүд эзлэх хувь хамгийн өндөр буюу тус бүр 10 гаруй хувийг эзэлж байна. Охидын тоо хөвгүүдээс ялимгүй их, олонх нь Улаанбаатар хот болон Дархан-Уул аймагт оршин сууж байна.

Хүснэгт 12. Үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны хүүхдүүдийн насны ангилал

| Хүүхдийн хувь, хүйсээр, байршлаар | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | | Хүйс, хувиар | | Байршил, хувиар | | | | |
| | Тоо | Хувь | Эр | Эм | Дорнод | Дархан | Дундговь | Хөвсгөл | УБ-СХД |
| **Бүгд** | 768 | 100 | 48.4 | 51.6 | 18.4 | 23.4 | 12.5 | 2.6 | 43.1 |
| **Хүүхдийн насны бүлэг** | | | | | | | | | |
| 6 -9 | 307 | 40.0 | 21.2 | 18.3 | 7.4 | 9.4 | 5.5 | 0.5 | 17.2 |
| 10 - 14 | 330 | 43.0 | 18.5 | 24.6 | 7.0 | 11.3 | 4.8 | 1.8 | 18.0 |
| 15 - 17 | 131 | 17.1 | 8.7 | 8.7 | 3.9 | 2.7 | 2.2 | 0.3 | 7.9 |
| **Нас** | | | | | | | | | |
| 6 | 64 | 8.3 | 3.1 | 3.8 | 1.7 | 2.3 | 0.8 | 0.3 | 3.3 |
| 7 | 76 | 9.9 | 5.4 | 5.1 | 2.3 | 1.8 | 0.9 | 0.1 | 4.7 |
| 8 | 87 | 11.3 | 6.9 | 4.7 | 1.4 | 2.1 | 2.0 | 0.1 | 5.7 |
| 9 | 80 | 10.4 | 5.8 | 4.7 | 2.0 | 3.1 | 1.8 | 0.0 | 3.5 |
| 10 | 84 | 10.9 | 5.6 | 5.1 | 2.2 | 2.7 | 1.2 | 0.5 | 4.3 |
| 11 | 76 | 9.9 | 5.3 | 4.9 | 1.7 | 2.9 | 1.3 | 0.5 | 3.5 |
| 12 | 70 | 9.1 | 4.0 | 5.4 | 1.2 | 1.7 | 1.6 | 0.5 | 4.2 |
| 13 | 52 | 6.8 | 1.1 | 4.9 | 0.9 | 2.3 | 0.3 | 0.3 | 3.0 |
| 14 | 48 | 6.3 | 2.5 | 4.3 | 1.0 | 1.7 | 0.5 | 0.0 | 3.0 |
| 15 | 47 | 6.1 | 3.8 | 2.5 | 1.4 | 0.9 | 0.8 | 0.0 | 3.0 |
| 16 | 50 | 6.5 | 2.9 | 3.8 | 1.4 | 1.3 | 0.8 | 0.1 | 2.9 |
| 17 | 34 | 4.4 | 2.0 | 2.4 | 1.0 | 0.5 | 0.7 | 0.1 | 2.1 |

### 3.3.2 Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн бэрхшээлийн түвшин

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хэмээн илрүүлсэн 2-5 насны 106 хүүхэд болон 6-17 насны 768 хүүхдийн эзлэх хувийг үйлдлийн чадвар тус бүрээр нь Хүснэгт 13 ба Хүснэгт 14-д харуулав. Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 настай хүүхдүүдийн хувьд илэрсэн хамгийн түгээмэл үйлдлийн чадварын хүндрэлүүд нь зан авираа удирдах, харилцах, суралцах, тоглох чадварууд байна. 2-5 насны эдгээр хүүхдийн 73.6 хувь нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй, 26.4 хувь нь нэгээс дээш үйлдлийн чадварын хүндрэлтэй аж. 2-5 насны хүүхдүүдийн 19% нь алхахдаа дэмжлэг авдаг, 5.7 хувь нь харааны шил зүүдэг, 2.8 хувь нь сонсголын аппарат зүүдэг байна.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 настай хүүхдүүдийн хувьд илэрсэн хамгийн түгээмэл хэлбэр нь **сэтгэл түгших, сэтгэл гутрах шинжүүд** байна. Тодруулбал, 71.1%-д нь сэтгэл түгших, 47.3%-д нь сэтгэл гутрах шинж илэрчээ. Судалгааны байршил, хүүхдүүдийн насны ангилал, сургуульд хамрагдалтаас нь үл шалтгаалан дээрх шинжүүд илэрч байна.

6-17 насны хүүхдийн 57.6 хувь нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй, 42.4 хувь нь нэгээс дээш үйлдлийн чадварын хүндрэлтэй аж. Судалгааны байршлаар авч үзвэл нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эзлэх хувь Дундговь аймагт, нэгээс дээш үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эзлэх хувь Хөвсгөл аймагт давамгайлж байна. Насны ангиллаар харьцуулахад нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эзлэх хувь 15-17

насныханд (61.8%) хамгийн их, нэгээс дээш үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эзлэх хувь 10-14 насныханд (45.8%) хамгийн их байна.

Туслах хэрэгсэл, төхөөрөмж[8] хэрэглэдэг боловч тухайн үйлдлийн чадварын хүрээнд хүндрэлтэй хэвээр байгаа 6-17 насны хүүхдийн эзлэх хувийг Хүснэгт 15-д үзүүлэв. 6-17 насны хүүхдүүдийн 12.6 хувь нь харааны шил зүүдэг, 4.7 хувь нь алхахдаа дэмжлэг авдаг, 1.3 хувь нь сонсголын аппарат зүүдэг байна.

[8] Туслах хэрэгсэл, төхөөрөмж гэж биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах, хамгаалах, дэмжих, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслүүд. Тухайлбал, хараагы шил, сонсголын аппарат, тэргэнцэр, таяг г.м

## Хүснэгт 13. Хүүхдийн үйлдлийн чадвар (2-5 нас)

Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 настай хүүхдийн хувь, хүндрэлийн хэлбэрээр

| | | 2-5 настай хүүхдийн хувь | | | 2-5 настай хүүхдийн хувь, үйлдлийн чадварын хүндрэлийн хэлбэрээр | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2-5 настай хүүхэд | Харааны шил, контакт линз зүүдэг | Сонсголын аппарат зүүдэг | Алхахдаа дэмжлэг авдаг | Харах | Сонсох | Алхах | Жижиг булчин үйл ажиллагаа | Харилцах | Суралцах | Тоглох | Зан авираа удирдах | Нэг үйлдлийн хүндрэлтэй хүүхдийн хувь | Нэгээс дээш үйлдлийн хүндрэлтэй хүүхдийн хувь | Харааны шил, контакт линз зүүдэг ч харааны хүндрэлтэй хүүхдийн хувь | Сонсголын аппарат зүүдэг ч сонсоход хүндрэлтэй хүүхдийн хувь | Алхахдаа дэмжлэг авдаг ч алхахад хүндрэлтэй хүүхдийн хувь | Үеийн хүүхдүүдтэй харьцуулахад алхахад хүндрэлтэй хүүхдийн хувь |
| **Бүгд** | 106 | 5.7 | 2.8 | 18.9 | 7.5 | 7.5 | 1.4 | 9.4 | 22.6 | 19.8 | 17.0 | 61.3 | 73.6 | 26.4 | 1.9 | 0.9 | 17.0 | 11.3 |
| **Байршил** | | | | | | | | | | | | | | | | | | |
| Дорнод | 16 | 6.3 | 0.0 | 25.0 | 6.3 | 0.0 | 1.6 | 18.8 | 37.5 | 37.5 | 25.0 | 62.5 | 62.5 | 37.5 | 0.0 | 0.0 | 25.0 | 25.0 |
| Дархан-Уул | 28 | 0.0 | 0.0 | 17.9 | 10.7 | 10.7 | 1.4 | 3.6 | 14.3 | 17.9 | 14.3 | 67.9 | 78.6 | 21.4 | 0.0 | 0.0 | 14.3 | 7.1 |
| Дундговь | 7 | 42.9 | 0.0 | 28.6 | 28.6 | 14.3 | 1.2 | 28.6 | 28.6 | 28.6 | 28.6 | 57.1 | 57.1 | 42.9 | 28.6 | 0.0 | 28.6 | 0.0 |
| Хөвсгөл | 4 | 0.0 | 0.0 | 25.0 | 0.0 | 0.0 | 2.3 | 50.0 | 25.0 | 25.0 | 25.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 0.0 | 0.0 | 25.0 | 50.0 |
| УБ-СХД | 51 | 3.9 | 5.9 | 15.7 | 3.9 | 7.8 | 1.2 | 3.9 | 21.6 | 13.7 | 13.7 | 58.8 | 78.4 | 21.6 | 0.0 | 2.0 | 13.7 | 7.8 |
| **Нас** | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | 29 | 3.4 | 0.0 | 17.2 | 3.4 | 3.4 | 1.3 | 0.0 | 10.3 | 6.9 | 6.9 | 72.4 | 86.2 | 13.8 | 0.0 | 0.0 | 13.8 | 6.9 |
| 3 | 30 | 6.7 | 3.3 | 33.3 | 13.3 | 10.0 | 1.6 | 13.3 | 40.0 | 26.7 | 26.7 | 50.0 | 63.3 | 36.7 | 3.3 | 0.0 | 30.0 | 16.7 |
| 4 | 25 | 4.0 | 8.0 | 4.0 | 4.0 | 8.0 | 1.3 | 12.0 | 4.0 | 8.0 | 4.0 | 76.0 | 84.0 | 16.0 | 4.0 | 4.0 | 4.0 | 8.0 |
| 5 | 22 | 9.1 | 0.0 | 18.2 | 9.1 | 9.1 | 1.4 | 13.6 | 36.4 | 40.9 | 31.8 | 45.5 | 59.1 | 40.9 | 0.0 | 0.0 | 18.2 | 13.6 |
| **СӨБ-д хамрагдалт** | | | | | | | | | | | | | | | | | | |
| Хамрагддаг | 66 | 3.0 | 4.5 | 10.6 | 6.1 | 7.6 | 1.3 | 6.1 | 15.2 | 15.2 | 13.6 | 65.2 | 80.3 | 19.7 | 1.5 | 1.5 | 10.6 | 6.1 |
| Хамрагддаггүй | 39 | 10.3 | 0.0 | 30.8 | 10 | 7.7 | 1.5 | 15.4 | 33.3 | 28.2 | 23.1 | 56.4 | 64.1 | 35.9 | 2.6 | 0.0 | 25.6 | 17.9 |

## Хүснэгт 14. Хүүхдийн үйлдлийн чадвар (6-17 нас)

Үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 настай хүүхдийн хувь, хүндрэлийн хэлбэрээр

| | | 6-17 настай хүүхдийн хувь, үйлдлийн чадварын хүндрэлийн хэлбэрээр | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6-17 настай хүүхдийн тоо | Харааны | Сонсголын | Алхах | Өөртөө үйлчлэх | Харилцах | Суралцах | Сэргээн санах | Анхаарлаа төвлөрүүлэх | Өөрчлөлтөд дасан зохицох | Зан авираа удирдах | Харилцаа холбоо тогтоох | Сэтгэл түгших | Сэтгэл гутрах | Нэг үйлдлийн хүндрэлтэй хүүхдийн хувь | Нэгээс дээш үйлдлийн хүндрэлтэй хүүхдийн хувь |
| **Бүгд** | 768 | 5.6 | 2.9 | 7.7 | 3.3 | 5.5 | 7.3 | 5.6 | 5.1 | 6.0 | 5.9 | 5.3 | 71.1 | 47.3 | 57.6 | 42.4 |
| **Байршил** | | | | | | | | | | | | | | | | |
| Дорнод | 141 | 4.3 | .7 | 12.1 | 7.1 | 5.0 | 6.4 | 6.4 | 5.7 | 6.4 | 7.1 | 5.0 | 70.2 | 44.7 | 58.2 | 41.8 |
| Дархан-Уул | 180 | 9.4 | 3.3 | 6.1 | 3.3 | 6.1 | 6.7 | 7.2 | 6.1 | 3.3 | 8.9 | 6.7 | 68.9 | 48.3 | 55.6 | 44.4 |
| Дундговь | 96 | 0.0 | 3.1 | 4.2 | 0.0 | 2.1 | 5.2 | 1.0 | 2.1 | 1.0 | 0.0 | 0.0 | 68.8 | 42.7 | 71.9 | 28.1 |
| Хөвсгөл | 20 | 10.0 | 15.0 | 5.0 | 5.0 | 15.0 | 35.0 | 15.0 | 5.0 | 15.0 | 5.0 | 5.0 | 65.0 | 20.0 | 40.0 | 60.0 |
| УБ-СХД | 331 | 5.4 | 2.7 | 7.9 | 2.4 | 5.7 | 6.9 | 5.1 | 5.1 | 8.2 | 5.4 | 6.3 | 73.7 | 50.8 | 55.3 | 44.7 |
| **Насны бүлэг** | | | | | | | | | | | | | | | | |
| 6-9 | 307 | 3.6 | 2.6 | 8.8 | 3.9 | 5.2 | 4.9 | 4.9 | 5.2 | 5.5 | 5.5 | 4.2 | 70.0 | 46.9 | 59.3 | 40.7 |
| 10 - 14 | 330 | 6.7 | 3.9 | 6.7 | 3.9 | 7.0 | 9.7 | 7.6 | 5.8 | 7.6 | 7.3 | 6.7 | 69.1 | 48.5 | 54.2 | 45.8 |
| 15 - 17 | 131 | 7.6 | .8 | 7.6 | 0.0 | 2.3 | 6.9 | 2.3 | 3.1 | 3.1 | 3.1 | 4.6 | 78.6 | 45.0 | 61.8 | 38.2 |
| **Сургуульд хамрагдалт** | | | | | | | | | | | | | | | | |
| Хамрагддаг | 725 | 5.9 | 2.9 | 5.8 | 2.6 | 4.0 | 5.8 | 4.4 | 4.6 | 5.4 | 5.4 | 4.3 | 72.1 | 47.4 | 58.8 | 41.2 |
| Хамрагддаггүй, сурч байгаад гарсан | 13 | 0.0 | 0.0 | 38.5 | 7.7 | 7.7 | 23.1 | 7.7 | 0.0 | 0.0 | 0.0 | 7.7 | 61.5 | 46.2 | 30.8 | 69.2 |
| Огт сурч байгаагүй | 30 | 0.0 | 3.3 | 40.0 | 16.7 | 40.0 | 36.7 | 33.3 | 20.0 | 23.3 | 20.0 | 30.0 | 50.0 | 43.3 | 40.0 | 60.0 |

| Хүснэгт 15. Туслах хэрэгслийн хэрэглээ (6-17 нас) | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйлдлийн чадварын бэрхшээлд зориулсан туслах хэрэгсэл ашигладаг 6-17 настай хүүхдийн хувь, ашигладаг хэрэгслээр | | | | | | | | | | |
| | | 6-17 настай хүүхдийн хувь | | | Харааны шил/контакт линз зүүдэг ч харааны хүндрэлтэй хүүхдийн хувь | Сонсголын аппарат зүүдэг ч сонсоход хүндрэлтэй хүүхдийн хувь | Алхахдаа дэмжлэг авдаг ч алхахад хүндрэлтэй хүүхдийн хувь | | Үеийн хүүхдүүдтэй харьцуулахад алхахад хүндрэлтэй хүүхдийн хувь | |
| | 6-17 настай хүүхдийн тоо | Харааны шил/ контакт линз зүүдэг | Сонсголын аппарат зүүдэг | Алхахдаа дэмжлэг авдаг | | | 100м | 500м | 100м | 500м |
| **Бүгд** | 768 | 12.6 | 1.3 | 4.7 | 3.4 | 0.3 | 0.0 | 2.6 | 3.6 | 4.7 |
| **Байршил** | | | | | | | | | | |
| Дорнод | 141 | 12.8 | 1.4 | 5.0 | 2.1 | 0.0 | 0.0 | 5.0 | 7.1 | 8.5 |
| Дархан-Уул | 180 | 12.2 | 1.1 | 6.1 | 5.6 | 0.6 | 0.0 | 2.2 | 3.3 | 3.3 |
| Дундговь | 96 | 10.4 | 0.0 | 3.1 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.1 | 2.1 | 1.0 |
| Хөвсгөл | 20 | 5.0 | 5.0 | 0.0 | 5.0 | 5.0 | 0.0 | 0.0 | 5.0 | 0.0 |
| УБ-СХД | 331 | 13.9 | 1.5 | 4.5 | 3.6 | 0.0 | 0.0 | 2.1 | 2.7 | 5.1 |
| **Насны бүлэг** | | | | | | | | | | |
| 6-9 | 307 | 6.5 | 1.0 | 3.9 | 1.0 | 0.0 | 0.0 | 2.6 | 2.9 | 5.5 |
| 10 - 14 | 330 | 14.8 | 1.5 | 4.8 | 4.5 | 0.6 | 0.0 | 1.5 | 3.9 | 3.6 |
| 15 - 17 | 131 | 21.4 | 1.5 | 6.1 | 6.1 | 0.0 | 0.0 | 5.3 | 4.6 | 5.3 |
| **Сургуульд хамрагдалт** | | | | | | | | | | |
| Хамрагддаг | 725 | 12.8 | 1.2 | 3.4 | 3.6 | 0.3 | 0.0 | 1.5 | 2.8 | 3.6 |
| Хамрагддаггүй, сурч байгаад гарсан | 13 | 0.0 | 7.7 | 38.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 30.8 | 15.4 | 15.4 |
| Огт сурч байгаагүй | 30 | 13.3 | 0.0 | 20.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 16.7 | 20.0 | 26.7 |

# 4. Хүүхдийн сургалтын үйл ажиллагааны ерөнхий нөхцөл байдал

## 4.1 Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтын шинж байдал

ТХЗ-ын зорилт 4.1-д "2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байх" гэж заасан байдаг. Сайн чанартай сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нь хүүхдийн суралцах чадварыг сайжруулахаас гадна анги улирах болон сургууль завсардалтыг бууруулж амжилт гаргахад эерэг нөлөө үзүүлдэг бол бага боловсрол нь хүний насан туршид суралцах суурь чадавхыг төлөвшүүлдэг. Иймд ТХЗ-ын зорилтод хүрэхийн тулд улс орнууд дээрх насны сургуульд хамрагдалтын хувьд онцгой анхаарал тавьдаг.

Монгол Улсын хувьд хүүхдүүд 2-5 насандаа сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, 6 наснаас ерөнхий боловсролын бага сургуульд, 12 насандаа дунд сургууль, 15 насандаа ахлах сургуульд элсэн ордог. Тус насаар тооцоход 2018 оны НҮТС-аар Монгол Улсын хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалт 68 хувь, бага боловсролд хамрагдалт 96.1 хувьтай, харин дунд боловсролд хамрагдалт нь 93 хувьтай байжээ. Үүнээс харахад дээр дурдсан ТХЗ-ийн зорилгод 2030 он гэхэд хүрэх боломжтой харагдаж байна.

Харин судалгааны зорилтот орон нутгийн хэмжээнд 657 үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн боловсролын байгууллагад хамрагдсан байдлыг авч үзэхэд 2-5 насны хүүхдийн 64 хувь нь цэцэрлэгт, 6-17 насны хүүхдийн 96 хувь нь 2018-2019 оны хичээлийн жилд ямар нэгэн боловсролын байгууллагад хамрагдсан байгаа нь УСХ-ны судалгааны дүнтэй ойролцоо байна (Дүрс 5, 6).

**Дүрс 5. 2018/2019 оны хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан хүүхдийн хувь**




**Дүрс 6. 2018/2019 оны хичээлийн жилд ЕБС-д хамрагдсан хүүхдийн хувь**




2018-2019 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдсан үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн олонх нь ердийн цэцэрлэгт суралцжээ. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн хувьд ихэнх нь огт цэцэрлэгт хамрагдаж байгаагүй бөгөөд тэдгээрийн ихэнх нь хөвгүүд байна.

### Хүснэгт 16. Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт

Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт "хувиар, байршлаар, насаар"

| | | Цэцэрлэгт хамрагдалт | | Суралцдаг цэцэрлэгийн төрөл | | | | | | Нийт хүүхдийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хамрагдсан | Хамрагдаагүй | Ердийн цэцэрлэг | тусгай цэцэрлэг | сувиллын цэцэрлэг | асрамжийн цэцэрлэг | халамжийн цэцэрлэг | гэр цэцэрлэг болон бусад цэцэрлэг | |
| Нийт | | 63% | 37% | 94% | 5% | 0% | 0% | 0% | 2% | 101 |
| Аймаг дүүргийн нэр | Дорнод аймаг | 56% | 44% | 100% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 18 |
| | Дархан-Уул аймаг | 71% | 29% | 87% | 13% | 0% | 0% | 0% | 0% | 21 |
| | Дундговь аймаг | 75% | 25% | 100% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 8 |
| | Хөвсгөл аймаг | 67% | 33% | 100% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 3 |
| | УБ-СХД | 61% | 39% | 94% | 3% | 0% | 0% | 0% | 3% | 51 |
| Нас | 2 нас | 30% | 70% | 100% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 23 |
| | 3 нас | 52% | 48% | 92% | 0% | 0% | 0% | 0% | 8% | 25 |
| | 4 нас | 82% | 18% | 100% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 17 |
| | 5 нас | 68% | 32% | 85% | 15% | 0% | 0% | 0% | 0% | 19 |
| | 6 нас | 100% | 0% | 94% | 6% | 0% | 0% | 0% | 0% | 17 |
| | Хариулахаас татгалзсан | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0% | 0 |

Үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны хүүхдүүдийн 96.2 хувь нь 2018-2019 оны хичээлийн жилд сургуульд хамрагдсан бол 3.8 хувь нь сургуульд хамрагдаагүй байна. Сургуульд суралцдаг хүүхдүүдийн 95.2 хувь нь ЕБС-ийн ердийн ангид, 1.7 хувь нь ЕБС-ийн тусгай анги болон тусгай сургуульд, 1.4 хувь нь МСҮТ болон ИДС-д суралцдаг байна.

2018-2019 оны хичээлийн жилд сургууль завсардсан хүүхдүүдийг насаар нь харьцуулан харвал 6-10 настай хүүхдүүдийн 2.5 хувь, 11-14 настай хүүхдүүдийн 3.5 хувь, 15-17 настай хүүхдүүдийн 6.7 хувь нь тус тус сургууль завсардсан байна. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн хувьд нас ахих тусам сургууль завсардалт нэмэгдэх хандлагатай байна.

## Хүснэгт 17. Үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалт

| Үйлдлийн хүндрэлтэй 6-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын байдал "хувиар, насаар, байршлаар" | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2018-2019 онд сургууль хамрагдалтын байдал | | Сурдаг сургуулийн төрөл | | | | | | | | Нийт 6-17 настай хүүхдийн тоо |
| | | Сургуульд сурсан | Сургууль завсардсан | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага | энгийн сургууль | энгийн сургууль /тусгай анги/ | энгийн сургууль /хүүхэд хөгжлийн төв/ | тусгай сургууль | насан туршийн боловсролын төв | МСҮТ, Техникум | их дээд сургууль, коллеж | |
| Нийт | | 96.2% | 3.8% | 0.8% | 95.2% | 0.2% | 0.4% | 1.5% | 0.0% | 1.3% | 0.6% | 556 |
| Аймаг, дүүргийн нэр | Дорнод | 94.6% | 5.4% | 0.0% | 97.7% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 2.3% | 92 |
| | Дархан-Уул | 97.3% | 2.7% | 0.9% | 91.7% | 0.9% | 0.0% | 3.7% | 0.0% | 1.8% | 0.9% | 113 |
| | Дундговь | 96.2% | 3.8% | 0.0% | 100.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 79 |
| | Хөвсгөл | 100.0% | 0.0% | 0.0% | 100.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 18 |
| | УБ-СХД | 96.1% | 3.9% | 1.3% | 94.0% | 0.0% | 0.9% | 1.7% | 0.0% | 2.1% | 0.0% | 254 |
| Нас | 6-10 нас | 97.5% | 2.5% | 1.6% | 97.3% | 0.0% | 0.4% | 0.8% | 0.0% | 0.0% | 0.0% | 278 |
| | 11-14 нас | 96.5% | 3.5% | 0.0% | 96.3% | 0.6% | 0.6% | 2.5% | 0.0% | 0.0% | 0.0% | 172 |
| | 15-17 нас | 93.3% | 6.7% | 0.0% | 88.1% | 0.0% | 0.0% | 2.0% | 0.0% | 6.9% | 3.0% | 105 |

Дээрхээс дүгнэхэд төслийн зорилтот орон нутгийн хэмжээнд сургуульд хамрагдалтын хувь хэмжээ улсын дүнтэй ойролцоо буюу ЕБС-ийн хамрагдалт харьцангуй сайн, харин сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт улсын дунджаас даруй 5 хувиар бага дүнтэй байна[9].

[9] Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018-ын үр дүнгээр сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн хувь 68,2 хувь, бага боловсролд хамрагдалт 96 хувь, дунд боловсролын хамрагдалт 93 хувь, ахлах ангид хамрагдалт 84 хувь (хамран сургалтын цэвэр жин) байна.

## 4.2 Оношлогдсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдал

Хоёрдугаар шатны мэдээлэл цуглуулалтад хамрагдсан 2-17 насны 657 [10] үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн 19,6% (N=129) нь хөгжлийн бэрхшээлтэй болох нь албан ёсоор оношлогдсон хүүхдүүд байв. Тэдгээр хүүхдүүдийн 82.6% нь эрүүл мэндийн байгууллагаар, 6.2% нь эцэг эх, гэр бүл өөрсдөө тодорхойлсон гэж хариулжээ (Хүснэгт 18).

Хүснэгт 18. ХБХ, онош тогтоосон байгууллагаар

| № | Байгууллагын төрөл | Дорнод | Дархан | Дундговь | Хөвсгөл | УБ-СХД | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийн байгууллага | 84.6% | 84.8% | 100.0% | 90.0% | 85.4% | 87.6% |
| 2 | Өөрсдөө тодорхойлсон | 0.0% | 12.1% | 0.0% | 10.0% | 7.3% | 6.2% |
| 3 | Салбар комиссын дүгнэлтээр | 15.4% | 0.0% | 0.0% | 0.0% | 7.3% | 5.42% |
| 4 | Боловсролын байгууллага | 0.0% | 3.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.8% |
| | Нийт | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% | 100% |

Монгол Улсад 2014 оноос албан ёсоор 0-16 насны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, Боловсрол, Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилготой салбар комиссууд аймаг, дүүрэг бүрийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дэргэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. 2014 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны дэргэд анх Төв комисс байгуулагдан, 2017 оноос бүх 21 аймаг, 9 дүүрэгт салбар комиссуудыг жинхлэн байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Гэвч дээрх судалгааны дүнгээр Салбар комиссын үнэлгээгээр баталгаажсан хүүхэд төслийн зорилтот орон нутгууд (сонгогдсон сум, хорооны хэмжээнд)-аас Улаанбаатар хот болон Дорнод аймгуудад л цөөн тоотой бүртгэгдсэн байгаа нь Салбар комиссын үйл ажиллагаа бүх сум, хороонд хүрч чадахгүй байгааг харуулж байна.

### Дүрс 7.Хөгжлийн бэрхшээлийн зэрэг




Хөгжлийн бэрхшээлийн хүндрэл, зэргийн хувьд нийт оноштой 2-17 хүртэлх насны хүүхдүүдийн 81 хувь нь дунд болон хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Хөгжлийн бэрхшээл нь оношлогдсон 2-5 насны хүүхдүүдийн 22 хувь нь, 6-17 насны хүүхдүүдийн 16.7 хувь нь нэгээс олон төрлийн буюу хавсарсан бэрхшээлтэй байсан. Бэрхшээл хавсарсан байх хэрээр хүүхдийн нийгмийн амьдралд оролцох, сурч боловсрох, үйлдэл гүйцэтгэх чадварууд хязгаарлагдаж байдаг тул

[10] Нэгдүгээр шатны мэдээлэл цуглуулалтаас илэрсэн 865 үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эцэг эхийн 78.1 хувь нь хоёрдугаар шатны мэдээлэл цуглуулалтад хамрагдсан болно.

дээрх тооны хүүхдүүдийн боловсролын хэрэгцээ шаардлагад онцгой анхаарал хандуулах шаардлагатай юм.

Хөгжлийн бэрхшээлийн тодорхой оноштой хүүхдүүдийг бэрхшээлийн төрлөөр нь харвал сонгогдсон орон нутгийн хэмжээнд хөдөлгөөний болон тархины гэмтэлтэй хүүхдүүд зонхилсон байгаагийн 56 хувь нь 2-10 насны хүүхдүүд байв. Өөрөөр хэлбэл төслийн зорилтот орон нутагт тулгуур эрхтний бэрхшээл бага насны хүүхдүүдийн дунд нийтлэг байна.

Хүснэгт 19. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр

| № | Бэрхшээлийн ангилал | 2-5 нас | 6-10 нас | 11-14 нас | 15-17 нас | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Суралцахуйн бэрхшээл | 0.0% | 6.0% | 5.9% | 4.5% | 4.6% |
| 2 | Аутизмын хүрээний эмгэг | 4.3% | 2.0% | 0.0% | 0.0% | 1.55% |
| 3 | Зан төлөвийн өөрчлөлт | 0.0% | 6.0% | 0.0% | 0.0% | 2.32% |
| 4 | Хэл яриа, харилцааны бэрхшээл | 13.0% | 8.0% | 17.6% | 13.6% | 12.4% |
| 5 | Хараагүй, Харааны бэрхшээл | 4.3% | 10.0% | 17.6% | 31.8% | 14. 7% |
| 6 | Сонсголгүй, Сонсголын бэрхшээл | 0.0% | 10.0% | 26.5% | 22.7% | 14.7% |
| 7 | Хараагүй, сонсголгүй хавсарсан | 0.0% | 0.0% | 0.0% | 4.5% | 0.77% |
| 8 | Хөдөлгөөний бэрхшээл | 30.4% | 30.0% | 17.6% | 13.6% | 24% |
| 9 | Оюун ухааны бэрхшээл | 4.3% | 6.0% | 20.6% | 13.6% | 10.8% |
| 10 | Тархины гэмтэл | 52.2% | 18.0% | 8.8% | 13.6% | 21% |
| 11 | Хөгжлийн хоцрогдол | 13.0% | 10.0% | 5.9% | 4.5% | 8.5% |
| 12 | Бусад өвчин эмгэг | 4.3% | 20.0% | 8.8% | 13.6% | 13.3% |
| | Нийт оношлогдсон ХБХ | 23 | 50 | 34 | 22 | 129 |

## 4.3 Сургууль завсардалт, түүний шалтгаан

Боловсролын тухай хуулийн 6.3-д “Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй” гэж заасан. ТХЗ-ын зорилт 4.1-д "2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, холбогдох, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байх” гэж заасан. Тиймээс Монгол оронд 6-14 насны хүүхдүүд насандаа тохирох боловсролын байгууллагын ангид суралцахгүй байгаа хүүхдийг сургууль завсардсан хүүхэд хэмээн тодорхойлж болно. НҮТС-аар сургууль завсардалт нь бага ангид 3.6 хувь, дунд ангид завсардалт нь 4.6 хувь байна. Харин ахлах ангид завсардалт нь 9.5 хувьтай байна. Сургууль завсардах магадлал нь ахлах ангид хамгийн өндөр, дунд ангид дунд зэрэг, харин бага ангид хамгийн бага сургууль завсарддаг байна. Үндэстний хувьд, казах хүүхдүүд бага ангидаа сургууль завсардах байдал нь илүү өндөр байна. Өрхийн аж байдлын индексийн хувьд харьцуулан харахад бага ангид аж байдлын түвшний нөлөө нь бага, харин дунд ангид аж байдлын түвшин доогуур өрхийн хүүхдийн сургууль завсардалт ихсэж улмаар ахлах ангид ороход энэ ялгаа нь огцом мэдэгдэхүйц өсөж байна[11].

**Судалгаагаар төслийн зорилтот орон нутаг дахь үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж тодорхойлогдсон 6-17 насны хүүхдүүдийн 3.8 хувь буюу 21 хүүхэд сургууль завсардсан байна.**

Сургууль завсардсан шалтгааныг гурван бүлэгт хуваан үзвэл хүүхдээс өөрөөс хамаарсан шалтгаанаар нийт хүүхдүүдийн 81 хувь (17), ар гэрийн шалтгаанаар гэж хариулсан хүүхдүүд 14.3 хувь (3), сургуультай холбоотой шалтгаанаар гэж хариулсан хүүхдийн эцэг эх 4.7 хувь (1)-тай маш бага байна.

Нэгд, хүүхдээс өөрөөс нь хамаарсан гэх шалтгааны хувьд давхардсан тоогоор хүүхэд дургүй 1, хүүхдийн харилцааны чадвар сулаас 1, нийгэмшлийн хоцрогдлоос 1, биеийн эрүүл мэндийн байдлаас 16, бусад гэж 3 хүүхдийн эцэг эх хариулжээ.

Хоёрт, ар гэрийн шалтгаанаар гэж хариулсан хүүхдүүдийн хувьд давхардсан тоогоор сургуульд хүргэж өгөх хүнгүйгээс 1, сургуулийн зардлыг төлөх боломжгүйгээс 4 хүүхэд, бичиг баримтгүйгээс 1 хүүхэд, шилжих хөдөлгөөнөөс 2 хүүхэд, бусад 3 шалтгаанаар сургууль завсарджээ.

Гуравт, сургуультай холбоотой хүчин зүйлийн хувьд давхардсан тоогоор үе тэнгийнхний дарамт шахалтаас болсон гэж нэг хүүхэд хариулсан, мөн багш ажилчдын дарамт шахалтаас гэж 1 хүүхэд тус тус хариулсан байна.

[11] Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, НҮБХС, ҮСХ, Монгол улс, 2018

Хүснэгт 20. Сургууль завсардсан хүүхдүүд эргэн сургуульд ороход тулгарч буй бэрхшээл

| № | Хүндрэл бэрхшээлүүд | Давтамж |
|---|---|---|
| 1 | Бүртгэл, ХБХ-ийн илрүүлэлт сул, тогтмол хийгддэггүй | 6 |
| 2 | Нэг завсардсан эсвэл сургуульд элсээгүй хүүхэд сургуульд суралцах сонирхол бага байдаг | 6 |
| 3 | Эцэг эхийн дэмжлэг сул, хүүхдээ сургах сонирхол бага байдаг | 9 |
| 4 | Сургуулийн удирдлага, багш ажилчид авах сонирхол бага байдаг | 4 |
| 5 | Багш ажилчдын сөрөг хандлага | 1 |
| 6 | Үе тэнгийнхний сөрөг хандлага | 6 |
| 7 | Сургуульд хүлээн авах эрхзүйн зохицуулалт хангалтгүй | 5 |
| 8 | Завсардсан, хоцрогдсон хүүхэдтэй ажиллах багшид нэмэлт дэмжлэг дутмаг | 7 |
| | Нийт | 44 |

Аймаг дүүргийн боловсролын хэлтсийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас харахад сургууль завсардсан, сургуулийн гадна үлдсэн ХБХ-ийг сургуульд хамруулахад учирч байгаа гол дөрвөн бэрхшээл байна. Эдгээрийг эрэмбэлбэл нэгд, эцэг эхийн дэмжлэг сул, мэдээлэл багатай байдаг нь, хоёрт, сургуулиудад завсардсан, хоцрогдсон хүүхэдтэй ажиллах багшид нэмэлт дэмжлэг дутмаг, гуравт, албан ёсны бүртгэл, ХБХ-ийн илрүүлэлт хийгддэггүй, дөрөвт, үе тэнгийнхний сөрөг хандлага зэрэг нь нөлөөлдөг байна. Тухайлбал бага сургуулийг дүүргээд дунд сургуульд багш, ажилчдын дэмжлэг дутагдсанаас болоод сургуулиас гарсан охины жишээг доороос харж болно.

**Шигтгээ 1. Баян-Өлгий аймгийн ХБХ-тэй казах эхийн ярилцлагаас**

Манай охин тэргэнцэртэй, сайн явж чаддаггүй. Дунд сургуульд бусад хүүхдүүдтэй хамт сурах боломж, хүрэлцээ байгаагүй. Бага сургуульд ээж нь ажилладаг болохоор бүх юманд тусалж ихэнх хичээлээ өөрөө заадаг болохоор хүүхэд сурч чадсан. Дунд ангид ороход сургууль дээр туслах хүн байгаагүй, хүүхдүүд ч тусалдаггүй, тэр ч байтугай багш нар ч хүртэл туслахаас татгалзсан. Мөн сургуульд гаднаас ороход налуу шат энэ тэр байгаагүй учраас сургуульд явах боломжгүй болсон.

Мөн чанарын мэдээллээс харахад үндэсний цөөнх болсон казах хүүхдүүдийн хувьд бага ангидаа сургууль завсардах явдал гардаг нь тэд албан ёсны хэл ба эх хэл хоёрыг зэрэг эзэмших шаардлага тулгардагтай холбоотой байна.

## 5. Тэгш хамруулах боловсролын орчин

Нэгдүгээр шатны судалгаагаар илэрсэн үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн сургалтын орчинд тулгардаг хүндрэл бэрхшээл, цаашдын боловсролын хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд Хүснэгт 21-т харуулсан тэгш хамруулах боловсролын гол индикаторуудын дагуу мэдээлэл цуглуулсан. Тус шалгуур үзүүлэлтүүдийг баримт бичгийн судалгааны үр дүнд үндэслэн боловсруулав:

**Хүснэгт 21. ХБХ-ийн боловсролын хэрэгцээг тодорхойлоход судалгаанд ашигласан индикаторын хүрээ**

| | Шалгуур үзүүлэлт | Эцэг эх | | Багш | | Нийгмийн ажилтан | | Ажиглалт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Чан | Тоо | Чан | Тоо | Чан | Шалгах хуудас |
| 1 | Тэгш хамруулсан соёл | + | | | | | | |
| 2 | Тэгш хамруулсан бодлого | + | | + | | | + | |
| 3 | Тэгш хамруулсан туршлага, практик | + | | | | | + | |
| 4 | Тэгш хамруулсан материаллаг орчин | + | | + | | | | + |

**Тэгш хамруулсан соёлын хүрээнд -** Тухайн сургуульд бүх хүүхэд аюулгүй, хүлээн зөвшөөрөгдсөн, хамтач найрсаг орчин, соёл, үнэт зүйл төлөвшсөн эсэхийг авч үзсэн. Ингэхдээ тухайн сургуулийн орчинд хүүхэд бүр өөрийнхөө боломжит дээд хэмжээнд хүртэл суралцах, хөгжих боломжтой, хүүхэд бүр өөрийнхөө үнэ цэнийг мэдэрдэг орчин бүрдсэн байх нь чухал.

**Тэгш хамруулсан бодлогын хүрээнд -** Сургуулийн дотоод бодлого, журам, төлөвлөгөө нь бүх ажилтан болон суралцагчийн оролцоог сургуульд элсэн орсон цагаас эхлэн дэмжих, хүүхэд бүрд хүрч ажиллах, ялгаварлан гадуурхалтыг хамгийн бага түвшинд байлгахад чиглэсэн эсэхийг эцэг эх, багш нарын хариултад үндэслэн тодорхойлсон.

**Тэгш хамруулсан практик туршлагын хүрээнд** - Сургууль дээр дурдсан тэгш хамруулах зарчмыг дэмжсэн бодлого, соёлын хүчин зүйлээ үйл ажиллагааны хэрэгжилтдээ хэрхэн буулгаж ажиллаж байгааг тодорхойлохыг зорьсон. Тухайлбал, багш хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн ажиллаж чаддаг эсэх, сурагчдын ялгаатай байдал, хэрэгцээнд нийцүүлэн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулдаг эсэх, хүүхэд бүр сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог эсэх нь гол шалгуур болно.

**Материаллаг орчны хүрээнд** - Энэ хүрээнд сургуулийн гадаад, дотоод орчин бүх хүүхдэд үйлчлүүлэхэд хүртээмжтэй, түгээмэл загвартай, зайлшгүй шаардлагатай нэмэлт туслах хэрэглэгдэхүүн, материал, нөөцтэй эсэхийг урьдчилан боловсруулсан шалгах хуудсыг ашиглан тодорхойлов.

Дээрх индикаторуудыг боловсруулахад ашигласан аргазүйн гол эх сурвалж болох "Тэгш хамруулах боловсролын индекс"-д дурдсанаар Дүрс 8-д харуулсан 3 орчин нь тэгш хамруулсан боловсролын орчин бүрдэх үндсэн гурвалжин хэмээн тодорхойлжээ (Ainskow, 2002)




Дүрс 8.Тэгш хамруулсан боловсролын үндсэн 3 чиглэл

Зорилтот цэцэрлэг, сургуульд тэгш хамруулсан орчин бүрдсэн эсэхийг дээрх 4 орчны хүрээнд авч үзэж үнэлэхдээ орчин тус бүр холбогдох 2-5 дэд индикаторын биелэлтээр хэмжигдэхээр боловсруулсан (Дүрс 9). Дэд индикатор тус бүр нь түүнийг илэрхийлэх 2-5 асуултаар хэмжигдэнэ.

Дүрс 9.Тэгш хамруулсан боловсролын орчны индекс тооцсон дэд индикаторууд




Орчин тус бүр дээр нэгдсэн индекс оноо тооцохдоо тухайн индикаторыг бүрдүүлж байгаа асуултуудын биелэлт нийт хэмжсэн асуултын тооноос нэгээр бага байж болохоор тооцсон. Тухайлбал: Сургуульд тэгш хамруулсан бодлогын орчин бүрдсэн эсэх индикатор нь түүнийг илэрхийлэх 4 дэд индикатораас бүрдсэн. Эхний дэд индикатор болох "Сургуулийн дотоод бодлого, үнэт зүйлийн талаар багш, сурагч, эцэг эхчүүд тогтмол мэдээлэл авдаг эсэх"

индикаторын биелэлтийг тооцохдоо түүнийг хэмжсэн 5 асуултын 4 ба түүнээс дээш утга дээр эерэг хариулт өгсөн оролцогчийн нийлбэрээр индекс оноо тооцогдсон.

Индекс оноог тайлбарлахдаа тухайн боловсролын байгууллагад хэмжсэн индикаторын биелэлт 40-өөс бага бол тэгш хамруулсан орчин **хангалттай бүрдээгүй**, 40-60 бол **бий болж байгаа**, 60-80 **сайжруулах шаардлагатай**, 80-100-н хооронд бол **хангалттай бүрдсэн** гэсэн шкалаар үнэлэв.

Судалгаанд онол аргазүйн эх сурвалж болгон ашигласан "Тэгш хамруулах боловсролын индекс"-д сургуулийн материаллаг орчинтой холбоотой асуудлуудыг авч үздэггүй. Иймд судалгааны баг баримт бичгийн судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсын боловсролын салбарын контекстэд сургуулийн материаллаг орчны асуудлыг зайлшгүй авч үзэх шаардлагатай гэж үзэн тус орчныг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан ашигласан. Ингэхдээ Ерөнхий боловсролын сургуулийн барилга төлөвлөлтийн дүрэм (Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 305 дугаар тушаалын 2 дугаар хавсралт) болон олон улсад ашиглагдсан ижил төстэй судалгааны асуулгад үндэслэн "Сургуулийн материаллаг орчны ажиглалтын хуудас" боловсруулан ашиглав.

## 5.1 Тэгш хамруулсан соёлын орчин

Тэгш хамруулсан соёлын орчин нэн тэргүүнд бүрдсэн байх нь тэгш хамруулсан боловсролын орчныг бүрдүүлэх суурь нь болж байна. Иймд энэхүү бүлэгт зорилтот цэцэрлэг, сургуулийн орчинд хүүхдэд ээлтэй, бие биетэйгээ хүндэтгэлтэй харилцах соёл, үнэт зүйлс төлөвшсөн эсэх, хүүхдийг хөгжлийн бэрхшээл болон хувийн ялгаатай байдлаар нь ялгаварлан гадуурхахгүй боловсролд тэгш хамруулж буй эсэх үзүүлэлтүүдийн үр дүнг авч үзлээ. Судалгаанд нэгдүгээр шатны үнэлгээнээс үйлдлийн чадварын хүндрэлтэй болох нь илэрсэн хүүхдийн эцэг эхийн байр суурь, санал бодолд үндэслэн соёлын орчны индекс тооцоог гаргасан болно:

Зорилтот ЕБС-дад үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах соёл бүрдсэн эсэхийг тодорхойлохдоо сургууль, цэцэрлэгт **1. Хамтын соёл төлөвшсөн эсэх, 2. Соёлын орчны үнэт зүйлс төлөвшсөн эсэх** гэсэн хоёр үзүүлэлтээр соёлын орчны индексийг хэмжсэн. Соёлын орчны индекс дараах шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээнд суурилсан. Үүнд:

**Сургууль, цэцэрлэгт хамтын соёл бүрдсэн байдал:**

1. Хүн бүр бие биедээ хүндэтгэлтэй, найрсаг ханддаг эсэх
2. Багш нар хүүхэд бүрийн онцлог, тусгай хэрэгцээг харгалзаж найрсаг харилцдаг эсэх
3. Хүүхдийн суралцах боломжийг хангасан аюулгүй орчинд суралцдаг эсэх
4. Хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг эсэх
5. Сургуулийн багш, ажилчид хүүхдийг бие биедээ туслахыг дэмждэг эсэх

**Соёлын орчны үнэт зүйлсийн төлөвшил:**

1. Багш нар бүх хүүхдэд адил тэгш, шударга ханддаг эсэх
2. Сургууль мэргэжлийн өндөр ёс зүйтэй, хүүхдээ даатгаж болохуйц үлгэр жишээ багш нартай эсэх
3. Сургууль нь хүүхдүүдэд маргаан зөрчилдөөнийг эв зүйгээр, хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхийг үлгэрлэдэг эсэх
4. Багш нар хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалзаж ажилладаг эсэх

Тэгш хамруулсан соёлын орчин бүрдсэн эсэхийг индекс болгон тооцохдоо тодорхойлсон индикаторуудын биелэлт тухайн боловсролын байгууллагад 40-өөс бага бол тэгш хамруулсан соёлын орчин хангалттай бүрдээгүй, 40-60 бол бий болж байгаа, 60-80 сайжруулах шаардлагатай, 80-аас их бол хангалттай бүрдсэн гэсэн шкалаар тооцсон.

Төслийн зорилтот орон нутаг дахь цэцэрлэг, сургуулиудад тэгш хамруулсан соёлын орчин бүрдсэн эсэхийг үнэлэхэд СӨББ-ийн соёлын орчин 18.8 хувь, ЕБС-ийн соёлын орчин маш бага 1.4 хувьтай гарчээ. Энэ нь төслийн зорилтот цэцэрлэг болон сургуулийн орчинд бүх хүүхдийг тэгш хамруулан сургах соёлын орчин бэлэн биш байгааг харуулж байна.

Судалгааны үр дүнг аймаг, дүүргээр үзвэл Дундговь аймгийн сонгогдсон сургуульд хамтын бүлгийн соёл бусад сургуулиудтай харьцуулахад бага зэрэг өндөр байгаа хэдий ч тэгш хамруулсан үнэт зүйлийг төлөвшүүлэх үйл явцад анхаарах шаардлагатай харагдаж байна (Хүснэгт 22).

### Хүснэгт 22. Зорилтот цэцэрлэг, сургуулийн соёлын орчны индекс оноо

| Цэцэрлэг, сургуулийн соёлын орчны үнэлгээ | | | |
|---|---|---|---|
| Аймаг, дүүрэг | 1.Хамтын бүлгийн соёл төлөвшсөн эсэх | 2.Тэгш хамруулсан үнэт зүйлс төлөвшсөн эсэх | Соёлын орчны нийлбэр индекс үнэлгээ |
| **Сургуулийн орчны соёлын индекс** | | | |
| Дундговь аймаг | 25,3 | 11.4 | 3.8 |
| Хөвсгөл аймаг | 5,6 | 11 | 5.6 |
| УБ, СХД | 3,5 | 15 | 0.8 |
| Дархан Уул аймаг | 3,5 | 26,5 | 1.8 |
| Дорнод аймаг | 5,4 | 14,1 | 0.0 |
| **Нийт** | | | **1.4** |
| **Цэцэрлэгийн соёлын орчны индекс** | | | |
| Дундговь аймаг | 62,5 | 37 | 37.5 |
| Хөвсгөл аймаг | 66,7 | 33 | 33.3 |
| УБ, СХД | 29,4 | 25 | 19.6 |
| Дархан Уул аймаг | 47,6 | 14 | 14.3 |
| Дорнод аймаг | 22,2 | 11 | 11.1 |
| **Нийт** | | | **18.8** |

80-100 Хангагдсан
60-79 Сайжруулах шаардлагатай
40-59 Бий болж байгаа
40<Огт хангагдаагүй

Цэцэрлэгийн соёлын орчин сургуулиас арай өндөр үзүүлэлттэй гарсан бөгөөд Хөвсгөл, Дундговь аймгийн сонгогдсон цэцэрлэгүүдэд тэгш хамруулсан соёлын орчин бий болж байгаа үр дүн харагдаж байна.

Дээрх үр дүнгээс харахад олон талын ялгаатай, тусгай хэрэгцээтэй бүх хүүхдийг хүлээж авах, нэг хамт олон болох хамтач найрсаг орчин, тэгш хамруулах үнэт зүйлийн төлөвшил төслийн зорилтот нийт цэцэрлэг, сургуулийн хэмжээнд сул байна.

Сургуулийн соёлын орчны индексийг хүүхдийн үйлдлийн чадварын төрлөөр харьцуулан авч үзвэл 1. Сэтгэл гутрал 2. Орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвар 3.Сэтгэл түгших 4.Сэргээн санах 5.Анхаарлаа төвлөрүүлэх чадвар султай хүүхдүүдийн хувьд доогуур үнэлгээтэй байна.

Хүснэгт 23. Сургуулийн соёлын орчны индекс (үйлдлийн чадварын төрлөөр)

| Үйлдлийн чадварын төрөл | 1.Хүн бүр биедээ хүндэтгэлтэй, найрсаг ханддаг гэж хариулсан оролцогчийн хувь | 2.Багш нар хүүхэд бүрийн онцлог тусгай хэрэгцээг харгалзаж хүүхэд бүртэй зөөлдөг найрсаг харилцдаг гэж хариулсан оролцогчийн хувь | 3.Хүүхдийг өөрийнхөө боломжийн дээд хэмжээнд бүрэн дүүрэн суралцах боломжийг хангасан аюулгүй орчин | 4.Хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг | 5.Сургуулийн багш ажилчид бүх хүүхдийг биедээ туслахыг дэмждэг | 6.Соёлын орчны нийлбэр индекс |
|---|---|---|---|---|---|---|
| Харах | 60.0 | 93.3 | 93.3 | 6.7 | 100.0 | 6.7 |
| Сонсох | 83.3 | 100.0 | 83.3 | 16.7 | 100.0 | 16.7 |
| Алхах | 54.5 | 81.8 | 100.0 | 18.2 | 90.9 | 18.2 |
| Өөртөө үйлчлэх | | 100.0 | 50.0 | 0.0 | 100.0 | 0.0 |
| Хэл яриа, харилцаа | 0.0 | 0.0 | 100.0 | 0.0 | 100.0 | 0.0 |
| Суралцах | 50.0 | 66.7 | 66.7 | 0.0 | 83.3 | 0.0 |
| Сэргээн санах | 33.3 | 33.3 | 33.3 | 0.0 | 33.3 | 0.0 |
| Анхаарлаа төвлөрүүлэх | 75.0 | 100.0 | 100.0 | 25.0 | 75.0 | 0.0 |
| Орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвар | 66.7 | 66.7 | 66.7 | 0.0 | 83.3 | 0.0 |
| Зан үйлээ хянах | 0.0 | 66.7 | 66.7 | 33.3 | 33.3 | 0.0 |
| Харилцаа холбоо тогтоох | 11.1 | 33.3 | 11.1 | 0.0 | 33.3 | 0.0 |
| Сэтгэл түгших | 54.4 | 74.5 | 88.7 | 7.8 | 91.2 | 6.4 |
| Сэтгэл гутрал | 58.0 | 78.0 | 84.0 | 11.2 | 90.0 | 7.2 |
| Хариулаагүй | 60.0 | 93.3 | 93.3 | 6.7 | 100.0 | 6.7 |

Энэ нь сургуулийн орчинд сэтгэл гутрал, нийгмийн өөрчлөлтөд дасан зохицох чадвар сул, сэтгэл түгших, сэргээн санах, анхаарал төвлөрүүлэх чадварын хүндрэлтэй хүүхдүүд сургууль, анги, үе тэнгийнхэн болон багш нартайгаа харилцахдаа ойлголцол, ойр дотно харилцаа үүсгэж чадахгүй, өөрийгөө илэрхийлэх, бусдын тусламж дэмжлэг авах зэргээр хамтран суралцах чадвар сул, сургуулийн орчинд дасан зохицож чадахгүй байх зэрэг бэрхшээлтэй тулгарч байгааг харуулж байна.

Дараагийн дэд бүлгүүдэд цэцэрлэг болон сургуулийн орчныг тус бүрд нь индикаторуудыг хэмжсэн асуулт бүрийн үр дүнгээр дэлгэрэнгүй авч үзлээ.

### 5.1.1 Сургуулийн орчин дахь тэгш хамруулах соёлын түвшин

Нэгдүгээр шатны илрүүлэх судалгаанаас үйлдлийн ямар нэгэн чадварын хүндрэлтэй болох нь илэрсэн хүүхдүүдийн эцэг эхээс хүүхдийнх нь дараах 2 үндсэн ерөнхий шалгуур үзүүлэлтийн дагуу хүүхдийнх нь сургуулийн орчинтой холбоотой асуултууд тавьсан:

1. Хүүхдийнх нь сургуульд тэгш хамруулсан хамтын соёл төлөвшсөн эсэх
2. Хүүхдийнх нь сургуульд тэгш хамруулсан үнэт зүйл төлөвшсөн эсэх хоёр ерөнхий үзүүлэлтээр тодорхойлсон.

#### 5.1.1.1 Тэгш хамруулсан хамтын соёл бүрдсэн эсэх:

Индексийг тооцохдоо индикатор бүрийн биелэлт хамгийн багадаа нийт тооцогдож байгаа асуултын тооноос нэгээр бага байж болохоор тооцсон. Нийлбэр индекс оноог бүх 5 индикатор бүрэн биелсэн байх утгыг тооцоход нийт судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 7 хувь нь дээрх 5 индикаторт бүгдэд нь эерэг байх хариултыг өгчээ (Хүснэгт 24). Байршлаар нь авч үзвэл Дундговь аймгийн сонгогдсон сургууль хамгийн эерэг үзүүлэлттэй байхад УБ хот болон Дархан-Уул аймгийн сонгогдсон сургуулиудын үзүүлэлт хамгийн бага байна.

Хүснэгт 24. Сургуулийн орчинд хамтын бүлэг бүрдсэн эсэх үзүүлэлт

| | 1.Сургуулийн орчин хүн бүр бие биедээ хүндэтгэлтэй, найрсаг ханддаг гэж хариулсан оролцогчийн хувь | 2.Багш нар хүүхэд бүрийн онцлог тусгай хэрэгцээг харгалзаж хүүхэд бүртэй эелдэг найрсаг харилцдаг гэж хариулсан оролцогчийн хувь | 3.Сургуулийн соёлын орчин хүүхдийг өөрийнхөө боломжийн дээд хэмжээнд бүрэн дүүрэн суралцах боломжийг хангасан аюулгүй орчин | 4.Сургуулийн орчинд хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг | 5.Сургуулийн багш ажилчид бүх хүүхдийг бие биедээ туслахыг дэмждэг | **Соёлын орчны нийлбэр индекс оноо** |
|---|---|---|---|---|---|---|
| Дорнод | 45.7 | 73.9 | 79.3 | 6.5 | 89.1 | 5.4 |
| Дархан | 47.8 | 69.0 | 82.3 | 6.2 | 90.3 | 3.5 |
| Дундговь | 79.7 | 88.6 | 86.1 | 32.9 | 88.6 | 25.3 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хөвсгөл | 50.0 | 83.3 | 77.8 | 5.6 | 83.3 | 5.6 |
| СХД | 56.7 | 77.2 | 86.6 | 6.3 | 88.6 | 3.5 |
| Дорнод | 45.7 | 73.9 | 79.3 | 6.5 | 89.1 | 5.4 |
| **Нийт** | **56.1** | **76.8** | **84.2** | **10.1** | **88.8** | **7.0** |
| **Үйлдлийн чадвараар** | | | | | | |
| Харах | 60.0 | 93.3 | 93.3 | 6.7 | 100.0 | 6.7 |
| Сонсох | 83.3 | 100.0 | 83.3 | 16.7 | 100.0 | 16.7 |
| Алхах | 54.5 | 81.8 | 100.0 | 18.2 | 90.9 | 18.2 |
| Өөртөө үйлчлэх | 100.0 | 100.0 | 50.0 | 0.0 | 100.0 | 0.0 |
| Хэл яриа | 0.0 | 0.0 | 100.0 | 0.0 | 100.0 | 0.0 |
| Суралцах | 50.0 | 66.7 | 66.7 | 0.0 | 83.3 | 0.0 |
| Сэргээн санах | 33.3 | 33.3 | 33.3 | 0.0 | 33.3 | 0.0 |
| Анхаарлаа төвлөрүүлэх | 75.0 | 100.0 | 100.0 | 25.0 | 75.0 | 0.0 |
| Өөрчлөлтөд дасан зохицох | 66.7 | 66.7 | 66.7 | 0.0 | 83.3 | 0.0 |
| Зан авираа удирдах | 0.0 | 66.7 | 66.7 | 33.3 | 33.3 | 0.0 |
| Бусадтай нөхөрлөх | 11.1 | 33.3 | 11.1 | 0.0 | 33.3 | 0.0 |
| Сэтгэлийн түгшүүр | 54.4 | 74.5 | 88.7 | 7.8 | 91.2 | 6.4 |
| Сэтгэл гутрал | 58.0 | 78.0 | 84.0 | 11.2 | 90.0 | 7.2 |
| Судлаачийн ажиглалтаар илэрсэн | 64.0 | 88.0 | 84.0 | 16.0 | 96.0 | 12.0 |

Индикатор тус бүрийн үр дүнг авч үзвэл "Сургуулийн орчинд хүүхдүүд ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг" гэсэн индикатор хамгийн бага үзүүлэлттэй байгаа нь сургуулийн орчинд багш сурагчид, болон үе тэнгийнхэн хоорондын харилцаанд нэгнээ ямар нэгэн ялгаатай байдлаар нь ялгаж хандах байдал түгээмэл байгаа нь ерөнхий индекс оноог бууруулахад нөлөөлж байгаа гол хүчин зүйл болж байна. Хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй хүүхэдтэй эцэг эхчүүд тус индикаторт илүү сөрөг хариултыг өгчээ.

Тус индикаторыг хэмжсэн дэд асуултуудын дан тоололтын үр дүнг харахад хүүхдийн хүйсээс хамааруулан ялгаж хандах тохиолдол харьцангүй бага, харин гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, бусдаас ялгарах бусад байдлаас нь хамааран ялгаж хандах тохиолдол нийт хүүхдийн 16.3 хувьд нь илэрсэн байна (Дүрс 10).

Дүрс 10. Сурагчдыг ялгаж хандах байдал, хувиар (N=565)




### 5.1.1.2 Тэгш хамруулсан үнэт зүйл төлөвшсөн эсэх:

Тус индикаторыг хэмжсэн бүлгүүдээс багш нар хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалзаж ажиллах байдал хамгийн сул байна.

Хүснэгт 25. Тэгш хамруулах үнэт зүйлийн төлөвшлийг хэмжсэн индикаторын үр дүн

| | 1.Багш нар хүүхдэд эрх тэгш хандахыг чухалчилдаг | 2.Сургууль мэргэжлийн өндөр ёс зүйтэй, хүүхдээ даатгаж болохуйц үлгэр жишээ багш нартай | 3.Сургууль нь хүүхдүүдэд маргаан зөрчилдөөнийг эв зүйгээр, хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхийг үлгэрлэдэг | 4.Багш нар хүүхэд бүр ялгаатайг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалзаж ажилладаг | Соёлын орчны нийлбэр индекс оноо |
|---|---|---|---|---|---|
| **Байршлаар** | | | | | |
| Дорнод | 55.4 | 71.7 | 72.8 | 37.0 | 14.1 |
| Дархан | 60.2 | 76.1 | 79.6 | 47.8 | 26.5 |
| Дундговь | 74.7 | 89.9 | 83.5 | 17.7 | 11.4 |
| Хөвсгөл | 50.0 | 61.1 | 61.1 | 44.4 | 11.1 |
| СХД | 61.4 | 75.2 | 81.1 | 30.7 | 15.0 |
| **Нийт** | **61.7** | **76.4** | **79.1** | **33.8** | **16.5** |
| **Үйлдлийн чадвараар** | | | | | |
| Харах | 60.0 | 93.3 | 100.0 | 40.0 | 20.0 |
| Сонсох | 50.0 | 83.3 | 100.0 | 16.7 | 16.7 |
| Алхах | 45.5 | 90.9 | 81.8 | 36.4 | 9.1 |
| Өөртөө үйлчлэх | 100.0 | 100.0 | 100.0 | 0.0 | 0.0 |
| Хэл яриа | 0.0 | 100.0 | 100.0 | 0.0 | 0.0 |
| Суралцах | 83.3 | 66.7 | 83.3 | 16.7 | 16.7 |
| Сэргээн санах | 33.3 | 33.3 | 0.0 | 0.0 | 0.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Анхаарлаа төвлөрүүлэх | 75.0 | 100.0 | 50.0 | 50.0 | 25.0 |
| Өөрчлөлтөд дасан зохицох | 66.7 | 33.3 | 66.7 | 33.3 | 33.3 |
| Зан авираа удирдах | 100.0 | 33.3 | 66.7 | 66.7 | 33.3 |
| Бусадтай нөхөрлөх | 22.2 | 22.2 | 33.3 | 33.3 | 22.2 |
| Сэтгэлийн түгшүүр | 64.2 | 82.8 | 78.9 | 27.5 | 13.7 |
| Сэтгэл гутрал | 62.0 | 72.8 | 80.4 | 39.2 | 17.2 |
| Судлаачийн ажиглалтаар илэрсэн | 60.0 | 84.0 | 88.0 | 44.0 | 32.0 |

Мөн дээрх индикаторуудыг хэмжсэн шалгуур асуултын хувьд эцэг эхчүүд "Мэдэхгүй" гэсэн хариултыг олон өгч байсныг дурдах хэрэгтэй. Энэ үр дүн нь эцэг эхчүүд сургуулийн дотоод амьдрал, сурагчдын хоорондын харилцаа, тэдний аливаа зөрчилтэй холбоотой асуудлуудыг үнэлж мэдэхгүй, сургууль, ангид хүүхдэд нийцтэй сэтгэл зүйн орчин бүрдсэн эсэх талаар мэдээлэл, ойлголтгүй байгааг харуулж байсан юм.

Харин соёлын орчны хувьд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдэд хамгийн таагүй нөлөөлж байгаа үзүүлэлтүүд нь сургуулийн орчинд хүүхдүүдийн "хувийн нууц болон хувийн эд зүйлсэд хүндэтгэлгүй ханддаг", "сургуулийн соёлын орчинд хүүхэд бүрэн аюулгүй гэдэгт эргэлзсэн хариултуудыг өгсөн байна (Дүрс 11).

Дүрс 11. Хүүхдүүд хоорондын хүндэтгэлтэй харилцаа, хувиар (N=520)



Соёлын орчны индексийг дүгнэвэл үйлдлийн чадварын хувьд хэл ярианы бэрхшээлтэй, өөртөө үйлчлэх чадвар сул, өөрчлөлтөд дасан зохицохдоо удаан, аливаа зүйлийг тогтоох, сэргээн санахдаа хүндрэлтэй хүүхдүүд **сургуулийн орчинд ялгаварлан гадуурхагдах**, **багш тухайн хүүхдийн тусгай хэрэгцээг сургалтын арга барилдаа харгалзаж ажиллах байдал хангалтгүй** байна.

Судалгаанд оролцсон үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн дунд харьяа орон нутгийнхаа ЕБС-д үе тэнгийн хүүхдүүдтэйгээ хамт амжилттай суралцан хичээллэж байгаа хүүхдүүд мөн олон байсан. Гэсэн хэдий ч нийтлэг багш нар үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийг үл тоох, ялгавартай хандах, төвөгшөөх, гадуурхах байдлаар сөрөг хандлага гаргадаг нь ярилцлагуудаар мөн илэрч байсан юм.

Шигтгээ 2.ХБХ-ийн ээжтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас. Орхон аймаг

| Багш нар танай хүүхэдтэй хэрхэн ажиллаж байна вэ? |
|---|
| ... Нийтэд нь хүүхдүүдээ хамруулаад заадаг болохоор тэр болгон очоод заагаад байх нь ховор. Харин биеийн тамирын багш нь харьцангуй сайн мэддэг учир арай өөр байдаг. Дунд ангид орохоор багш нар нь солигдоод олон багш ордог. Математикийн багш нь яаж юм сурах юм бэ, юм заа л даа гэж байнга хэлдэг. Өөр тусгай газар луу нь явуул л даа гэж байнга хэлдэг. Багштай нь уулзаж ярилцаж үзсэн ч ерөөсөө эергээр хүлээж аваагүй. |
| Сургалт хөтөлбөр явуулахад, шалгалтад хэцүү байна гэж удаа дараа хэлж байсан. Хүүхдэд маань хэцүү байдаг. Миний зүгээс багшид нь хүүхэд маань цаашид тоо бодож чадахгүй, тиймээс чадаад байгаа юман дээр дэмжээд түүгээр нь дүнг нь гаргаж болохгүй юм уу гэхээр улсын шалгалт шүү дээ, болохгүй, заавал сурах ёстой гэх мэтээр дургүйцлээ илэрхийлдэг. |

Соёлын орчныг хэмжсэн индикатор, түүнийг шалгасан шалгуур асуулт бүрийг авч үзвэл нийт судалгаанд хамрагдсан үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн 5-7 орчим хувь нь сургууль дээрээ найз нөхөдгүй, сургуульдаа явах дургүй байгаа нь анхаарал татахуйц үр дүн байв.

### 5.1.2 Цэцэрлэг дэх тэгш хамруулсан соёлын орчин

Цэцэрлэгийн түвшинд тэгш хамруулсан соёлын орчин бүрдсэн эсэхийг аргачлалын хувьд сургуулийнхтай ижил аргаар тооцсон. Нийт зорилтот аймаг, дүүргийн цэцэрлэгийн 2-5 насны хүүхдийн 110 эцэг эх, асран хамгаалагч нараас мэдээлэл авч цэцэрлэгийн соёлын орчны талаарх үнэлгээг хийсэн болно.

#### 5.1.2.1 Тэгш хамруулсан хамтын соёл бүрдсэн эсэх:

Нийлбэр индекс оноог бүх 5 индикатор бүрэн биелсэн байх утгыг тооцоход нийт судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 50 хувь нь дээрх 5 индикаторт бүгдэд нь эерэг байх хариултыг өгчээ (Хүснэгт 26). Байршлаар нь авч үзвэл Хөвсгөл, Дундговь аймгийн сонгогдсон цэцэрлэг хамгийн эерэг үзүүлэлттэй байхад УБ хот болон Дорнод аймгийн сонгогдсон цэцэрлэгийн үзүүлэлт арай бага байна.

Хүснэгт 26. Цэцэрлэгийн орчинд хамтын бүлэг бүрдсэн эсэх үзүүлэлт

| | 1.Цэцэрлэгийн орчинд хүн бүр бие биедээ хүндэтгэлтэй, найрсаг ханддаг | 2.Багш нар хүүхэд бүрийн онцлог тусгай хэрэгцээг харгалзаж хүүхэд бүртэй эелдэг найрсаг харилцдаг | 3.Сургуулийн соёлын орчин хүүхдийг өөрийнхөө боломжийн дээд хэмжээнд бүрэн дүүрэн суралцах боломжийг хангасан аюулгүй орчин | 4.Сургуулийн орчинд хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг | Соёлын орчны нийлбэр индекс оноо |
|---|---|---|---|---|---|
| Дорнод | 50.0 | 38.9 | 50.0 | 33.3 | 22.2 |
| Дархан | 61.9 | 47.6 | 61.9 | 61.9 | 47.6 |
| Дундговь | 62.5 | 75.0 | 75.0 | 62.5 | 62.5 |
| Хөвсгөл | 66.7 | 66.7 | 66.7 | 66.7 | 66.7 |
| СХД | 56.9 | 39.2 | 52.9 | 33.3 | 29.4 |
| **Нийт** | **57.4** | **44.6** | **56.4** | **42.6** | **35.6** |
| **Үйлдлийн чадвараар** | | | | | |
| Харах | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 |
| Сонсох | 50.0 | 0.0 | 50.0 | 0.0 | 0.0 |
| Алхах | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Жижиг булчин | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хэл яриа | 33.3 | 0.0 | 33.3 | 0.0 | 0.0 |
| Суралцах | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 |
| Тоглох | 38.5 | 15.4 | 30.8 | 23.1 | 15.4 |
| Зан авирын өөрчлөлт | 50.0 | 45.5 | 52.3 | 43.2 | 34.1 |

Үйлдлийн чадварын хүндрэлийн төрлөөр ялгааг харахад цэцэрлэгийн орчинд **сонсох, алхах, хэл ярианы хүндрэлтэй хүүхдүүдийн** хувьд соёлын орчин хамгийн таагүй дүгнэгджээ.

Индикатор тус бүрээр нь авч үзэхэд цэцэрлэгийн орчинд хүүхдүүд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг эсэх үзүүлэлт нь хамгийн бага үзүүлэлттэй гарчээ.

Индикатор тус бүрийг хэмжсэн асуултуудаас харахад хүүхдүүд өнгөрсөн хичээлийн жилд цэцэрлэгтээ дуртай явсан, багш нар нь хүүхдийн хөгжлийн ахиц, амжилтыг магтан урамшуулж, хүүхдүүд нь цэцэрлэгийнхээ багшид дуртай байсан гэж 80 хувиас дээш хувьтай хариулсан нь бага насны хүүхдүүдийн хувьд сайн үзүүлэлт байна. Судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн багш нар хүүхэдтэй зөв, хүндэтгэлтэй харилцах байдал, хүүхдийн гэр бүлийн уламжлал, хэл соёлд хүндэтгэлтэй хандах байдал зэрэгт 70-аас дээш хувьтай байгаа нь дундаж үзүүлэлт юм. Энэ нь багш нар харилцааны ур чадвар болон мэргэжлийн ур чадвараа илүү сайжруулан хүүхдэд ээлтэй харилцаа хандлагыг ажилдаа хэвшүүлэх шаардлагатайг харуулж байна. Цэцэрлэгийн орчинд хүүхэд нь бүрэн аюулгүй гэдэгт эцэг эхчүүдийн 20 хувь нь эргэлзэж байна. СӨББ-ын орчинд бүх хүүхдийг тэгш хамруулах соёлын орчны төлөвшсөн байдал дунд түвшинд байна гэж дүгнэж байна.

Хүснэгт 27. Цэцэрлэгийн соёлын орчныг илтгэх шалгуур асуултуудын үр дүн

| | Цэцэрлэгийн соёлын орчин (N=110) | | | |
|---|---|---|---|---|
| | **Ээлтэй, найрсаг орчин** | Тийм | Үгүй | Мэдэхгүй |
| 1 | Цэцэрлэгийн багш, ажилчид танай хүүхдийн гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, бусдаас ялгаатай байдлаас үүдэн ялгаж хандах тохиолдол гардаг уу? | 13.5 | 85.1 | 1.5 |
| 2 | Танай хүүхэд өнгөрсөн хичээлийн жилд цэцэрлэгтээ явахдаа хэр дуртай байсан бэ? | 83.6 | 16.4 | 0 |
| 3 | Танай хүүхдийн гаргасан ахицыг цэцэрлэгийн багш нар хэр зэрэг магтаж, урамшуулдаг вэ? | 83.5 | 13.5 | 3.0 |
| 4 | Танай хүүхэд цэцэрлэгийнхээ багшид хэр дуртай вэ? | 82.0 | 12.0 | 6.0 |
| 5 | Цэцэрлэгийн багш ажилчид танай хүүхэдтэй зөв хүндэтгэлтэй харилцдаг уу? | 79.1 | 7.5 | 13.4 |
| 6 | Цэцэрлэгийн орчинд танай хүүхэд бүрэн аюулгүй гэдэгт та итгэлтэй байж чаддаг уу? | 77.7 | 20.9 | 1.5 |
| 7 | Цэцэрлэгийн багш ажилчид танай хүүхдийн хэл соёлд хүндэтгэлтэй ханддаг уу? | 76.2 | 6.0 | 17.9 |
| 8 | Танай хүүхэд цэцэрлэг дээрээ хэр зэрэг найз нөхөдтэй бэ? | 76.1 | 10.5 | 13.4 |
| 9 | Багш ажилчид танай гэр бүлийн уламжлалт ёс заншилд хүндэтгэлтэй ханддаг уу? | 73.2 | 1.5 | 25.4 |
| 10 | Багш нар танай хүүхдийг элдэв нэр хочтой болохоос хамгаалдаг уу? | 59.7 | 9.0 | 31.3 |

### 5.1.2.2 Тэгш хамруулсан үнэт зүйл төлөвшсөн эсэх:

Хүснэгт 28. Тэгш хамруулсан үнэт зүйлийн төлөвшлийг хэмжсэн индикаторын үр дүн

| | 1. Багш нар хүүхдэд эрх тэгш хандахыг чухалчилдаг | 2.Сургууль мэргэжлийн өндөр ёс зүйтэй, хүүхдээ даатгаж болохуйц үлгэр жишээ багш нартай | 3.Сургууль нь хүүхдүүдэд маргаан зөрчилдөөнийг эв зүйгээр, хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхийг үлгэрлэдэг | 4.Багш нар хүүхэд бүр ялгаатайг хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагаандаа харгалзаж ажилладаг | Соёлын орчны нийлбэр индекс оноо |
|---|---|---|---|---|---|
| **Байршлаар** | | | | | |
| Дорнод | 44.4 | 50.0 | 33.3 | 22.2 | 11.1 |
| Дархан | 42.9 | 52.4 | 47.6 | 42.9 | 14.3 |
| Дундговь | 50.0 | 75.0 | 62.5 | 37.5 | 37.5 |
| Хөвсгөл | 33.3 | 66.7 | 66.7 | 33.3 | 33.3 |
| СХД | 39.2 | 52.9 | 51.0 | 33.3 | 25.5 |
| **Нийт** | **41.6** | **54.5** | **48.5** | **33.7** | **21.8** |
| **Үйлдлийн чадвараар** | | | | | |
| Харах | 50.0 | 50.0 | 50.0 | 0.0 | 0.0 |
| Сонсох | 50.0 | 50.0 | 50.0 | 0.0 | 0.0 |
| Алхах | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Жижиг булчин | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хэл яриа | 33.3 | 33.3 | 33.3 | 16.7 | 16.7 |
| Суралцах | 50.0 | 50.0 | 50.0 | 0.0 | 0.0 |
| Тоглох | 23.1 | 30.8 | 23.1 | 15.4 | 7.7 |
| Зан авирын өөрчлөлт | 29.5 | 50.0 | 45.5 | 22.7 | 15.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Судлаачийн ажиглалтаар илэрсэн | 62.5 | 75.0 | 62.5 | 62.5 | 37.5 |

Үнэт зүйлийн төлөвшлийн хувьд цэцэрлэгийн орчинд ихэнх индикатор хангалтгүй дүгнэгдсэн.

Судалгааны хүрээнд цэцэрлэгийн соёлын орчныг үнэлэхдээ багш ажилтнуудын харилцаанд илэрч байгаа тэгш байдал, харилцааны үнэт зүйлүүдийг үнэлүүлсэн. Энэ үр дүнг авч үзвэл:

1. Цэцэрлэгийн багшийн ёс зүйд итгэх итгэл 85.1%
2. Багш нар хүүхдийг бусад хүүхэдтэй эв найртай харилцахад сургах байдал 85.0% гарчээ.

Харин хүүхдүүдийн аливаа зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэх чадвар, хүүхдэд эерэг үлгэр дуурайлал үзүүлэх, хүүхдийн хувийн онцлогт тохируулан дэмжин ажиллах чадварыг эцэг эхчүүд 73-77 хувьтай байна гэж хариулсан нь цэцэрлэгийн багш нар мэргэжлийн болон харилцааны чадвараа сайжруулах хэрэгтэйг харуулж байна. Багш нар хүүхдүүдийг бусадтай нь жишиж харьцуулах нь их байгаа нь хүүхдийн хувийн онцлогийг олж харан хөгжүүлэхэд саад болох хүчин зүйл юм.

Хүснэгт 29.Цэцэрлэгийн соёлын орчин (n=110)

| | Үнэт зүйл | Тийм | Үгүй | Мэдэхгүй |
|---|---|---|---|---|
| 1 | Хүүхдийн тань багш мэргэжилтний хувьд ёс зүйтэй багш мөн эсэх | 85.1 | 4.5 | 10.4 |
| 2 | Цэцэрлэгийн багш нар хүүхэдтэй эелдэг, зөв харилцдаг эсэх | 85.0 | 6.0 | 9.0 |
| 3 | Цэцэрлэгийн багш нар хүүхдийг аливаа зөрчил маргааныг эв зүйгээр шийдвэрлэх чадвартай эсэх | 77.6 | 6.0 | 16.4 |
| 4 | Цэцэрлэгийн багш нар хүүхдэд эергээр үлгэр дуурайлал үзүүлж чаддаг эсэх | 76.1 | 3.0 | 20.9 |
| 5 | Багш, ажилчид хүүхдийн онцлог, бусдаас ялгаатай байдлыг нь ойлгож, дэмжиж ажилладаг эсэх | 73.1 | 17.9 | 9.0 |
| 6 | Цэцэрлэгийн багш нар бүх хүүхдэд адил тэгш ханддаг эсэх | 65.7 | 16.4 | 17.9 |
| 7 | Багш нар танай хүүхдийн хүмүүжлийг бусад үе тэнгийн хүүхдүүдтэй жишиж харьцуулдаг эсэх | 31.3 | 49.3 | 19.4 |
| 8 | Багш нар танай хүүхдийн сурлагын ахицыг үе тэнгийн бусад хүүхдүүдтэй жишиж харьцуулдаг эсэх | 28.4 | 53.7 | 17.9 |

Тэгш хамруулсан соёлын орчин бүрдсэн эсэхийг төслийн зорилтот цэцэрлэг, сургуулийн хүрээнд үнэлэхэд сургуулийн хувьд соёлын орчин хангалтгүй, цэцэрлэгийн хувьд бий болж байгаа үр дүнг индекс тооцоо харууллаа. Газарзүйн байршлаар авч үзвэл соёлын хоёр үзүүлэлт хоёуланд нь Дундговь аймгийн цэцэрлэг, сургууль бусдаасаа илүү эерэг үр дүнг үзүүлж байна.

**Үйлдлийн чадварын хүндрэлийн хувьд цэцэрлэгт илүү бие махбодын бэрхшээлүүд болох хараа, сонсгол, хөдөлгөөн, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд соёлын орчны таагүй нөлөөллийг мэдэрдэг бол сургуулийн хувьд бусадтай нөхөрлөх, харилцаа холбоо тогтоох,**

**суралцах, аливаа зүйлийг тогтоох, сэргээн санах зэрэг танин мэдэхүй, харилцааны чадвар султай хүүхдүүд соёлын орчны таагүй нөлөөллийг мэдэрч байна.**

Тэгш хамруулсан соёлын орчныг хэмжсэн индикаторуудын хувьд цэцэрлэг, сургууль аль алинд нь хүүхдийг гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, бусдаас ялгаатай байдлаас нь үүдэн ялгаж хандах байдал хамгийн өндөр үзүүлэлттэй. Мөн тэдгээр хүүхдүүдийн онцлог тусгай хэрэгцээг сургалтын арга барил, багшлах аргазүйд бүрэн харгалзаж ажиллаж чаддаггүй болохыг судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд онцолжээ.

## 5.2 Боловсролын бодлогын орчин

Энэхүү бүлгийн эхэнд тэгш хамруулах боловсролыг дэмжсэн үндэсний хууль эрхзүйн баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн дүрэм, журам, тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг баримт бичгийн шинжилгээнд үндэслэн тоймлон авч үзсэн. Мөн индекс оноог тооцох зорилгоор судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд болон багш нарын санал бодолд үндэслэн төслийн зорилтот цэцэрлэг, сургуулийн дотоод бодлогын орчин тэгш хамруулах боловсролыг дэмжиж буй эсэхийг үнэлсэн.

### 5.2.1 Хууль, бодлогын баримт бичигт хийсэн шинжилгээ

Юуны өмнө тэгш хамруулан сургах боловсролыг дэмжих чиглэлээр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн баримт бичгүүдийг судалсан. Эдгээр хуулиудтай судалгааны үр дүнг холбон үзье.

**Боловсролын тухай хууль.** 2006 онд батлагдсан нэмэлт өөрчлөлтөөр 5.1.4-д "Иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана" гэж заасан. Тус судалгаанд хамрагдсан сургуульд сурдаг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн 3 хувь нь хүүхдийг анх сургуульд элсэн ороход нээлттэй хүлээж аваагүй гэж хариулсан бол цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эхийн 9 хувь хүлээж аваагүй гэж хариулсан байна. Тус судалгаанд хамрагдсан сургуульд сурдаг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн 12.6 хувь нь хүүхдэд нь сургуулийн дотоод дүрэм журмыг мөрдөхөд нь ямар нэгэн хүндрэл гарч байна гэж хариулсан бол, цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эхийн 19.4 хувь нь хүндрэл гардаг гэж хариулжээ.

**Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль.** Тус хуульд 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд хөнгөн хэлбэрийн ХБХ-ийг ердийн бүлэгт сургах тухай, цэцэрлэгийн багш ХБХ-тэй ажиллавал нэмэгдэл цалин олгох тухай зэрэг тэгш хамруулах боловсролыг дэмжсэн зохицуулалтууд орсон. Судалгааны үр дүнгээр цэцэрлэгт сурдаг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэдтэй нийт эцэг эхчүүдийн 28.4 хувь цэцэрлэгийн зүгээс эцэг эхчүүдэд цэцэрлэгийн бодлого, үнэт зүйлийн талаар мэдээллийг өгдөг гэж хариулсан. Тус бүлгийн 14.9 хувь нь цэцэрлэгийн үүд, хүлээлгийн өрөө зэрэгт цэцэрлэгийн баримталж ажилладаг бодлого, үнэт зүйлийн талаар мэдээлэл байдаг гэж хариулсан байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (ХБХЭТХ).** Тус хуульд ХБХ-ийг "Бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй, бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ" гэж заажээ. Судалгааны үр дүнгээс дурдвал зарим аймгууд өөрийн орон нутгийн хүний нөөц, хөрөнгө санхүүд түшиглэн ердийн сургууль, цэцэрлэгийн дэргэд тусгай анги, бүлэг нээн хичээллүүлж байгаа сайн туршлага байна. НТБТ-д дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж байгаа ХБХ байгаа ч, тэдгээр хүүхдүүдийг ердийн сургууль руу шилжүүлэн сургах талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа хангалтгүй байна.

ХБХЭТХ-ийн 16.2 заалтад "бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна" гэсэн хэдий ч бидний авсан судалгааны үр дүнгээс харвал "хөгжлийн бэрхшээлийн" талаар нийгмийн ажилтнууд, багш нарын хооронд ч ойлголтын зөрүү ажиглагдаж байлаа. Зарим аймагт Боловсрол соёл урлагийн газарт ХБХ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй байхад зарим аймагт бага боловсрол хариуцсан мэргэжилтэн нь давхар хариуцан ажилладаг байдалтай байна. Багш нар ХБХ-ийг ЕБС-д хамруулахад тулгамдаж буй хүндрэл бэрхшээлд мэргэжлийн бэлтгэгдсэн багш, хүний нөөц дутмаг, төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, багшийн урамшуулал байхгүй, судалгаанд суурилсан тохирсон хөтөлбөр дутмаг, арга зүй байхгүй зэрэг хүндрэл бэрхшээлүүдийг нэрлэж байна.

ХБХЭТХ-ийн 37.2.1-д "0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг ХБХ-ийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тогтооно" гэжээ. Мөн "ХБХ-дэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх зааврыг" 2018 оны 11-р сарын 15-ны өдрийн ХНХ, БСШУС, ЭМ сайд нарын хамтарсан тушаалаар баталсан. Уг тушаалын 4.2.1—т "Салбар комисс нь тухайн бүс нутагт амьдарч байгаа хүүхдийн бэрхшээлтэй эсэхийг тогтооно" гэсэн боловч 4.3.3-т нь "...онош тодорхой бус хүүхэд салбар комиссын хуралдаанд оролцох боломжгүй..." гэж заасан нь зөвхөн эмчийн онощд үндэслэн хүүхдийн "хөгжлийн бэрхшээлийг" тодорхойлоход хүргэж байна. Энэ нь хүүхдийг бэрхшээлийг зөвхөн өвчин, согог талаас нь харж тодорхойлох буюу эрүүл мэндийн байгууллагаар оношлогдоогүй хүүхдүүдэд тусгай боловсролын үйлчилгээг авах боломжийг хязгаарлаж байгаа юм.

БСШУС-ын сайдын 2019 оны 5-р сарын 14-нд батлагдсан А/292 тушаалын дагуу "ХБХ-ийг ЕБС-д тэгш хамран сургах журам"-д "Сургууль нь ХБХ-ийн боловсролын ялгаатай хэрэгцээг тодорхойлох, дасан зохицоход нь дэмжлэг үзүүлж ГСТ боловсруулж хэрэгжүүлэх, засан сайжруулах, зөвлөгөө өгөх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ" гэж заасан. Мөн түүнчлэн "ХБХ-эй ажиллаж байгаа багшид хүүхдийн ахиц, үр дүнг тооцон урамшуулал олгох асуудлыг сургуулийн дотоод дүрэм, хөдөлмөрийн гэрээнд тусган шийдвэрлэнэ" гэсэн заалтууд нь ХБХ-ийн оношилгоо үнэлгээ хийх стандарт, арга аргачлал тодорхой бус байгаатай холбоотой хэрэгжихэд бэрхшээлтэй байгааг асуудал хариуцсан багш нар ярьж байлаа.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2018-2022).** Зорилт 2-д хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны боловсролд тэгш хамруулна, зорилт 3.2.1.1-д ХБХ-ийн боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа одоогийн нөхцөл байдлын судалгааг үндэсний хэмжээнд хийх гэж заасан байна. Мөн зорилт 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэнэ гэж заасан бөгөөд шалгуур үзүүлэлтийг нь "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын хурлаар хөгжлийн бэрхшээлийг тогтоосон хүүхдийн эзлэх хувь" гэж заасан байна. Гэвч Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Хөгжлийг Дэмжих Ерөнхий газар нь байгуулагдаад удаагүй (2018) байгаа учраас дээр дурдсан бодлогын зорилтууд, мөн индикаторуудыг тайлагнасан мэдээ гараагүй байна. Тус судалгаанд хамрагдсан хүмүүсийн 10.8 хувь нь тэдний хүүхэд сургууль дээр нь төрөөс зохион байгуулж байгаа ямар нэг төсөл

хөтөлбөрт хамрагдсан гэсэн бол, цэцэрлэгт хүүхэд нь сурдаг эцэг эхчүүдийн 18.3 хувь нь мөн хамрагджээ. Тус судалгаанд хамрагдсан хүмүүсийн 26.3 хувь нь тэдний хүүхэд олон улсын байгууллагын ямар нэгэн тусламж, хөтөлбөрт хамрагдсан гэж хариулсан бол, цэцэрлэгт хүүхэд сурдаг эцэг эхчүүдийн 6 хувь тийм гэж хариулжээ.

Тэгш хамруулах боловсрол нь үндэсний цөөнх хүүхдүүдийн боловсрол, эх хэл ба албан ёсны хэлний сургалтын чадавхыг сайжруулахад мөн чиглэдэг. МУЗГ-ын зүгээс үндэсний цөөнх хүүхдүүдийн боловсролын үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор доор дурдсан тогтоолуудыг гаргажээ.

**Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай.** 2010 онд ЗГ-ын 66-р тогтоолоор баталсан, агуулга нь "Боловсролын хүрээлэнгийн бүтцэд казах хүүхдийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх чиг үүрэг бүхий сектор байгуулж, бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон санхүүжүүлэх", "Казах хэл дээр сургалт явуулдаг ЕБС-ийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хянаж, казах болон монгол хэл судлах цагийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох замаар сургалтын чаналыг сайжруулах арга хэмжээ авах" зэрэг болно. 2018 оны НҮТС-гаар нэгдүгээр ангид сурч байгаа, өмнөх хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан хүүхдийн хувь 85 хувьтай, үүнээс энэ үзүүлэлт нь казах хүүхдүүдийн хувьд 59 хувь буюу хамгийн бага байна. Чухам тийм учраас нийт 6 настай хүүхдүүдээс 1-р ангид элссэн хүүхдийн хувь улсын хэмжээгээр 92 хувь байхад казах хүүхдүүд 80.4 хувь буюу хамгийн бага байна. Бага боловсрол эзэмшвэл зохих насны нийт хүүхдүүдээс бага боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн улсын дундаж нь 97 хувь байхад казах хүүхдүүд 93.6 хувь буюу мөн хамгийн бага байна. Гагцхүү дунд боловсрол эзэмшвэл зохих насны нийт хүүхдүүдээс дунд боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн улсын дундаж нь 93 хувьтай байхад казах хүүхдүүд 92.1 хувь байна.

Хүснэгт 30. Баян-Өлгий аймгийн мэдээлэл

| № | Баян-Өлгий[12] | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|
| 1. | Бага ангид хамрагдсан нийт хүүхдийн тоо | 10513 | 10483 | 10824 | 11025 |
| 2. | Үүнээс ХБХ | 199 | 157 | 138 | 104 |
| 3. | Дунд ангид хамрагдсан нийт хүүхдийн тоо | 6697 | 7037 | 7865 | 7887 |
| 4. | Үүнээс ХБХ | 156 | 138 | 144 | 121 |
| 5. | Ахлах ангид хамрагдсан нийт хүүхдийн тоо | 5416 | 5071 | 4373 | 4280 |
| 6. | Үүнээс ХБХ | 133 | 92 | 94 | 76 |

Зөвхөн Баян-Өлгий аймгийн жишээн дээр үзэхэд бага ангид хамрагдсан нийт хүүхдийн тоонд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй байхад бага ангид суралцдаг ХБХ-ийн тоо бараг хоёр

[12] *Боловсролын Хэлтсийн мэргэжилтэн М.Сержанаас авсан мэдээлэл 2019-08-12*

дахин багассан байна. Мөн дунд ба ахлах ангид суралцаж байгаа ХБХ-ийн тоо ч гэсэн багассан үзүүлэлт харагдаж байна.

**Цаатан иргэдийн талаар авах арга хэмжээний тухай.** 2018 оны ЗГ-ын 213-р дугаар тогтоол нь "Үндэсний цөөнхийн түүх, ёс заншил, өв соёлыг хадгалж үлдэх, эх хэлээрээ суралцах эрхийг хангах зорилгоор тува хэлний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тува хэлний багш нар бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах арга хэмжээ авна" гэж заажээ. Энэ тогтоол хэрэгжихэд тува хэлний сурах бичиг гаргах, судалгааны ажлыг дэмжих зэрэг ажлууд хийгдэж байна.

### 5.2.2 Яамны бодлого шийдвэр, арга хэмжээ

**Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах журам**. БСШУСЯ-аас 2018 оны 3-р сарын 29-нд А/155 тоот тушаалаар "Үлгэрчилсэн загвар, аргачлал батлах тухай" тушаалын нэгдүгээр хавсралтаар Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)-ний загвар, хоёрдугаар хавсралтаар ГСТ (Individual Development Plan) боловсруулах аргачлалыг тус тус баталсан. Энэхүү төлөвлөгөө нь хүүхдийн хөгжлийн бодит байдалд тулгуурлан сургуулийн болон гэрийн орчинд тухайн хүүхэдтэй ажиллах сургалтын агуулга, багшийн болон мэргэжилтний арга зүй, дэмжлэгийн тогтолцоог тодорхойлж хэрэглэх зорилготой. Мөн суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, түүний хөгжлийг дэмжсэн байх үүднээс боловсруулжээ. ГСТ нь 2018-2019 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд сургууль бүр дээр ХБХ дээр ийм төлөвлөгөөг гарган ажиллаж эхлээд байна. Гэвч энэ нь бүрэн жигдрээгүй, нөгөө талаас багш нарын зүгээс энэхүү төлөвлөгөөг гаргах мэдлэг, чадвар, туршлага дутагдаж байна.

**ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам.** БСШУСЯ-аас 2018 оны 6-р сард А/425 дугаар тушаалаар ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмыг боловсруулж баталсан. Улмаар 2018-2019 оны хичээлийн жилээс хэрэглэж эхэлсэн. Үнэлгээний журамд нь "хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ГСТ, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ" гэж заасан. Улмаар "суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ" гэж заажээ. Чухам үүнээс харахад энэхүү журам нь өмнөхтэй харьцуулбал тэгш хамран сургахтай холбоотой суралцагчийг ахицаар үнэлэх уян хатан зохицуулалт хийж өгснөөрөө ихээхэн дэвшилттэй байна.

Цаашид багш нарыг уян хатан үнэлэхтэй холбоотой мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх, туршлагыг нь нэмэгдүүлэх, мөн тодорхой арга, аргачлалаар хангах, сургалтад хамруулах шаардлагатай байна. Судалгаанд хамрагдсан нийт багш нарын 63.2 хувь нь ХБХ-ийн сургалтын амжилтыг үнэлэх системтэй арга хэмжээ дутмаг байна гэж хариулжээ.

Тэгш хамруулах боловсрол, ХБХ-тэй холбоотой хэд хэдэн журам сүүлийн жилүүдэд УИХ ба ЗГ-аас батлагдсан. Тэдгээрийг товч дурдвал:

**Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам.** МУЗГ-аас 2012 оны 5-р сард ЗГ-ын А/185-р тогтоолыг гаргасан. Энэ

тогтоолын 3.2-д "хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад санхүүжилт олгохдоо нэг суралцагчийн хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцно" гэж заагаад мөн 3.3-д "энэхүү журмын 3.2 дахь заалт ХБХ-д сургаж байгаа ердийн цэцэрлэг, сургуульд нэгэн адил хамаарна" гэж заажээ. Үүнээс харахад ХБХ суралцаж байгаа ердийн цэцэрлэг, сургуулиуд санхүүжилтээ авахдаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлж тооцож болно. Гэвч энэ заалт нь 2019 оны хаврын хичээлийн жилийг дуустал хэрэгжээгүй байгаа билээ.

**Бага, Дунд, Бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам.** 2018 оны 4-р сард БСШУЯ-аас уг журмыг А/168 дугаартай тушаалаар баталсан. Уг журам нь НТБТ-ийн үндсэн баримт бичиг бөгөөд 1.2-д "Албан боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй сургуулийн насны хүүхдэд суурь боловсрол заавал олгох, бүх нийтийн ерөнхий боловсрол нөхөн эзэмших, бие даан суралцах хүсэлтэй иргэдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол эзэмшүүлэх харилцааг энэхүү журмаар зохицуулна", 1.3-д "Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй, хэлбэр, хугацаа нь суралцагчдын боловсрол эзэмших хэрэгцээ, боломж, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн, олон хувилбартай, уян хатан, чөлөөтэй, нээлттэй байна" гэж заагаад мөн 1.4-д "Сургуульд огт суугаагүй, хоёр ба түүнээс дээш жил завсардсан иргэнийг дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулна" гэжээ. НТБТ нь сургууль завсардсан болон ХБХ-ийг сургах ажлыг давхар хариуцдаг учраас суралцагчийн хэрэгцээ, онцлогт нь тохирсон уян хатан байх боломжтой гэдгээрээ онцлогтой байна.

**ХБХ-ийг ЕБС-д тэгш хамран сургах журам.** БСШУС-ын яамнаас 2019 оны 5-р сард уг журмыг баталсан. Журамд хүүхдийг тэгш хамран сургахтай холбоотой дэмжлэгийн багийг байгуулах, орчныг бүрдүүлэх, хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн арга зүй, арга барилаар хичээл заах, тусгай сургуулиудтай хамтарч ажиллах, эцэг эхтэй хамтарч ажиллах, үе тэнгийнхний дэмжлэгийн хөдөлгөөн өрнүүлэх, ХБХ-дэд зориулсан нэмэлт сургалтуудыг зохион байгуулах, "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим" байгуулах, эдгээр арга хэмжээг авахтай холбоотой зардлыг сургалтын байгууллагын жил бүрийн төсөвт суулгах зэрэг маш тодорхой, олон шинэ зохицуулалтуудыг оруулжээ.

**"Сургууль хамрагдалтыг дэмжих зөвлөл[13]".** ХНХЯ, БСШУС, ЭМЯ-ны хамтарсан тушаалаар 2018 оны 11-р сард "ХБХ-д хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар"-ыг боловсруулан баталсан. Энэ зааврын нэг хэсэгт сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг байгуулж ажиллуулах талаар заасан. ХБХ-ийг сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилготой зөвлөлийг сум, хороонд байгуулах бөгөөд сургууль дотор дэмжлэгийн баг байгуулна. Баг нь бусад сурагчид, тэдний эцэг эхийн ойлголт, оролцоог дээшлүүлэх зорилготой. Тус зөвлөлд сургуулиас сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн эмч, хүүхдийн асран хамгаалагч нар орох боломжтой байна.

---

[13] https://www.legalinfo.mn/annex/details/8825?lawid=13811

### 5.2.3 Бодлогын орчны эцэг эх ба багш нарын үнэлгээ

Тэгш хамруулах боловсролын орчин төслийн зорилтот цэцэрлэг сургуульд бүрдсэн эсэхийг индекс үзүүлэлтээр тооцох зорилгоор үйлдлийн чадварын хүндрэлтэй болох нь илэрсэн хүүхдүүдийн эцэг эхчүүдээс хүүхдийнх нь цэцэрлэг, сургуулийн дотоод бодлогын орчинг үнэлүүлсэн. Сургуулийн дотоод бодлогын орчны талаар эцэг эхчүүдээс гадна багш нар илүү сайн мэдээлэлтэй байх тул зорилтот цэцэрлэг, сургуулийн багш нарын хариултыг энэ хэсэгт мөн авч үзэв.

Цэцэрлэгт хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах бодлого хэрэгжиж буй эсэхийг доор дурдсан дөрвөн индикатораар, харин сургуульд тэгш хамруулан сургах бодлого хэрэгжиж буй эсэхийг зургаан дэд индикаторын үр дүнгээр хэмжив.

Тэгш хамруулсан бодлогын орчин бүрдсэн эсэхийг индекс болгон тооцохдоо тодорхойлсон индикаторуудын биелэлт тухайн боловсролын байгууллагад 40-өөс бага бол тэгш хамруулсан бодлогын орчин хангалттай бүрдээгүй, 40-60 бол бий болж байгаа, 60-80 сайжруулах шаардлагатай, 80-аас их бол хангалттай бүрдсэн гэсэн шкалаар тооцсон.

Хүснэгт 31. Цэцэрлэгийн орчин дахь бодлогын орчны индекс үзүүлэлт, эцэг эх/асран хамгаалагчийн хариултаар

| | 1.Сургуулийн дотоод тэгш хамруулах бодлого, үнэт зүйлийн талаар багш, сурагч, эцэг эхчүүдэд тогтмол мэдээлэл өгдөг | 2.Хамран сургах тойргийн бүх хүүхдүүдийг сургууль хүлээн авдаг | 3.Сургууль хүүхэд нэг бүрийг үр дүнтэй сургах уян хатан бодлогын орчинтой | 4.Хүүхдийг үр дүнтэй сургахын тулд бусад байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажилладаг | Бодлогын орчны нийлбэр индекс оноо |
|---|---|---|---|---|---|
| Дорнод | 38.9 | 55.6 | 38.9 | 16.7 | 11.1 |
| Дархан | 61.9 | 61.9 | 38.1 | 14.3 | 9.5 |
| Дундговь | 75.0 | 75.0 | 62.5 | 25.0 | 25.0 |
| Хөвсгөл | 66.7 | 66.7 | 33.3 | 0.0 | 0.0 |
| УБ-СХД | 45.1 | 54.9 | 45.1 | 23.5 | 23.5 |
| **Нийт** | **50.5** | **58.4** | **43.6** | **19.8** | **17.8** |

80-100 Хангагдсан
60-79 Сайжруулах шаардлагатай
40-59 Бий болж байгаа
40<Огт хангагдаагүй

Хүснэгтээс харахад цэцэрлэгийн орчин дахь бодлогын индекс үзүүлэлт 17.8 хувьтай гарсан нь тэгш хамруулах боловсролыг дэмжсэн цэцэрлэгийн дотоод бодлогын орчны хэрэгжилт хангалтгүй болохыг илэрхийлсэн үзүүлэлт юм. Байршлаар авч үзвэл Дундговь аймгийн сонгогдсон цэцэрлэг бусдаасаа илүү эерэг үзүүлэлттэй, Хөвсгөл аймгийн сонгогдсон цэцэрлэгт тус орчин хамгийн хангалтгүй харагдаж байна. Үүнээс индикатор тус бүрийн үзүүлэлтийг харвал цэцэрлэгийн орчинд хүүхдийг үр дүнтэй сургахын тулд бусад байгууллагуудтай хамтран ажилладаг гэдэг үзүүлэлт хамгийн бага үзүүлэлттэй байна.

Хүснэгт 32. Сургуулийн орчин дахь бодлогын орчны индекс үзүүлэлт

| | 1.Сургуулийн дотоод тэгш хамруулах бодлого, үнэт зүйлийн талаар багш, сурагч, эцэг эхчүүдэд тогтмол мэдээлэл өгдөг | 2.Хамран сургах тойргийн бүх хүүхдүүдий г сургууль хүлээн авдаг | 3.Сургууль хүүхэд нэг бүрийг үр дүнтэй сургах уян хатан бодлогын орчинтой | 4.Хүүхдийг үр дүнтэй сургахын тулд бусад байгууллагуу дтай үр дүнтэй хамтран ажилладаг | 5.Хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн сургалтын орчинд тохируулга, нэмэлт дэмжлэг үзүүлдэг | 6.Сургалтын үр дүнг сайжруулахын тулд бусад талуудын санал хүсэлтийг хүлээн авч, үйл ажиллагаандаа тусгадаг | Бодлогын орчны нийлбэр индекс оноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дорнод | 70.7 | 93.5 | 55.4 | 30.4 | 33.7 | 72.8 | 5.4 |
| Дархан | 74.3 | 94.7 | 57.5 | 15.9 | 34.5 | 69.0 | 4.4 |
| Дундговь | 79.7 | 94.9 | 74.7 | 22.8 | 38.0 | 79.7 | 7.6 |
| Хөвсгөл | 66.7 | 100.0 | 77.8 | 22.2 | 33.3 | 77.8 | 5.6 |
| УБ-СХД | 72.8 | 92.5 | 67.3 | 35.8 | 46.5 | 72.8 | 17.3 |
| **Нийт** | **73.6** | **93.7** | **64.7** | **28.6** | **40.3** | **73.2** | **11.0** |

80-100 Хангагдсан
60-79 Сайжруулах шаардлагатай
40-59 Бий болж байгаа
40<Огт хангагдаагүй

Харин сургуулийн насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн хувьд сургуулийн орчныг хэмжсэн зургаан үзүүлэлтийн нийлбэр индекс нь 11 хувь гарсан нь мөн л хангалтгүй үзүүлэлт юм. Индикатор тус бүрийн үр дүнг харвал сургууль тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг үр дүнтэй сургахын тулд бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах байдал хангалтгүй, хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн сургалтын орчинд тохируулга, нэмэлт дэмжлэг үзүүлэх зохицуулалт хангалтгүй гэж үзжээ. Ялангуяа тус үзүүлэлт нь хэл ярианы бэрхшээлтэй болон аливаа зүйлийг тогтоох, сэргээн санахдаа хүндрэлтэй тулгардаг хүүхдүүдийн хувьд хамгийн өндөр гарсан байна.

Олон талын байр суурийг үнэлгээнд тусгах зорилгоор бодлогын орчны нөхцөл байдлыг авч үзэхдээ багш нарын санал бодлыг мөн давхар судалсан. Багш нарын хувьд бодлогын орчныг харьцангуй өөргөөр буюу нийт орчны нийлбэр индекс 72.4 хувиар үнэлэгдсэн нь тэгш хамруулсан бодлогын орчин харьцангуй бий болсон, цаашид сайжруулах шаардлагатай гэдэг дүгнэлтэд хүрч байна. Багш нарын хувьд сургуулийн дотоод бодлогын асуудалд эцэг эхчүүдээс илүү ойр бөгөөд бүх орон нутагт сургууль хамран сургах тойргийнхоо бүх хүүхдийг тэгш хамруулж чаддаг гэж ихэнх сургуулийг үнэлсэн бол сургалтынхаа үр дүнг сайжруулах зорилгоор оролцогч талуудын саналыг үйл ажиллагаандаа тусгах байдал хамгийн бага үзүүлэлттэй байна (Хүснэгт 33).

Хүснэгт 33. Боловсролын орчин дахь бодлогын орчны индекс үзүүлэлт, багш нарын хариултаар

| | 1.Багш ажилчид сургуулийнхаа дотоод бодлого, үнэт зүйлийг сайтар мэддэг | 2.Тусгай хэрэгцээ, бусдаас ялгаатай байдлаас нь үл хамааран хамран сургах тойргийн хүүхдийг сургууль хүлээн авдаг, дэмждэг | 3.Хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн сургалтын орчинд тохируулга, нэмэлт дэмжлэг үзүүлэх боломжтой | 4.Сургалтын үр дүнг сайжруулахын тулд бусад талуудын санал хүсэлтийг хүлээн авч, үйл ажиллагаандаа тусгадаг | Бодлогын орчны нийлбэр индекс оноо |
|---|---|---|---|---|---|
| Дорнод | 94.7 | 100.0 | 89.5 | 94.7 | 84.2 |
| Дархан | 95.0 | 100.0 | 100.0 | 80.0 | 75.0 |
| Дундговь | 80.0 | 100.0 | 60.0 | 100.0 | 60.0 |
| Хөвсгөл | 88.9 | 100.0 | 88.9 | 88.9 | 77.8 |
| УБ-СХД | 91.3 | 95.7 | 73.9 | 87.0 | 60.9 |
| **Нийт** | **92.1** | **98.7** | **85.5** | **88.2** | **72.4** |

80-100 Хангагдсан
60-79 Сайжруулах шаардлагатай
40-59 Бий болж байгаа
40<Огт хангагдаагүй

Дээрх үзүүлэлтүүдийг дүгнээд үзвэл цэцэрлэгээс илүү сургуульд тэгш хамруулах боловсролыг дэмжсэн эрхзүйн орчин, түүний хэрэгжилтүүд явагдаж байгаа хэдий ч энэ нь нийлбэр дүнгээрээ хангалтгүй, цаашид сайжруулах шаардлагатай хэвээр байна. Ерөнхийдөө тэгш хамруулсан боловсролын бодлогын орчныг сайжруулахын тулд тусгай боловсролын чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах байдал болон боловсролын оролцогч талуудын санал хүсэлтийг хүлээн авдаг, үйл ажиллагаандаа тусгах механизмыг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

## 5.3 Боловсролын материаллаг орчин

Энэ бүлэгт зорилтот цэцэрлэг, сургуульд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдэд ээлтэй эсэх, тэдний бэрхшээлийн онцлогт нийцсэн сургуулийн дэд бүтэц, материаллаг орчин бүрдсэн эсэхийг үнэлсэн. Судалгааны мэдээллийг зорилтот цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш, ажилтнууд, эцэг эх асран хамгаалагчдын мэдээлэлд үндэслэн боловсруулав.

### 5.3.1 Сургууль, цэцэрлэгийн материаллаг орчны үнэлгээ

Судалгааны хүрээнд багш нараас үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийг сургах үйл ажиллагаанд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг асуухад тэдний 91 хувь нь сургалтын материал, тусгай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж хангалтгүй, 43 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг сургуульд хүлээн авах дэд бүтэц дутмаг, сургуулийн бэлэн байдал хангагдаагүй гэж үзсэн байна.

Дүрс 12.Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах үйл ажиллагаанд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл (N=76)




ЕБС-дад сургуулийн орчныг сайжруулах чиглэлээр хичээлийн жилийн эхэнд багш, ажилчдын саналыг аван ажлыг төлөвлөгөөндөө тусгах, хагас жилд нэг удаа эцэг, эхчүүдтэй уулзаж саналыг авах, эцэг, эхчүүдээс судалгаа авах зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Гэвч сургууль, цэцэрлэгийн төсөв санхүүгийн чадавхаас шалтгаалан олон санал хэрэгжиж чадахгүй байна. Судалгааны хүрээнд тусгай хэрэгцээтэй хүүхдийн сурах орчин, нөхцөлийг ажиглалтын аргаар судлан сургууль, цэцэрлэгийн материаллаг орчны үнэлгээг гаргалаа. Эндээс үзвэл сонгогдсон сургуулиудын материаллаг орчин хангалтгүй байна. Цэцэрлэгүүдийн хувьд мөн ижил гадаад орчин, дотоод, анги танхимын орчны материаллаг нөхцөл стандартын шаардлагыг хангахгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна (

Хүснэгт 34) .

### Хүснэгт 34. Гадаад дотоод материаллаг орчны үнэлгээ, хувиар

| Орчны ажиглалтын хуудасны үр дүн | | Гадаад орчны үнэлгээ | Дотоод орчны үнэлгээ | ТХХ суралцдаг ангийн үнэлгээ | Сургуулийн материаллаг орчны үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| **Сургуулийн үнэлгээ** | | | | | |
| Дундговь | 3-р сургууль | 50% | 40% | 71.4% | 53.8% |
| Дорнод | 1-р сургууль | 40% | 76% | 42.9% | 52.9% |
| УБ, СХД | 42-р сургууль | 80% | 68% | 0% | 49% |
| Хөвсгөл | Цагааннуур ЕБС | 20% | 32% | 28.6% | 46.9% |
| Дархан | 12-р сургууль | 10% | 32% | 71.4% | 37.8% |
| **Цэцэрлэгийн үнэлгээ** | | | | | |
| Дорнод | 8-р цэцэрлэг | 50% | 56% | 57.1% | 54.4% |
| Дархан | 7-р цэцэрлэг | 10% | 60% | 100.0% | 56.7% |
| Дундговь | 3-р цэцэрлэг | 60% | 40% | 71.4% | 57.1% |
| УБ, СХД | 253-р цэцэрлэг | 30% | 76% | 0% | 35% |

Зорилтот аймаг, дүүрэгт 2018-2019 оны хичээлийн жилд тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсролыг дэмжих чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагаа, хамтран ажилласан байгууллагуудын талаар судалгаанд оролцсон аймаг, дүүргийн боловсролын мэргэжилтнүүдээс (N=18) мэдээлэл авч Хүснэгт 35-д харуулав.

### Хүснэгт 35. ХБХ-ийн боловсролыг дэмжих чиглэлээр хамтран ажилласан байгууллага (үйл ажиллагааны тоо)

| Үйл ажиллагааны төрөл | Аймаг/Дүүргийн ЗДТГ-тай хамтран | ОУБ, ТББ хамтран | Цэцэрлэг, хороотой хамтран | Сургууль/НТБТ хамтран |
|---|---|---|---|---|
| **Бүгд** | 28 | 44 | 8 | 26 |
| Эцэг эхчүүдэд зориулсан сургалт | 4 | 4 | 1 | 6 |
| Багш нарт зориулсан сургалт | 3 | 6 | 1 | 4 |
| ХБИ-д зориулсан тохижилт, дэд бүтэц | 6 | 6 | 2 | 5 |
| ХБХ-д зориулсан тоног төхөөрөмж, сургалтын хэрэгслээр хангах | 4 | 8 | 1 | 0 |
| Олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагаа | 3 | 8 | 0 | 5 |
| Туршлага солилцох үйл ажиллагаа | 1 | 3 | 2 | 4 |
| Сургуулийн дэд бүтэц сайжруулах | 4 | 4 | 1 | 1 |
| Сургалтын материал, сурах бичгээр хангах | 3 | 5 | 0 | 1 |
| Үйл ажиллагаа зохион байгуулдаггүй | 0 | 0 | 0 | 0 |

Өнгөрсөн хичээлийн жилд тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургалтын орчныг сайжруулах чиглэлээр орон нутгийн боловсролын мэргэжилтнүүд Аймаг, Дүүргийн ЗДТГ-тай хамтран тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан сургалтын хэрэгслээр хангах, орчны тохижилт, дэд бүтцийн ажлуудыг хийсэн бол ОУБ, ТББ-тай хамтран сургалтын материал, сурах бичгээр

хангах, сургуулийн дэд бүтцийг сайжруулах ажлуудыг хийсэн байна. Мөн хороо болон цэцэрлэг, сургууль, НТБТ-тэй хамтран тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан орчны тохижилт, сургуулийн дэд бүтцийг сайжруулах ажлууд хийж гүйцэтгэсэн байна.

### 5.3.2 Хүртээмжтэй материаллаг орчин бүрдсэн эсэх

Энэ хэсэгт сургууль, цэцэрлэгийн гадаад ба дотоод орчны хувьд хүүхдэд бэрхшээл тулгардаг эсэх, материаллаг орчны хүртээмжтэй байдал, орчны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургууль, цэцэрлэгийн зүгээс арга хэмжээ авдаг эсэх талаар авч үзнэ. Үнэлгээг сургуулийн гадаад ба дотоод орчны бэрхшээл, материаллаг орчны хүртээмж, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ гэсэн 3 үндсэн хүрээнд авч үзлээ.

#### 5.3.2.1 Сургууль цэцэрлэгийн гадаад ба дотоод орчны бэрхшээл

6-17 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэдтэй 556 эх, асран хамгаалагчийн 35.2 хувь нь сургуулийн гадаад орчныг хүүхдэд нь бэрхшээл[14] учруулдаг хэмээн үнэлжээ. Тодруулбал, 25.5 хувьд нь сургуульдаа очих/буцах нийтийн тээвэртэй холбоотой, 10.4 хувьд нь цэцэрлэгийн хашаагаар орохтой холбоотой, 6.3 хувьд нь цэцэрлэгийн барилгын хаалгаар орохтой холбоотой, 12.1 хувьд нь биеийн тамирын талбай ашиглахтай холбоотой бэрхшээл тулгардаг байна.

2-5 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэдтэй 101 эх, асран хамгаалагчийн 25 хувь нь цэцэрлэгийн гадаад орчныг хүүхдэд нь бэрхшээл[15] учруулдаг гэж үзсэн. Тодруулбал, 19.8 хувьд нь цэцэрлэгтээ очих/буцах нийтийн тээвэртэй холбоотой, 5.9 хувьд нь цэцэрлэгийн хашаагаар орохтой холбоотой, 3 хувьд нь цэцэрлэгийн барилгын хаалгаар орохтой холбоотой, 8.9 хувьд нь тоглоомын талбай ашиглахтай холбоотой бэрхшээл тулгардаг байна.

Түүнчлэн  сургууль, цэцэрлэгийн гадаад ба дотоод орчин, ангийн орчинд ажиглалт хийхэд сургууль, цэцэрлэгийн орчинд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүд тусгай хэрэгсэлтэйгээр, бие даан, аюулгүй зорчих боломж бага, аюулгүй байдал хангагдаагүй, сайжруулах шаардлагатай олон ажил байна. Тухайлбал, автобусны буудлаас сургууль, цэцэрлэг хүртэлх замаар тэргэнцэртэй хүүхэд зорчих боломжгүй байгаагийн жишээг доорх хоёр зурагт харууллаа. Эхний зургаас харахад цэцэрлэг автобусны буудлаас хол байрлахын зэрэгцээ засмал зам байхгүй, зорчих боломжгүй байна. Дараагийн зургийн хувьд хуучирсан засмал замтай ч эвдрэл ихтэй учраас  тэргэнцэртэй хүүхэд зорчиход ихээхэн хүндрэлтэй аж (Дүрс 13).

---

[14] Сургууль руугаа нийтийн тээврээр зорчих, хашаагаар орох, барилгын хаалгаар орох, биеийн тамирын талбай ашиглах гэсэн 4 үзүүлэлтийн аль нэгд нь бэрхшээлтэй тулгардаг гэвэл гадаад орчныг бэрхшээлтэй гэж үзэв.

[15] Цэцэрлэг рүүгээ нийтийн тээврээр зорчих, хашаагаар орох, барилгын хаалгаар орох, тоглоомын талбайд тоглох гэсэн 4 үзүүлэлтийн аль нэгд нь бэрхшээлтэй тулгардаг гэвэл гадна орчныг бэрхшээлтэй гэж үзэв.

### Дүрс 13. Сургууль, цэцэрлэгийн гадаад орчны бэрхшээл, бэрхшээлийн төрлөөр




### Дүрс 14.Автобусны буудлаас сургууль хүртэлх замаар тэргэнцэртэй хүүхэд зорчих боломжгүй байдал

СХД, 253-р цэцэрлэг. 2019.07.22



Дорнод аймаг, 1-р сургууль. 2019.07.07



Түүнчлэн автобусны буудлаас сургууль, цэцэрлэг хүртэлх замаар харааны бэрхшээлтэй хүүхэд зорчих боломжгүй байгааг доорх хоёр зурагт харуууллаа. Эхний зургаас харахад автобусны буудлаас цэцэрлэг хүртэл харааны бэрхшээлтэй хүүхэд зорчих зориулалтын зам байхгүйн сацуу машины хөдөлгөөн их, автобусны буудлаас хол байрлаж байна. Дараагийн зургийн хувьд замын эвдрэл ихтэй учраас харааны бэрхшээлтэй хүүхэд зорчиход нэлээд хүндрэл учруулахаар байна (Дүрс 15).

### Дүрс 15. Автобусны буудлаас сургууль хүртэлх замаар хараны бэрхшээлтэй хүүхэд зорчих боломжгүй байдал

СХД, 253-р цэцэрлэг. 2019.07.22



Дорнод аймаг, 1-р сургууль. 2019.07.07



Мөн сургууль, цэцэрлэгийн хашааны хаалга тэргэнцэртэй иргэн багтахуйц өргөнтэй эсэх, барилгын хаалга нь налуу замтай эсэх, налуу зам нь түших, татах бариул болон хаалттай эсэхийг ажиглалтаар авч үзэхэд төдийлөн хангалтгүй байна.  Дараах зурагт тэргэнцэртэй хүүхэд зорчих зам байхгүй, хаалганы өргөн бага, налуу зам байхгүй, түших, татах бариулгүй зэргийн цэцэрлэг, сургуулийн кейсээр харууллаа.

### Дүрс 16. Сургууль, цэцэрлэгийн хашааны болон барилгын хаалганы хувьд тэргэнцэртэй хүүхэд орох боломжгүй байдал

СХД, 253-р цэцэрлэг. 2019.07.22



Дундговь аймаг, 3-р сургууль. 2019.07.07



6-17 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэдтэй эх, асран хамгаалагчдын 25.5 хувь нь сургуулийн дотоод орчныг хүүхдэд нь бэрхшээл[16] учруулдаг хэмээн үнэлжээ. Тодруулбал, 7.7 хувьд нь сургуулийн доторх шатаар зорчихтой холбоотой, 14.9 хувьд нь угаалгын өрөөг ашиглахтай холбоотой, 12.1 хувьд нь номын сангаар үйлчлүүлэхтэй холбоотой бэрхшээл тулгардаг аж.

[16] Сургуулийн шатаар зорчих, угаалгын өрөөг ашиглах, номын сангаар үйлчлүүлэх гэсэн 3 үзүүлэлтийн аль нэгд нь бэрхшээлтэй тулгардаг гэвэл дотоод орчныг бэрхшээлтэй гэж үзэв.

2-5 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэдтэй эх, асран хамгаалагчдын 5.9 хувь нь сургуулийн дотоод орчныг хүүхдэд нь бэрхшээл[17] учруулдаг хэмээн үнэлжээ. 5 хувьд нь сургуулийн доторх шатаар зорчихтой холбоотой, 3 хувьд нь угаалгын өрөөг ашиглахтай холбоотой бэрхшээл тулгардаг байна.

6-17 насны хүүхдийн эх, асран хамгаалагчдын 15 хувь, 2-5 насны хүүхдийн эх, асран хамгаалагчдын 5% нь гадаад ба дотоод орчны бэрхшээл хоёулаа хүүхдэд нь тулгардаг гэсэн байна.

Дүрс 17. Сургууль, цэцэрлэгийн дотоод орчны бэрхшээл, бэрхшээлийн төрлөөр




Дотоод орчны ажиглалтаар сургууль, цэцэрлэгийн дотоод орчин, ангийн орчинд ажиглалт хийхэд сургууль, цэцэрлэгийн орчинд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүд тусгай хэрэгсэлтэйгээр, бие даан, аюулгүй зорчих боломж төдийлөн бүрдээгүй байна. Доорх зурагт сургуулийн дотор шат, шал халтирахаас сэргийлсэн резинэн наалтгүй, сургуулийн коридорт нэг эсвэл хоёр талын ханаы бариулгүй, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуураар сургуулийн багш, ажилчид, хүүхдүүд бие даан саадгүй үйлчлүүлэх боломжгүй байгааг баримтжуулан харууллаа.

Дүрс 18. Сургууль, цэцэрлэгийн дотор талд аюулгүй зорчих боломжгүй байдал

Дорнод аймаг, 1-р сургууль. 2019.07.07



Дорнод аймаг, 1-р сургууль. 2019.07.07



---

*[17] Цэцэрлэгийн шатаар зорчих, угаалгын өрөөг ашиглах гэсэн 2 үзүүлэлтийн аль нэгд нь бэрхшээлтэй тулгардаг гэвэл цэцэрлэгийн дотоод орчныг бэрхшээлтэй гэж үзэв.*

Дорнод аймаг, 1-р сургууль. 2019.07.07



Зорилтот аймаг, дүүргийн сургуулиудад суралцдаг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчидтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийхэд сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдээ сургах үйл ажиллагаанд тулгарч буй материаллаг орчны дараах бэрхшээлийг голдуу хэлж байв. Үүнд:

- Сургууль, цэцэрлэгийн анги дүүргэлт хэвийн түвшнөөс хэтэрсэн.
- Сургуулийн унаа байхгүй.
- Баянхонгор аймагт НТБТ-ийн барилга нь хуучирсан учраас тэргэнцэртэй хүүхэд явах зам байхгүй.
- Дорнод аймгийн сургуулийн хувьд ариун цэврийн байгууламж нь гадаа байдаг.
- Хөвсгөл аймгийн сургуулийн хувьд анги жижиг, олон хүүхэдтэйгээс гадна өвөл галлагаа муутайгаас анги танхим нь хүйтэн байдаг.
- Ашиглах ном, сурах бичиг хүрэлцээгүй, тусгай хэрэгцээтэй хүүхдэд тохирсон ном, сурах бичиг байхгүй.

Сургууль, цэцэрлэгийн дотоод орчинд тусгай хэрэгцээтэй хүүхдийн суралцаж байгаа анги, танхимыг хүртээмжтэй болгох, сургалтын танхимыг түгээмэл загвартай[18] болгох зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байна.

#### 5.3.2.2 Материаллаг орчны хүртээмж

Материаллаг орчны хүртээмжийг сургуулийн хувьд авч үзлээ. 6-17 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эх, асран хамгаалагчдын 57.4 хувь хүүхдэд нь ашиглах боломжтой ном, сурах бичиг сургуульд хангалттай бий, 83.3 хувь хүүхэд нь хичээлийн хэрэглэгдэхүүнээ бүрэн ашигладаг гэжээ. Харин хүүхдийн сэтгэл хямарсан үед очих тусгай өрөө, сэтгэл санаа засах мэргэжлийн багш, ажилтны хүрэлцээ хангалтгүй байна. Тодруулбал, эх, асран хамгаалагчдын зөвхөн 6 орчим хувь хүүхдийнх нь сургуульд хүүхэд хямарсан үедээ очих тусгай өрөө бий гэсэн бол гуравны нэг нь тэдэнтэй ярилцах, сэтгэл санааг засах багш, ажилтантай гэжээ.

[18] "түгээмэл загвар" гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг хэлнэ. ХБХЭТХ,2017

Дүрс 19. Сургуулийн материаллаг орчны хүрэлцээ (n=556)




ЕБС-ийн түвшинд тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн (танин мэдэхүй, оюун ухааны, нийгэмшихүйн, зан үйлийн) онцлогт нийцсэн хичээлийн хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүн дутагдалтай, мэргэжлийн сэтгэл зүйч, согог засалч, дохионы багш, хэл засалч зэрэг мэргэжлийн багш, мэргэжилтнүүдийн хэрэгцээ ЕБС-д нэн шаардлагатай байна.

... Тоног төхөөрөмж, сурах бичиг дутагдалтай, мэргэжлийн багш гэдэг зүйл хамгийн чухал зүйл байна. Мэргэжлийн багш хамгийн түрүүнд байж хэрэгтэй тоног төхөөрөмж дээр ажиллаж хэрэгтэй зүйлийг заана. Одоогийн байдлаар бид хоёрт (ээж хүү хоёрт) тулгамдаад байгаа асуудал бол гарын авлага материалууд, тоног төхөөрөмж, хараагүй хүүхдэд юу байх ёстой тэр бүх зүйл хэрэгтэй байна. Жирийн хүүхдүүдтэй тоглоход нэг өөр, өөрийн мэдрэмжээр тоглодог тоглоомоор тогловол нэг өөр байна. Хурууны мэдрэмжээр тоглодог эвлүүлдэг тоглоом байдаг. Тэрийг өөрөө судалж үзсэн.Манай аймгийн төвд байдаггүй. Тэр зүйлүүд маш дутмаг байдаг. Манай суманд огт байдаггүй , хараагүй хүүхдийн хэрэглэгдэхүүн маш дутмаг.

Эх, асран хамгаалагчтай хийсэн ярилцлагаас

### 5.3.2.3 Орчны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ

Сүүлийн нэг жилийн хугацаанд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулан гадаад болон дотоод орчноо сайжруулсан сургууль харьцангүй цөөн байна. Тодруулбал, 6-17 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эх, асран хамгаалагчдын 17 орчим хувь хүүхдийнх нь сургууль сүүлийн нэг жилийн хугацаанд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулан гадаад болон дотоод орчноо сайжруулсан гэжээ. Эх, асран хамгаалагчдын гуравны нэг гаруй нь сургуулийн барилга байгууламжийг хүртээмжтэй болгох чиглэлээр эцэг эхчүүдээс санал авсан байна.

Цэцэрлэгийн хувьд гадаад ба дотоод хүртээмжээ сайжруулахад чиглэсэн ажлуудыг тодорхой түвшинд хийсэн гэж хэлж болохоор байна. Тодруулбал, 2-5 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийн эх, асран хамгаалагчдын 40 гаруй хувь нь хүүхдийнх нь цэцэрлэг сүүлийн нэг жилийн хугацаанд гадаад болон дотоод орчны хүртээмжээ

сайжруулсан гэжээ. Түүнчлэн 30 гаруй хувь нь цэцэрлэгийн барилга байгууламжийг хүртээмжтэй болгох чиглэлээр эцэг эхчүүдээс санал авсан гэж хариулсан байна.

### Дүрс 20. Сургууль, цэцэрлэгийн орчны хүртээмжийг сайжруулах арга хэмжээ




6-17 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн тал хувь нь хүүхдийнхээ сургуулийн гадаад, дотоод материаллаг орчныг бүрэн аюулгүй нөхцөлд байдаг гэж үзсэн бол 38% хувь аюултай гэж үзжээ (Дүрс 21). Харин багш нараас ангийнх нь орчин бүх хүүхдэд хүртээмжтэй байдаг эсэх талаар асуухад олонх (75%) нь хүртээмжтэй гэжээ (Дүрс 22).

### Дүрс 21. Сургууль гадаад, дотоод материаллаг орчны хувь аюулгүй эсэх, эх, асран хамгаалагчийн үнэлгээ (n=556)




### Дүрс 22. Ангийн орчин хүртээмжтэй эсэх, багшийн үнэлгээ (n=76)




Хүснэгт 36 ба Хүснэгт 37-д үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн эх, асран хамгаалагчдын сургууль, цэцэрлэгийн материаллаг орчны хүртээмжийн талаарх үнэлгээг голлох үзүүлэлтүүдээр харьцуулан харуулав.

Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сурах орчны стандартыг хангахын тулд сургуулийн дэд бүтэц, материаллаг орчинд шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх чиглэлээр дараах асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

- Хүүхдийн аюулгүй байдал, эрүүл, ариун цэврийн стандартыг хангасан орчныг бүрдүүлэх
- Сургалтын стандартыг хангасан анги, танхимаар хангах
- Тээвэрлэлт, сургуульдаа ирэх, очих боломжийг бүрдүүлэх
- Сурах бичиг, хүүхдийн бэрхшээлийн төрөл, онцлогт тохирох сурах бичгээр хангах
- Сургалтын материаллаг орчныг сайруулахад эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
- Хичээлийн анги, танхимын хүрэлцээ, ширээ сандал, багтаамжийг стандартын дагуу болгох, орчныг сайжруулах
- Сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг нэмэх, тоног төхөөрөмж, сургалтын техник хэрэгслийн талаас дэмжих
- Сурах бичиг, ном, дэвтэр зэрэг хичээлийн хэрэгслээр хангах
- Спорт заал, тоглоомын талбай, амрах өрөөтэй болох

## Хүснэгт 36. Сургуулийн материаллаг орчны хүртээмж

6-17 насны хүүхэдтэй эх, асран хамгаалагчдын хариултын хувь, байршил, хүүхдийн нас, хүүхдийн үйлдлийн чадварын хүндрэлийн төрөл, өрхийн аж байдлын түвшнөөр

| | | Сургуулийн гадаад орчны бэрхшээлийн төрлүүд | | | | Сургуулийн дотоод орчны бэрхшээлийн төрлүүд | | | Материаллаг орчны хүртээмж | | | | Орчны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ | | | Сургуулийн гадаад, дотоод орчныг бүрэн аюулгүй гэдэгтэй санал нийлэх эсэх | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Нийтийн тээврээр зорчих | Хашаагаар орох | Барилгын хаалгаар орох | Биеийн тамирын талбайд тоглоход | Шатаар зорчих | Угаалгын өрөөг ашигла | Сургуулийн номын сангаар | Ашиглах боломжтой ном, _ | Хичээлийн хэрэглэгдэхүүнээ _ | Тусгай өрөө байдаг | Сэтгэл заслын багш, ажилтан | Гадаад орчны хүртээмжийг сайжруулсан | Дотоод орчны хүртээмжийг сайжруулсан | Сургуулийн барилгыг хүртээмжтэй болгох чиглэлээр эцэг эхээс санал авсан | Нийлнэ | Нийлэхгүй |
| **Бүгд** | 556 | 25.5 | 10.4 | 6.3 | 12.1 | 7.7 | 14.9 | 12.1 | 57.4 | 83.3 | 5.8 | 34.5 | 16.9 | 16.7 | 37.4 | 50.2 | 38.3 |
| **Байршил** | | | | | | | | | | | | | | | | | |
| Дорнод | 92 | 12.0 | 6.5 | 6.5 | 10.9 | 7.6 | 23.9 | 13.0 | 57.6 | 85.9 | 1.1 | 18.5 | 8.7 | 9.8 | 40.2 | 56.5 | 34.8 |
| Дархан-Уул | 113 | 31.9 | 8.8 | 8.8 | 5.3 | 5.3 | 16.8 | 9.7 | 64.6 | 87.6 | 2.7 | 40.7 | 12.4 | 11.5 | 26.5 | 52.2 | 34.5 |
| Дундговь | 79 | 12.7 | 1.3 | 1.3 | 2.5 | 2.5 | 0.0 | 7.6 | 51.9 | 88.6 | 6.3 | 24.1 | 17.7 | 17.7 | 26.6 | 54.4 | 27.8 |
| Хөвсгөл | 18 | 16.7 | 0.0 | 11.1 | 5.6 | 5.6 | 22.2 | 27.8 | 22.2 | 83.3 | 0.0 | 16.7 | 5.6 | 5.6 | 33.3 | 44.4 | 50.0 |
| УБ-СХД | 254 | 32.3 | 16.1 | 6.3 | 18.9 | 10.6 | 15.0 | 13.0 | 58.3 | 78.7 | 9.1 | 42.1 | 22.4 | 22.0 | 44.9 | 46.1 | 43.7 |
| **Хүүхдийн насны ангилал** | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 -9 | 218 | 28.0 | 13.3 | 8.3 | 12.4 | 8.7 | 15.1 | 9.6 | 68.3 | 85.8 | 5.0 | 30.7 | 16.1 | 17.0 | 38.5 | 48.2 | 41.3 |
| **Бүгд** | 3.0 | 1215 | 75.7 | 2.7 | 10.8 | 2.7 | 8.1 | 37 |
| **Хүйс** | | | | | | | | |
| Эрэгтэй | 4.7 | 597 | 71.4 | 3.6 | 14.3 | 0.0 | 10.7 | 28 |
| Эмэгтэй | 1.5 | 618 | 88.9 | 0.0 | 0.0 | 11.1 | 0.0 | 9 |
| Насны бүлэг | | | | | | | | |
| 2-5 | 1.0 | 306 | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 3 |
| 6-9 | 4.2 | 408 | 64.7 | 0.0 | 23.5 | 5.9 | 5.9 | 17 |
| 10-14 | 3.8 | 342 | 92.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 7.7 | 13 |
| 15-17 | 2.5 | 159 | 50.0 | 25.0 | 0.0 | 0.0 | 25.0 | 4 |
| **Хүүхдүүдийн эцэг, эхтэйгээ амьдарч буй байдал** | | | | | | | | |
| Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг | 2.4 | 1096 | 76.9 | 3.8 | 11.5 | 0.0 | 7.7 | 26 |
| Зөвхөн эхтэйгээ хамт амьдардаг | 10.5 | 86 | 88.9 | 0.0 | 11.1 | 0.0 | 0.0 | 9 |
| Зөвхөн эцэгтэйгээ хамт амьдардаг | 0.0 | 10 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эцэг, эх нь хоёулаа нас барсан | 100.0 | 2 | 0.0 | 0.0 | 0.0 | 50.0 | 50.0 | 2 |
| Мэдэхгүй | 0.0 | 21 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0 |
| **Өрхийн аж байдлын түвшин** | | | | | | | | |
| Доогуур | 1.9 | 270 | 0.0 | 0.0 | 60.0 | 0.0 | 40.0 | 5 |
| Дунджаас доогуур | 5.1 | 256 | 92.3 | 0.0 | 0.0 | 7.7 | 0.0 | 13 |
| Дундаж | 2.4 | 248 | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 6 |
| Дунджаас дээгүүр | 2.6 | 234 | 50.0 | 16.7 | 16.7 | 0.0 | 16.7 | 6 |
| Дээгүүр | 3.4 | 207 | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 7 |
| **Байрлал** | | | | | | | | |
| Дорнод | 6.2 | 210 | 84.6 | 0.0 | 7.7 | 0.0 | 7.7 | 13 |
| Дархан-Уул | 4.4 | 272 | 66.7 | 8.3 | 8.3 | 8.3 | 8.3 | 12 |
| Дундговь | 4.7 | 150 | 57.1 | 0.0 | 28.6 | 0.0 | 14.3 | 7 |
| Хөвсгөл | 0.0 | 44 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0 |
| УБ-СХД | .9 | 539 | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 5 |

# 2.Өрхийн эдийн засгийн шинж байдал

## 2.1.Өрхийн аж байдлын түвшин

Аж байдлын индекс нь өрхийн амьдралын түвшний нийлмэл хэмжүүр юм. Аж байдлын индексийг өрхийн удаан эдэлгээтэй барааны хэрэглээ, сууцны төрөл, ашиглагдсан материал, ус болон ариун цэврийн байгууламжийн төрөл зэрэг үзүүлэлтүүдийг ашиглан тооцдог. Уг индекс нь өрхийг доогуур аж байдалтайгаас дээгүүр аж байдалтай хүртэл эрэмбэлэн хувааж, тухайн бүлэгт тулгарч буй асуудлуудыг тодорхойлох боломж олгодог (USAID). Энэ судалгааны хувьд аж байдлын индексийг 562 өрхийн хувьд тооцож, өрхүүдийг аж байдлын түвшнээр 5 тэнцүү бүлэгт хуваана. Ингэснээр өрхийн аж байдлын ялгаатай байдал нь үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээ авахад тулгарч буй бэрхшээлд хэрхэн нөлөөлж буйг илрүүлэх боломж бүрдэх юм.

Судалгаанд хамрагдсан өрх болон өрхийн хүн амыг өрхийн аж байдлын түвшнөөр нь ангилж, Хүснэгт 46 ба Хүснэгт 47-д тус тус үзүүлэв. Дорнод аймгийн өрхүүдийн аж байдлын түвшин харьцангуй сайн буюу нийт өрхийн 81.5 хувь нь дунджаас дээгүүр ба дээгүүр гэсэн бүлэгт хамаарч байгаа бол Хөвсгөл аймагт өрхийн аж байдлын түвшин харьцангуй сул буюу өрхүүдийн олонх нь (76.1%) нь дунджаас доогуур ба доогуур гэсэн бүлэгт хамаарч байна. Харин Дархан-Уул ба Улаанбаатар хотын өрхүүдийн аж байдал нэлээд төстэй буюу өрхүүдийн 30 гаруй хувь нь дунджаас дээгүүр ба дээгүүр бүлэгт, 70 орчим хувь нь дундаж ба түүнээс доогуур бүлгүүдэд харьяалагдаж байна.  Дундговь аймгийн өрхүүд аж байдлын түвшний 5 бүлэгт харьцангуй жигд тархжээ.

Хүснэгт 46. Өрхийн аж байдлын түвшин, өрхийн тоогоор

| Өрхийн эзлэх хувь, өрхийн аж байдлын түвшнөөр, өрхийн тоогоор | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Өрхийн аж байдлын түвшин | | | | |
| | Өрхийн тоо | Доогуур | Дунджаас доогуур | Дундаж | Дунджаас дээгүүр | Дээгүүр |
| Бүгд | 562 | 19.9 | 20.1 | 19.9 | 20.1 | 19.9 |
| Дорнод | 97 | 0.0 | 11.3 | 7.2 | 18.6 | 62.9 |
| Дархан-Уул | 117 | 19.7 | 23.1 | 25.6 | 20.5 | 11.1 |
| Дундговь | 81 | 19.8 | 17.3 | 23.5 | 23.5 | 16.0 |
| Хөвсгөл | 21 | 57.1 | 19.0 | 23.8 | 0.0 | 0.0 |
| УБ-СХД | 246 | 24.8 | 23.2 | 20.7 | 21.1 | 10.2 |

Өрхийн гишүүдийг аж байдлын түвшнөөр ангилахад 562 өрхийн 2577 гишүүний 42 хувь (1056) нь дунджаас доогуур, 20% (511) нь дундаж, 38 хувь (988) нь дунджаас дээгүүр аж байдалтай амьдарч байна.

Хүснэгт 47. Өрхийн аж байдлын түвшин, байршлаар

| Өрхийн гишүүдийн эзлэх хувь, өрхийн аж байдлын түвшнөөр, байршлаар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Өрхийн аж байдлын түвшин | | | | |
| | Өрхийн гишүүдийн тоо | Доогуур | Дунджаас доогуур | Дундаж | Дунджаас дээгүүр | Дээгүүр |
| **Бүгд** | **2577** | **20.9** | **20.9** | **19.8** | **19.7** | **18.6** |
| Дорнод | 443 | 0.0 | 11.1 | 7.7 | 17.6 | 63.7 |
| Дархан-Уул | 613 | 21.7 | 24.6 | 25.0 | 19.1 | 9.6 |
| Дундговь | 323 | 19.8 | 18.6 | 23.8 | 25.4 | 12.4 |
| Хөвсгөл | 96 | 59.4 | 17.7 | 22.9 | 0.0 | 0.0 |
| УБ-СХД | 1102 | 25.9 | 23.8 | 20.4 | 21.0 | 9.0 |

Дараагийн хэсгүүдэд өрхийн аж байдлын индексийн тооцоход ашигласан үзүүлэлтүүдийг багцлан авч үзнэ.

## 2.2. Өрхийн сууц

Өрхийн аж байдлын индексийг тооцоход ашигласан нэг багц үзүүлэлт бол өрхийн сууцны төрөл, сууцанд ашиглагдсан материал юм. Дүрс 25-д өрхийн сууцны төрөл, сууцны хэмжээ, өрөөний тоо, сууцны шал, дээвэр, гадна ханаы үндсэн материал, цахилгаан эрчим хүчээр хангагдсан эсэх, интернэттэй зэрэг үзүүлэлтийг байршил тус бүрээр харууллаа.

Нийт судалгаанд оролцсон өрхүүдийн 31 хувь нь гэрт, 30 хувь нь сууцны тусдаа байшинд, 28 хувь нь орон сууцанд, үлдсэн 11 хувь нь бие даасан тохилог сууц болон нийтийн байранд амьдарч байна.

Дүрс 25.Өрхийн сууцны төрөл, хувиар




Байршлаар авч үзвэл гэрт амьдардаг өрхүүдийн талаас илүү хувь нь Улаанбаатар хотын өрхүүд бол Дорнод аймгаас гэрт амьдардаг өрх судалгаанд хамрагдаагүй байна. Орон сууцны байшинд амьдарч буй өрхүүдийн бараг тал орчим хувь нь Дорнод аймгийнх, сууцны тусдаа байшинд амьдарч буй өрхүүдийн олонх нь Улаанбаатар хотын өрхүүд ажээ.

Гэрт амьдардаг өрхүүд дунджаар 4-5 ханатай гэрт, байшинд амьдардаг өрхүүд дунджаар 62м$^2$ талбай бүхий байшинд амьдарч байна. Дундговь ба Улаанбаатар хотын өрхүүдийн сууцны дундаж хэмжээ бусад байршлаас илүү том ажээ. Өрхүүдийн байшин дунджаар 2 өрөөтэй бүхий байшинд амьдарч байна. Дундговь ба Улаанбаатар хотын өрхүүдийн сууцны дундаж хэмжээ бусад байршлаас илүү том ажээ. Өрхүүд өөрийн сууцандаа амьдардаг бол үлдсэн өрхүүд түрээсийн болон түрээсгүй сууцанд амьдарч байна. Хөвсгөл, Дундговийн

өрхүүдийн хувьд голдуу өөрийн эзэмшлийн сууцандаа сууж байгаа бол Улаанбаатарын өрхүүдийн энэ хувь хамгийн бага байна.

Хүснэгт 48. Өрхийн сууцны шинж байдал

| Өрхийн хувь, дундаж хэмжээ, байршлаар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Байршил | | | | |
| | Бүгд | Дорнод | Дархан-Уул | Дундговь | Хөвсгөл | УБ-СХД |
| **Дүн** | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Сууцны төрөл, % | | | | | | |
| Гэр | 31.3 | 0.0 | 19.3 | 26.7 | 2.3 | 51.7 |
| Орон сууцны байшин | 28.5 | 48.8 | 18.1 | 13.8 | 0.0 | 19.4 |
| Бие даасан тохилог сууц | 7.1 | 2.5 | 52.5 | 12.5 | 0 | 32.5 |
| Сууцны тусдаа байшин | 29.5 | 0.6 | 19.9 | 4.2 | 10.2 | 65.1 |
| Нийтийн байр | 3.6 | 85 | 0 | 0 | 0 | 15 |
| **Гэрийн ханын дундаж тоо** | 4.8 | - | 5.1 | 4.5 | 5 | 4.9 |
| **Сууцны дундаж талбайн хэмжээ, м2** | 61.9 | 42.5 | 49.5 | 62 | 53.5 | 78.9 |
| **Нийт өрөөний дундаж тоо** | 2.1 | 2 | 2 | 2.6 | 1.4 | 2.2 |
| **Хүн унтдаг өрөөний тоо**, % | | | | | | |
| 0 | 1.2 | 0.0 | 1.7 | 0.0 | 0.0 | 2.0 |
| 1 | 68.3 | 53.6 | 65.8 | 87.7 | 90.5 | 67.1 |
| 2 | 26.2 | 38.1 | 29.1 | 8.6 | 9.5 | 27.2 |
| 3 ба түүнээс дээш | 4.3 | 8.2 | 3.4 | 3.7 | 0.0 | 3.7 |
| **Нэг өрөөнд унтдаг хүний дундаж тоо** | 3.9 | 3.4 | 4.3 | 4.3 | 4.4 | 3.9 |
| **Сууцны өмчийн хэлбэр, %** | | | | | | |
| Өөрийн сууц | 82.56 | 81.44 | 82.05 | 92.59 | 95.24 | 78.86 |
| Түрээстэй суудаг | 7.65 | 14.43 | 10.26 | 2.47 | 0.00 | 6.10 |
| Түрээсгүй суудаг | 5.16 | 3.09 | 5.13 | 3.70 | 4.76 | 6.50 |
| Бусад | 4.6 | 1.03 | 2.56 | 1.23 | 0.00 | 8.54 |
| Өрхийн тоо | 562 | 97 | 117 | 81 | 21 | 246 |

Нийт судалгаанд хамрагдсан өрхүүдийн олонх (84%) нь бүрэн ба хагас боловсруулсан шалтай сууцтай бол 15 орчим хувь нь шалгүй бөгөөд эдгээр нь гэрт амьдардаг өрхүүд аж. Байшинд амьдардаг 386 өрхийн 70 хувьд байшингийнх нь шал дулаалгагүй бол үлдсэн 30 хувьд байшингийнх нь шал дулаалгатай ажээ. Шалны дулаалгаа голдуу хайрга, үнс, шаарга, шилэн хөвөнгөөр хийжээ.

### Дүрс 26. Байшинтай өрхүүдийн шалны дулаалга (n=386)




Сууцны дээвэр ба ханын материалын хувьд байшинтай өрхүүд голдуу бүрэн боловсруулсан материалаар байшингийн дээвэр ба ханаа хийсэн байна. Гэртэй өрхүүдийн олонх нь хүйтний улиралд дээвэр болон туургаа давхарлан дулаалдаг ажээ. Түүнчлэн гэртэй айлуудын 59% нь үүдний амбаартай, харин 41% үүдний амбаар ашигладаггүй байна.

Байшинтай өрхүүдийн 47% нь байшингийнхаа дээврийг, 42% нь ханаа дулаалаагүй байна. Дээвэр болон ханын дулаалгад шилэн хөвөн, хайрга, үнс, шаарга, үртэс, цагаан хөөсөнцөр түгээмэл ашигладаг байна.

### Дүрс 27. Байшингийн дээврийн дулаалгын байдал (n=386)




### Дүрс 28. Байшингийн ханын дулаалгын байдал (n=386)




Судалгаанд хамрагдсан бараг бүх өрх төвлөрсөн эрчим хүчний системд хамрагдсан бол зөвхөн 4 өрх цахилгаангүй бөгөөд үүний 2 нь Улаанбаатар хотынх, үлдсэн 2 нь Хөвсгөл аймгийн өрх аж. Нийт өрхийн 39 хувь нь гэртээ интернэтийн холболттой, харин 61% нь гэртээ интернэтгүй байна.

Хүснэгт 49. Өрхийн сууцны материал

| Өрхийн хувь, байршлаар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Байршил | | | | |
| | Бүгд | Дорнод | Дархан-Уул | Дундговь | Хөвсгөл | УБ-СХД |
| Дүн | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| **Шалны үндсэн материал** | | | | | | |
| **Байшин** | | | | | | |
| Шалгүй | 0.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 1.2 |
| Хагас боловсруулсан(a) | 16.7 | 19.6 | 14.5 | 1.2 | 71.4 | 17.1 |
| Бүрэн боловсруулсан(b) | 49.3 | 80.4 | 52.1 | 40.7 | 9.5 | 41.9 |
| Бусад | 1.1 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.4 |
| **Гэр** | | | | | | |
| Шалгүй | 14.2 | 0.0 | 20.5 | 12.3 | 14.3 | 17.5 |
| Хагас боловсруулсан(a) | 12.8 | 0.0 | 4.3 | 33.3 | 4.8 | 15.9 |
| Бетон | 4.1 | 0.0 | 4.3 | 11.1 | 0.0 | 3.7 |
| Бусад | 0.2 | 0.0 | 0.0 | 1.2 | 0.0 | 0.0 |
| Хариулаагүй/Мэдэхгүй | 1.1 | 0.0 | 4.3 | 0.0 | 0.0 | 0.4 |
| **Дээврийн үндсэн материал** | | | | | | |
| **Байшин** | | | | | | |
| Бүрэн боловсруулсан( c) | 59.6 | 84.5 | 45.3 | 38.3 | 81.0 | 61.8 |
| Бусад | 5.0 | 8.2 | 12.0 | 3.7 | 0.0 | 1.2 |
| **Гэр** | | | | | | |
| Дан | 8.7 | 0.0 | 11.1 | 6.2 | 14.3 | 11.4 |
| Давхар | 22.6 | 0.0 | 17.9 | 51.9 | 4.8 | 25.6 |
| Хариулаагүй/Мэдэхгүй | 4.1 | 7.2 | 13.7 | 0.0 | 0.0 | 0.0 |
| **Ханын үндсэн материал** | | | | | | |
| **Байшин** | | | | | | |
| Хагас боловсруулсан (d) | 2.7 | 0.0 | 6.8 | 0.0 | 0.0 | 2.8 |
| Бүрэн боловсруулсан(e) | 63.0 | 99.0 | 53.0 | 42.0 | 81.0 | 58.9 |
| Бусад | 3.0 | 1.0 | 11.1 | 0.0 | 0.0 | 1.2 |
| **Гэр** | | | | | | |
| Дан | 7.7 | 0.0 | 12.8 | 4.9 | 9.5 | 8.9 |
| Давхар | 23.7 | 0.0 | 16.2 | 53.1 | 9.5 | 28.0 |
| Цахилгаан эрчим хүч | | | | | | |
| Төвлөрсөн системд холбогдсон | 98.4 | 99.0 | 100.0 | 98.8 | 90.5 | 98.0 |
| Дэд станц/ генератор | 0.9 | 1.0 | 0.0 | 1.2 | 0.0 | 1.2 |
| Цахилгаан эрчим хүчгүй | 0.7 | 0.0 | 0.0 | 0.0 | 9.5 | 0.8 |
| Гэртээ интернэт холболттой | | | | | | |
| Тийм | 39.0 | 71.1 | 31.6 | 48.1 | 4.8 | 29.7 |
| Үгүй | 61.0 | 28.9 | 68.4 | 51.9 | 95.2 | 70.3 |
| Өрхийн тоо | 562 | 97 | 117 | 81 | 21 | 246 |

Хагас боловсруулсан шалны материал: банз, мод.
Бүрэн боловсруулсан шалны материал: модон паркет, өнгөлсөн мод, шахмал паркет, плита, бетон.
Бүрэн боловсруулсан дээврийн материал: металл/төмөр, долгионт хавтан, хар цаас/замын хар орно.
Хагас боловсруулсан ханын материал: сүрэл, шар шавар
Бүрэн боловсруулсан ханын материал: цемент, блок, мод, банз, дүнз, тоосго, металл өнгөлгөө, хуванцар хавтан, шавардлага

## 2.3.Өрхийн эд зүйлс

Өрхийн аж байдлын индексийн бас нэгэн гол үзүүлэлт бол өрхийн эзэмшиж буй эд зүйлс юм. Хүснэгт 50-д өрхийн эзэмшдэг цахилгаан хэрэгсэл, тавилга, эд хогшил, өрхийн гишүүний эзэмшдэг зүйлсийг байршлаар харууллаа. Цахилгаан хэрэгслийн хувьд өрхүүдийн олонх нь зурагт, индүү, хөргөгч, хагас автомат угаалгын машин, будаа агшаагчтай аж. Тавилга, эд хогшлын хувьд ихэнх өрх унтлагын ор, хувцасны шүүгээ, буйдантай байна. Бүх өрхийн хувьд гар утастай гишүүнтэй, ихэнх өрхийн (74%) гишүүд нь банкны хадгаламжийн эсвэл харилцах данстай байна.

**Хүснэгт 50. Өрхийн болон өрхийн гишүүдийн эд зүйлс**

| Эзэмшдэг өрхийн хувь, байршлаар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Байршил | | | | |
| | Бүгд | Дорнод | Дархан-Уул | Дундговь | Хөвсгөл | УБ-СХД |
| **Цахилгаан хэрэгсэл** | | | | | | |
| Зурагт | 95.6 | 97.9 | 97.4 | 93.8 | 85.7 | 95.1 |
| Хөргөгч | 82.0 | 93.8 | 74.4 | 74.1 | 28.6 | 88.2 |
| Хөлдөөгч | 41.1 | 41.2 | 41.9 | 60.5 | 52.4 | 33.3 |
| Тоос сорогч | 37.7 | 56.7 | 21.4 | 53.1 | 23.8 | 34.1 |
| Богино долгионы зуух | 17.3 | 18.6 | 18.8 | 18.5 | 4.8 | 16.7 |
| Шарах шүүгээ | 29.4 | 49.5 | 29.1 | 24.7 | 28.6 | 23.2 |
| Индүү | 86.1 | 90.7 | 85.5 | 84.0 | 71.4 | 86.6 |
| Холигч/миксер | 15.8 | 40.2 | 11.1 | 7.4 | 4.8 | 12.2 |
| Халуун тогоо | 53.9 | 48.5 | 49.6 | 72.8 | 42.9 | 52.8 |
| Кофе чанагч | 3.0 | 8.2 | 1.7 | 0.0 | 0.0 | 2.8 |
| Будаа агшаагч | 70.6 | 82.5 | 66.7 | 63.0 | 47.6 | 72.4 |
| Талх баригч | 4.4 | 8.2 | 2.6 | 0.0 | 0.0 | 5.7 |
| Хагас автомат угаалгын машин | 77.2 | 70.1 | 71.8 | 75.3 | 81.0 | 82.9 |
| Бүрэн автомат угаалгын машин | 5.2 | 16.5 | 3.4 | 7.4 | 0.0 | 1.2 |
| Агаар цэвэршүүлэгч | 5.0 | 10.3 | .9 | 2.5 | 0.0 | 6.1 |
| Агаар чийгшүүлэгч | 5.3 | 11.3 | 1.7 | 2.5 | 0.0 | 6.1 |
| Видео камер, зургийн аппарат | 5.9 | 11.3 | 1.7 | 7.4 | 0.0 | 5.7 |
| Тавилга, эд хогшил | | | | | | |
| Суурин утас | 3.74 | 11.34 | 2.56 | 2.47 | 4.76 | 1.63 |
| Радио | 1.2 | 2.1 | 0.9 | 1.2 | 0.0 | 1.2 |
| Буйдан | 65.5 | 75.3 | 52.1 | 84.0 | 28.6 | 65.0 |
| Хувцасны шүүгээ | 73.2 | 78.6 | 91.4 | 57.1 | 78.0 | 78.5 |
| Төмөр ор | 5.7 | 3.1 | 6.8 | 7.4 | 19.0 | 4.5 |
| Унтлагын ор | 79 | 67.0 | 79.5 | 81.5 | 71.4 | 83.3 |
| **Өрхийн гишүүний эзэмшдэг эд зүйлс, өрхийн хувь** | | | | | | |
| Компьютер, нөутбүүк, таблет | 28.8 | 47.4 | 20.5 | 32.1 | 28.6 | 24.4 |
| Гар утас | 99.6 | 100.0 | 100.0 | 97.5 | 100.0 | 100.0 |
| **Банкны данс** | 73.8 | 92.8 | 78.6 | 53.1 | 100.0 | 68.7 |
| **Өрхийн тоо** | 562 | 97 | 117 | 81 | 21 | 246 |

## 2.4.Өрхийн бусад хөрөнгө

Өрхийн аж байдлын индексийн тооцоонд өрхийн тээврийн хэрэгсэл, газар тариалангийн талбай, хувийн мал, тэжээвэр амьтантай эсэхийг хамруулан тооцсон. Өрхүүдийн хамгийн түгээмэл ашиглагдаг тээврийн хэрэгсэл нь суудлын машин (40%), унадаг дугуй (23.8%) ажээ.

Байршлаар авч үзэхэд Хөвсгөлөөс бусад бүх байршилд суудлын машинтай өрхийн тоо бусад тээврийн хэрэгслээс тэргүүлж байгаа бол Хөвсгөлд өрхүүдийн гуравны хоёр нь мотоциклтой аж. Түүнчлэн ачааны машинтай өрхийн тоо орон нутагт их байх хандлагатай байна.

Нийт өрхүүдийн зөвхөн 1.2 хувь (7 өрх) нь газар тариалан, 13.9 хувь (78 өрх) нь хувийн мал, тэжээвэр амьтантай байна. Мал бүрээр авч үзвэл өрхүүдийн 5-7 хувь нь үхэр, адуу, ямаа, хоньтой ажээ.

Хүснэгт 51. Өрхийн бусад хөрөнгийн шинж байдал

| Эзэмшдэг өрхийн хувь, байршлаар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Байршил | | | | |
| | Бүгд | Дорнод | Дархан-Уул | Дундговь | Хөвсгөл | УБ-СХД |
| **Өрхийн тээврийн хэрэгсэл** | | | | | | |
| Унадаг дугуй | 23.8 | 46.4 | 17.9 | 29.6 | 33.3 | 15.0 |
| Мотоцикл | 4.3 | 3.1 | 1.7 | 4.9 | 66.7 | 0.4 |
| Ердийн хөсөг | 2.7 | 1.0 | 10.3 | 0.0 | 4.8 | 0.4 |
| Жийп | 1.2 | 3.1 | 0.9 | 0.0 | 0.0 | 1.2 |
| Суудлын машин | 40.0 | 45.4 | 29.9 | 40.7 | 28.6 | 43.5 |
| Ачааны машин | 5.3 | 8.2 | 2.6 | 12.3 | 14.3 | 2.4 |
| Микро автобус | 1.1 | 0.0 | 0.9 | 1.2 | 0.0 | 1.6 |
| Трактор | 0.7 | 2.1 | 0.0 | 0.0 | 4.8 | 0.4 |
| **Тариалангийн талбай ба мал амьтан** | | | | | | |
| Тариалангийн талбайтай | 1.2 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.8 |
| Мал, тэжээвэр амьтантай | 13.9 | 19.6 | 2.6 | 18.5 | 71.4 | 10.6 |
| **Мал тус бүрээр** | | | | | | |
| Үхэр | 6.4 | 16.5 | 2.6 | 1.2 | 61.9 | 1.2 |
| Тэмээ | 0.4 | 1.0 | 0.0 | 1.2 | 0.0 | 0.0 |
| Адуу | 5.7 | 16.5 | 1.7 | 7.4 | 23.8 | 1.2 |
| Ямаа | 6.6 | 11.3 | 2.6 | 16.0 | 42.9 | 0.4 |
| Хонь | 7.1 | 13.4 | 2.6 | 14.8 | 38.1 | 1.6 |
| **Өрхийн тоо** | **562** | **97** | **117** | **81** | **21** | **246** |

Малтай айлуудын малын дундаж тоог Хүснэгт 52-д харуулав. Дундговь болон Дорнодын малтай айлуудын нийт малын дундаж тоо хамгийн их байна. Түүнчлэн өрхийн аж байдлын түвшин нэмэгдэхийн хэрээр малтай айлуудын малын тоо олширч байна.

Хүснэгт 52. Дундаж малын тоо

| Дундаж утгаар, байршил ба өрхийн аж байдлын түвшнөөр | | Таван хошуу мал | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Үхэр | Тэмээ | Адуу | Ямаа | Хонь |
| **Байршил** | | | | | | |
| Дорнод | 231 | 27 | 3 | 60 | 79 | 163 |
| Дархан-Уул | 63 | 6 | - | 6 | 28 | 25 |
| Дундговь | 275 | 3 | 18 | 45 | 148 | 114 |
| Хөвсгөл | 39 | 19 | - | 11 | 15 | 19 |
| УБ-СХД | 26 | 5 | - | 4 | 10 | 24 |
| **Өрхийн аж байдлын түвшин** | | | | | | |
| Доогуур | 45 | 23 | - | 12 | 13 | 19 |
| Дунджаас доогуур | 122 | 12 | - | 3 | 89 | 83 |
| Дундаж | 182 | 13 | 18 | 32 | 133 | 71 |
| Дунджаас дээгүүр | 110 | 7 | - | 21 | 60 | 63 |
| Дээгүүр | 221 | 24 | 3 | 58 | 96 | 146 |

## 2.5.Өрхийн орлого ба орлогын эх үүсвэр

Өрхийн амьжиргаанд нөлөөлдөг гол хүчин зүйл бол өрхийн орлого юм. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 87.2 хувь нь 1.1 сая төгрөгөөс бага буюу улсын дунджаас[22] бага орлоготой байна. Өрхийн орлогыг судалгааны байршлаар авч үзвэл, Дорнодын өрхүүдийн 69 хувь, Дархан-Уулын 88.9 хувь, Дундговийн 87.6 хувь, Хөвсгөлийн 80.8 хувь, Улаанбаатарын 94 хувь улсын дунджаас бага орлоготой байна.

Өрхийн аж байдлын түвшнөөр авч үзвэл, доогуур болон дунджаас доогуур аж байдалтай бараг бүх өрх, дундаж аж байдалтай өрхүүдийн 92 хувь, дунджаас дээгүүр аж байдалтай өрхүүдийн 88 хувь, дээгүүр аж байдалтай өрхүүдийн 57 хувь нь улсын дунджаас бага орлоготой байна. Өрхийн аж байдлын түвшин болон өрхийн сарын орлого эерэг хамааралтай буюу аж байдлын түвшин өсөхийн хэрээр орлого өсөж буй дүр зураг ажиглагдаж байна.

Хүснэгт 53. Өрхийн сарын дундаж орлого

| Өрхийн хувь, байршил ба өрхийн аж байдлын түвшнөөр | Өрхийн сарын орлого, мянган төгрөг | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | <300 | 300-500 | 501-700 | 701-900 | 901-1.100 | 1,101-1.600 | 1,601-2.100 | 2,100< |
| Бүгд | 20.5 | 21.5 | 22.1 | 14.4 | 8.7 | 8.9 | 2.0 | 2.0 |
| **Байршил** | | | | | | | | |
| Дорнод | 14.4 | 15.5 | 17.5 | 10.3 | 11.3 | 19.6 | 4.1 | 7.2 |
| Дархан-Уул | 12.8 | 27.4 | 23.1 | 17.1 | 8.5 | 9.4 | 0.0 | 1.7 |
| Дундговь | 30.9 | 17.3 | 18.5 | 12.3 | 8.6 | 4.9 | 6.2 | 1.2 |
| Хөвсгөл | 33.3 | 19.0 | 9.5 | 9.5 | 9.5 | 19.0 | 0.0 | 0.0 |
| УБ-СХД | 22.0 | 22.8 | 25.6 | 15.9 | 7.7 | 4.9 | 0.8 | 0.4 |
| **Өрхийн аж байдлын түвшин** | | | | | | | | |
| Доогуур | 44.6 | 31.3 | 15.2 | 5.4 | 3.6 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Дунджаас доогуур | 30.1 | 32.7 | 17.7 | 13.3 | 5.3 | 0.9 | 0.0 | 0.0 |

[22] 2018 оны байдлаар нэг өрхийн сарын дундаж орлого Улсын дунджаар 1,181,067 төгрөг байна (ҮСХ, 2018).

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дундаж | 16.1 | 23.2 | 27.7 | 17.0 | 8.0 | 6.3 | 0.9 | 0.9 |
| Дунджаас дээгүүр | 9.7 | 14.2 | 29.2 | 23.0 | 11.5 | 8.8 | 1.8 | 1.8 |
| Дээгүүр | 1.8 | 6.3 | 20.5 | 13.4 | 15.2 | 28.6 | 7.1 | 7.1 |

Өрхийн орлогын эх үүсвэрийг авч үзвэл нийт өрхийн 70 хувь нь цалингийн орлоготой, 43.5 хувь нь хүүхдийн мөнгө авдаг, 23.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой бол зөвхөн 6.4 хувь нь өрхийн аж ахуйгаас орлого олдог ажээ. Орлогын эх үүсвэрийг сарын дундаж орлого, өрхийн аж байдлын түвшнөөр харьцуулахад өрхийн сарын орлого болон аж байдлын түвшин өсөх тусам цалингаас гадна өрхийн аж ахуйгаас орлого олдог өрхийн хувь өсөж байна.

Хүснэгт 54. Өрхийн орлогын эх үүсвэрийн төрлүүд

| Өрхийн хувь, байршил, өрхийн сарын дундаж орлого, аж байдлын түвшнөөр | Эх үүсвэрийн төрлүүд | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Цалин | Өрхийн аж ахуй | Тэтгэвэр, тэтгэмж | Хүүхдийн мөнгө | Оюутны тэтгэлэг | Бусдаас авсан/нөхөн олговор | Зээл | Хадгаламж | Бусад эх үүсвэр |
| **Бүгд** | 70.6 | 6.4 | 23.4 | 43.5 | 0.9 | 0.2 | 1.8 | 0.5 | 7.8 |
| **Байршил** | | | | | | | | | |
| Дорнод | 74.2 | 6.2 | 21.6 | 13.4 | 1.0 | 0.0 | 4.1 | 0.0 | 10.3 |
| Дархан-Уул | 67.5 | 11.1 | 31.6 | 39.3 | 1.7 | 0.0 | 1.7 | 1.7 | 7.7 |
| Дундговь | 52.5 | 13.8 | 17.5 | 56.3 | 1.3 | 0.0 | 3.8 | 0.0 | 12.5 |
| Хөвсгөл | 76.2 | 0.0 | 42.9 | 76.2 | 0.0 | 0.0 | 0.0 | 4.8 | 0.0 |
| УБ-СХД | 76.0 | 2.4 | 20.3 | 50.4 | 0.4 | 0.4 | 0.4 | 0.0 | 6.1 |
| **Өрхийн сарын дундаж орлого, мянган төгрөг** | | | | | | | | | |
| <300 | 31.3 | 0.9 | 34.8 | 61.7 | 0.9 | 0.0 | 2.6 | 0.0 | 12.2 |
| 300-500 | 71.1 | 6.6 | 26.4 | 41.3 | 0.0 | 0.8 | 0.0 | 0.0 | 5.8 |
| 501-700 | 80.5 | 8.9 | 15.4 | 37.4 | 0.8 | 0.0 | 0.0 | 0.8 | 3.3 |
| 701-900 | 87.7 | 4.9 | 25.9 | 44.4 | 0.0 | 0.0 | 2.5 | 0.0 | 6.2 |
| 901-1,100 | 77.6 | 10.2 | 16.3 | 36.7 | 2.0 | 0.0 | 2.0 | 0.0 | 14.3 |
| 1,101-1,600 | 94.0 | 6.0 | 16.0 | 36.0 | 4.0 | 0.0 | 4.0 | 4.0 | 8.0 |
| 1,601-2,100 | 90.9 | 9.1 | 9.1 | 27.3 | 0.0 | 0.0 | 9.1 | 0.0 | 0.0 |
| 2,100 > | 81.8 | 27.3 | 18.2 | 18.2 | 0.0 | 0.0 | 9.1 | 0.0 | 27.3 |
| **Өрхийн аж байдлын түвшин** | | | | | | | | | |
| Доогуур | 52.7 | 2.7 | 31.3 | 59.8 | 0.9 | 0.9 | 0.0 | 0.0 | 8.0 |
| Дунджаас доогуур | 67.9 | 4.5 | 25.9 | 55.4 | 0.0 | 0.0 | 2.7 | 0.0 | 3.6 |
| Дундаж | 74.3 | 7.1 | 21.2 | 44.2 | 0.9 | 0.0 | .9 | 1.8 | 8.8 |
| Дунджаас дээгүүр | 75.0 | 8.9 | 21.4 | 39.3 | 0.9 | 0.0 | 1.8 | 0.0 | 8.9 |
| Дээгүүр | 83.0 | 8.9 | 17.0 | 18.8 | 1.8 | 0.0 | 3.6 | 0.9 | 9.8 |

## 3.Хүүхдийн эх/асран хамгаалагчийн мэдээлэл

Энэ хэсэгт хүүхдийн эх, асран хамгаалагчийн үйлдлийн чадварыг тодорхойлохын сацуу тэдгээрийн ерөнхий шинж байдлын талаар авч үзнэ.

### 3.1 Эх, асран хамгаалагчийн үйлдлийн чадвар

Үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж илэрсэн 2-17 насны хүүхэдтэй 657 эх, асран хамгаалагчийн 6.7 хувь нь наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй, 4.7 хувь нь нэгээс дээш үйлдлийн чадварын хүндрэлтэй байна. Илэрсэн түгээмэл үйлдлийн чадварын хүндрэлүүд нь алхах, харах, сонсох чадварууд байна. Эх, асран хамгаалагчдын 21.8 хувь нь харааны шил зүүдэг, 2.4 хувь нь сонсголын аппарат зүүдэг байна. Харааны шил, сонсголын аппарат зүүснээр олонх нь үйлдлийн чадварын хүндрэлээ шийдэж чадсан байна. Тодруулбал, харааны шил зүүдэг ч харааны хүндрэлтэй хэвээр байгаа эх, асран хамгаалагчийн хувь 1.8 хувь, сонсголын аппарат зүүдэг ч сонсоход хүндрэлтэй хүмүүсийн хувь 0.8 байна.

Наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй эх, асран хамгаалагчдыг гол үзүүлэлтүүдээр нь харьцуулан авч үзэхэд Улаанбаатар, Дархан-Уул аймгийн нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй эх, асран хамгаалагчдын хувь, 10-14, 15-17 насны хүүхэдтэй эх, асран хамгаалагчдын эзлэх хувь ялимгүй өндөр байна. Түүнчлэн аж байдлын доогуур түвшинтэй өрхүүдийн 11.9 хувьд нь наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй эх, асран хамгаалагчид байна.

## Хүснэгт 55. Эх, асран хамгаалагчийн үйлдлийн чадвар

Эх, асран хамгаалагчийн хувь, байршил, хүүхдийн нас, үндэс угсаа, өрхийн аж байдлын түвшнөөр

| | Эх, асран хамгаалагчдын тоо | Эх, асран хамгаалагчийн хувь | | Үйлдлийн чадварын хүндрэлийн хэлбэрээр | | | | | | Нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй эх, асран хамгаалагчийн хувь | Нэгээс дээш үйлдлийн чадварын хүндрэлтэй эх, асран хамгаалагчийн хувь | Харааны шил, контакт линз зүүдэг ч харааны хүндрэлтэй эх, асран хамгаалагчийн хувь | Сонсголын аппарат зүүдэг ч сонсоход хүндрэлтэй эх, асран хамгаалагчийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хараааны шил /контакт линз зүүдэг | Сонсголын аппарат зүүдэг | Харах | Сонсох | Алхах | Эргэн санах | Өөртөө үйлчлэх | Харилцах | | | | |
| **Бүгд** | 657 | 21.8 | 2.4 | 3.8 | 3.7 | 6.1 | 2.7 | 1.1 | 0.8 | 6.7 | 4.7 | 1.8 | 0.8 |
| **Байршил** | | | | | | | | | | | | | |
| Дорнод | 110 | 29.1 | .9 | 0.0 | .9 | 7.3 | .9 | 1.8 | 0.0 | 5.5 | 2.7 | 0.0 | 0.0 |
| Дархан-Уул | 134 | 23.1 | 1.5 | 6.7 | 11.2 | 11.9 | 6.7 | 2.2 | 3.7 | 6.7 | 13.4 | 1.5 | .7 |
| Дундговь | 87 | 11.5 | 3.4 | 2.3 | 2.3 | 2.3 | 2.3 | 0.0 | 0.0 | 4.6 | 2.3 | 1.1 | 0.0 |
| Хөвсгөл | 21 | 4.8 | 4.8 | 0.0 | 0.0 | 9.5 | 0.0 | 4.8 | 0.0 | 4.8 | 4.8 | 0.0 | 0.0 |
| УБ-СХД | 305 | 22.6 | 3.0 | 4.6 | 2.0 | 3.9 | 2.0 | .3 | 0.0 | 7.9 | 2.3 | 3.0 | 1.3 |
| **Хүүхдийн нас** | | | | | | | | | | | | | |
| 2-5 | 85 | 23.5 | 1.2 | 1.2 | 3.5 | 2.4 | 0.0 | 0.0 | 1.2 | 1.2 | 3.5 | 1.2 | 0.0 |
| 6-9 | 235 | 20.4 | 1.7 | 4.3 | 3.4 | 6.4 | 3.0 | 1.3 | .4 | 6.4 | 4.7 | 1.7 | 0.0 |
| 10-14 | 232 | 21.1 | 3.0 | 4.3 | 5.6 | 7.3 | 3.4 | 1.3 | 1.3 | 8.6 | 6.5 | 1.7 | 2.2 |
| 15-17 | 105 | 24.8 | 3.8 | 3.8 | 0.0 | 5.7 | 2.9 | 1.0 | 0.0 | 7.6 | 1.9 | 2.9 | 0.0 |
| **Хүйс** | | | | | | | | | | | | | |
| Эрэгтэй | 333 | 19.8 | 1.5 | 3.9 | 3.9 | 6.6 | 3.0 | .9 | .6 | 6.6 | 4.8 | 1.2 | .3 |
| Эмэгтэй | 324 | 23.8 | 3.4 | 3.7 | 3.4 | 5.6 | 2.5 | 1.2 | .9 | 6.8 | 4.6 | 2.5 | 1.2 |
| **Үндэс угсаа** | | | | | | | | | | | | | |
| Халх | 536 | 21.1 | 2.8 | 3.9 | 3.0 | 5.6 | 3.0 | .7 | .2 | 6.7 | 3.7 | 1.9 | .9 |
| Бусад | 119 | 25.2 | .8 | 3.4 | 6.7 | 8.4 | 1.7 | 2.5 | 3.4 | 6.7 | 9.2 | 1.7 | 0.0 |
| Хариулаагүй | 2 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| **Өрхийн аж байдлын түвшин** | | | | | | | | | | | | | |
| Доогуур | 134 | 16.4 | 4.5 | 7.5 | 1.5 | 11.9 | 6.7 | 2.2 | 0.0 | 11.9 | 6.7 | 2.2 | 0.0 |
| Дунджаас доогуур | 143 | 21.0 | 2.1 | 1.4 | 4.2 | 3.5 | .7 | 0.0 | 0.0 | 4.9 | 2.1 | 1.4 | 2.1 |
| Дундаж | 137 | 17.5 | 1.5 | 4.4 | 5.8 | 5.1 | 3.6 | 1.5 | 3.6 | 2.9 | 8.8 | 2.2 | .7 |
| Дунджаас дээгүүр | 124 | 24.2 | 2.4 | 4.0 | 3.2 | 6.5 | 2.4 | 1.6 | 0.0 | 7.3 | 4.8 | 1.6 | 0.0 |
| Дээгүүр | 119 | 31.1 | 1.7 | 1.7 | 3.4 | 3.4 | 0.0 | 0.0 | 0.0 | 6.7 | .8 | 1.7 | .8 |

## 3.2.Эх, асран хамгаалагчийн шинж байдал

2-17 насны хүүхдүүдтэй эх, асран хамгаалагчдын 77 хувь нь гэрлэсэн, 5 хувь нь хамтран амьдрагчтай бол 15.4 хувь нь бэлэвсэн, салсан, гэрлэсэн ч тусдаа амьдардаг, 3 хувь нь ганц бие ажээ. Бага насны буюу 2-5 насны хүүхэдтэй гэрлэсэн эх, асран хамгаалагчдын хувь бусад насны хүүхэдтэй эх, асран хамгаалагчдын хувиас дунжаар 10 орчим хувиар өндөр байна. Харин 6-9 насны хүүхэдтэй эх, асран хамгаалагчдын салалтын хувь бусад насны хүүхэдтэй эх, асран хамгаалагчдаас их байна.

Дүрс 29.Эх, асран хамгаалагчдын гэрлэлтийн байдал, (n=657)




Дүрс 30. Эх, асран хамгаалагчдын гэрлэлтийн байдал, хүүхдийн насны ангиллаар, %




2-17 насны хүүхдүүдтэй эх, асран хамгаалагчдын 45.8 хувь нь цалин хөлстэй ажил эрхэлдэг бөгөөд тэдний олонх нь хувийн ба төрийн байгууллагад ажиллаж байна. 15.8 хувь хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч, малчин, нөхөрлөл хоршооны гишүүн бол 10 хувь нь тэтгэвэрт, 3.7 хувь нь оюутан, гэртээ хүн асардаг, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч ажээ. Харин 21 хувь нь одоогоор ажил эрхлээгүй байна.

Дүрс 31. Эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдал, (n=657), %




Дүрс 32. Цалин хөлстэй ажиллагч эх, асран хамгаалагчдын ажилладаг байгууллагын төрөл, (n=301)




Хүснэгт 56-д эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдлыг байршил, хүүхдийн насны бүлэг, хүйс, үндэс угсаа, өрхийн аж байдлын түвшнөөр харууллаа.

### Хүснэгт 56. Эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдал

| Эх, асран хамгаалагчдын хувь, байршил, хүүхдийн насны бүлэг, хүйс, үндэс угсаа, аж байдлын түвшнөөр | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эх/асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдлын хувь | | | | | | | | | | |
| | Бүгд | Цалин хөлстэй ажиллагч | Ажил олгогч | Хувиараа хөдөлмөр эрхлэгч | Нөхөрлөл хоршооны гишүүн | Мал аж ахуй эрхлэгч | Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ... | Оюутан | Тэтгэвэрт | Гэрт хүн асардаг | Бусад | Ажил эрхэлдэггүй |
| **Бүгд** | 657 | 45.8 | 0.8 | 14.3 | 0.2 | 0.5 | 0.9 | 1.4 | 10.0 | 1.4 | 0.6 | 21.0 |
| **Байршил** | | | | | | | | | | | | |
| Дорнод | 110 | 54.5 | 1.8 | 11.8 | 0.0 | 0.0 | 2.7 | 0.9 | 14.5 | 0.0 | 0.9 | 11.8 |
| Дархан-Уул | 134 | 40.3 | .7 | 12.7 | 0.0 | 0.0 | 0.0 | 1.5 | 12.7 | 3.0 | 2.2 | 20.1 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дундговь | 87 | 42.5 | 0.0 | 19.5 | 0.0 | 3.4 | 2.3 | 0.0 | 10.3 | 1.1 | 0.0 | 18.4 |
| Хөвсгөл | 21 | 57.1 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 4.8 | 14.3 | 0.0 | 0.0 | 19.0 |
| УБ-СХД | 305 | 45.2 | 0.7 | 15.4 | 0.3 | 0.0 | 0.3 | 1.6 | 6.9 | 1.3 | 0.0 | 25.6 |
| **Хүүхдийн насны бүлэг** | | | | | | | | | | | | |
| 2-5 | 85 | 48.2 | 3.5 | 5.9 | 1.2 | 0.0 | 1.2 | 1.2 | 5.9 | 0.0 | 2.4 | 30.6 |
| 6-9 | 235 | 45.5 | 0.0 | 16.2 | 0.0 | 0.0 | 1.7 | 1.3 | 8.5 | 1.3 | 0.9 | 20.0 |
| 10-14 | 232 | 44.8 | 0.4 | 14.2 | 0.0 | 1.3 | 0.0 | 1.3 | 13.8 | 1.7 | 0.0 | 19.4 |
| 15-17 | 105 | 46.7 | 1.0 | 17.1 | 0.0 | 0.0 | 1.0 | 1.9 | 8.6 | 1.9 | 0.0 | 19.0 |
| **Хүйс** | | | | | | | | | | | | |
| Эрэгтэй | 333 | 45.6 | 0.6 | 13.5 | 0.3 | 0.6 | 1.2 | 2.1 | 8.7 | 0.9 | 0.3 | 22.5 |
| Эмэгтэй | 324 | 46.0 | 0.9 | 15.1 | 0.0 | 0.3 | 0.6 | 0.6 | 11.4 | 1.9 | 0.9 | 19.4 |
| **Үндэс угсаа** | | | | | | | | | | | | |
| Халх | 536 | 46.1 | .9 | 14.4 | 0.0 | 0.6 | 0.9 | 1.1 | 9.3 | 1.1 | 0.6 | 22.2 |
| Бусад | 119 | 44.5 | 0.0 | 14.3 | 0.8 | 0.0 | 0.8 | 2.5 | 13.4 | 2.5 | 0.8 | 15.1 |
| Хариулаагүй | 2 | 50.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 50.0 |
| **Өрхийн аж байдлын түвшин** | | | | | | | | | | | | |
| Доогуур | 134 | 41.0 | 0.0 | 9.7 | 0.0 | 0.7 | 0.0 | 0.0 | 12.7 | 0.7 | 0.0 | 32.1 |
| Дунджаас доогуур | 143 | 47.6 | 0.0 | 9.8 | 0.7 | 0.0 | 0.7 | 2.1 | 7.7 | 2.8 | 2.1 | 21.7 |
| Дундаж | 137 | 44.5 | 1.5 | 21.2 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.9 | 10.9 | 1.5 | 0.0 | 15.3 |
| Дунджаас дээгүүр | 124 | 42.7 | 0.0 | 16.9 | 0.0 | 1.6 | 0.8 | 1.6 | 11.3 | 1.6 | 0.0 | 20.2 |
| Дээгүүр | 119 | 53.8 | 2.5 | 14.3 | 0.0 | 0.0 | 3.4 | 0.0 | 7.6 | 0.0 | 0.8 | 15.1 |

# Хавсралт 2-Хүүхдийн хөгжилд нөлөөлөх бусад үзүүлэлт

## 2.1 Хүүхдийн хүмүүжил

Хүүхэд амжилттай суралцахад сургуулийн орчин нөхцөлөөс гадна гэр бүлийн орчин, дэмжлэг, эцэг эхийн харилцаа хандлага чухал оролцоотой. Тодруулбал, хүүхдийн хүмүүжил 0-6 насанд эрчимтэй явагдаж, 6-12 насанд хүмүүжлийн суурь тавигдаж дуусдаг гэж үздэг. Үүний дараанаас өсвөр насны төлөвшил явагдаж эхэлдэг (МУБИС., 2018). Иймд хүүхдийн хамгийн анхны хүмүүжүүлэгчид болох эцэг эхийн ойлголт, хандлага, арга барил нь хувь хүний төлөвшлийн гол хүчин зүйл юм.

2016 онд МУБИС-ийн Боловсролын судалгаа арга зүйн тэнхимээс хот, хөдөөгийн ЕБС-ийн багш, эцэг эхчүүдийн хүмүүжлийн тухай ойлголт, хандлагыг тодруулах зорилгоор түүвэр судалгаа хийсэн байна (Ш.Ичинхорлоо, 2017). Судалгааны дүнгээр "Гэр бүлийн таагүй орчин, уур амьсгал" хүүхдийн хүмүүжилд нэн тэргүүнд хамгийн их нөлөөлдөг гэж нийт судалгаанд оролцсон эцэг эх болон багш нарын 60 хувь нь дурджээ. Үүнээс үзэхэд эцэг эх өөрсдөө хүүхдийнхээ хүмүүжилд хэрхэн ханддаг, шийтгэл хүчирхийллийг хэрхэн ойлгодог байх нь хүүхэд амжилттай сурч боловсроход шууд бус утгаараа нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Тус судалгааны хүрээнд судалгаанд хамрагдсан 2-14 хүртэлх насны хүүхдүүдийн эцэг эхчүүдийн сүүлийн 1 сарын хугацаанд хүүхдээ хүмүүжүүлэх зорилгоор ашигладаг аргуудыг тодруулсан. Үүнээс гадна, бие махбодын шийтгэлд хандах хандлагыг тодруулж шинж байдлын бусад үзүүлэлтүүдтэй харьцуулж үзэв. Дээрх асуултуудын үр дүнг Хүснэгт 57-д харуулав.

**Хүснэгт 57. Хүүхдэд ашиглаж буй хүмүүжлийн арга, аймгаар**

| | Хүчирхийллийн бус арга хэрэглэдэг[23] | Сэтгэл санааны хүчирхийллийн арга[24] | Бие махбодын хүчирхийлэл | Хүнд шийтгэл[25] | Нийт хүүхдийн тоо |
|---|---|---|---|---|---|
| Дорнод | 45.5% | 34.1% | 21.6% | 3.4% | 88 |
| Дархан | 45.4% | 31.1% | 25.2% | 2.5% | 119 |
| Дундговь | 75.7% | 10.8% | 10.8% | 1.4% | 74 |
| Хөвсгөл | 26.3% | 31.6% | 5.3% | 0.0% | 19 |
| УБ-СХД | 43.3% | 32.9% | 28.2% | 4.8% | 252 |
| Нийт | | | | | 552 |

Хэрвээ хүүхэд нь ямар нэгэн буруу үйлдэл хийсэн бол хүмүүжүүлэх зорилгоор хүнд хэлбэрийн шийтгэлийн арга хэлбэрийг ашигладаг эцэг эхийн хувь Улаанбаатар хотод өндөр гарсан байна. Хүүхдийн настай харьцуулан харахад нас нэмэгдэх хэрээр хүнд хэлбэрийн шийтгэлийн арга ашиглах байдал нэмэгдэж байсан. Бусад шинж байдлын үзүүлэлтээр харьцуулан харахад эцэг эхийн боловсролын түвшин нэмэгдэх хэрээр хүнд хэлбэрийн

[23] Хүчирхийллийн бус арга гэдэгт: Хүүхдэдээ бурууг нь хэлж тайлбарлах, бурууг нь ойлгуулах зорилгоор ямар нэгэн үйлдэл хийлгэх арга хэмжээ авч буйг ойлгоно.

[24] Сэтгэл санааны хүчирхийлэл гэдэгт: Хүүхэд рүүгээ орилж хашхирах, загнах үйлдлүүд

[25] Хүнд хэлбэрийн хүчирхийлэл гэдэгт: Хацар дээр нь алгадах, нүүр, толгой уруу нь цохих, чихийг нь мушгих, хүчтэй олон удаа цохих, зодох зэрэг үйлдлүүд багтана.

шийтгэлийн арга хэлбэрийг ашиглах байдал нэмэгдэж байгаа нь сонирхол татахуйц үр дүн байв.

Үйлдлийн чадварын төрлөөс хамаараад авч байгаа хүмүүжлийн аргад ялгаа бий эсэхийг харахад 2-6 насны хүүхдүүдийн хувьд "Зан авираа удирдахад хүндрэлтэй хүүхдүүд", 6-14 насны хүүхдүүдээс "Анхаарлаа төвлөрүүлэх" чадварын хүндрэлтэй хүүхдүүдэд хүнд хэлбэрийн шийтгэлийн арга хэрэглэх байдал өндөр байна.

Хүснэгт 58. Хүүхдийг хүмүүжүүлэхэд ашиглаж буй арга, үйлдлийн бэрхшээлийн төрлөөр

| | Хүчирхийллийн бус арга хэрэглэдэг[26] | Сэтгэл санааны хүчирхийллийн арга[27] | Бие махбодын хүчирхийлэл | Хүнд шийтгэл[28] | Нийт хүүхдийн тоо |
|---|---|---|---|---|---|
| **2-6 нас** | | | | | |
| Харах | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 2 |
| Сонсох | 50.0 | 0.0 | 50.0 | 0.0 | 2 |
| Алхах | 0.0 | 50.0 | 50.0 | 0.0 | 2 |
| Жижиг булчингийн үйл ажиллагаа | 50.0 | 50.0 | 0.0 | 0.0 | 2 |
| Хэл яриа, харилцаа | 50.0 | 16.7 | 50.0 | 0.0 | 6 |
| Суралцах | 25.0 | 25.0 | 25.0 | 0.0 | 4 |
| Тоглох | 53.8 | 7.7 | 7.7 | 0.0 | 13 |
| Зан авираа удирдах | 43.2 | 22.7 | 38.6 | 2.3 | 44 |
| **Нийт** | | | | | **552** |
| **6-14 нас** | | | | | |
| Харах | 50.0 | 25.0 | 25.0 | 0.0 | 12 |
| Сонсох | 80.0 | 20.0 | 0.0 | 0.0 | 5 |
| Алхах | 40.0 | 20.0 | 30.0 | 0.0 | 10 |
| Өөртөө үйлчлэх | 50.0 | 50.0 | 0.0 | 0.0 | 2 |
| Хэл яриа, харилцаа | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 1 |
| Суралцах | 40.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 5 |
| Сэргээн санах | 0.0 | 66.7 | 0.0 | 0.0 | 3 |
| Анхаарлаа төвлөрүүлэх | 0.0 | 33.3 | 66.7 | 33.3 | 3 |
| Өөрчлөлтөд дасан зохицох | 25.0 | 50.0 | 50.0 | 0.0 | 4 |
| Зан авираа удирдах | 33.3 | 33.3 | 0.0 | 0.0 | 3 |
| Бусадтай найзалж нөхөрлөх | 66.7 | 0.0 | 0.0 | 0.0 | 9 |
| Уур бухимдал | 50.3 | 29.2 | 19.9 | 3.1 | 161 |
| Сэтгэлийн түгшүүр | 46.9 | 34.8 | 25.1 | 5.8 | 207 |
| **Нийт** | | | | | **444** |

[26] Хүчирхийллийн бус арга гэдэгт: Хүүхдэдээ бурууг нь хэлж тайлбарлах, бурууг нь ойлгуулах зорилгоор ямар нэгэн үйлдэл хийлгэх арга хэмжээ авч буйг ойлгоно.

[27] Сэтгэл санааны хүчирхийлэл гэдэгт: Хүүхэд рүүгээ орилж хашхирах, загнах үйлдлүүд

[28] Хүнд хэлбэрийн хүчирхийлэл гэдэгт: Хацар дээр нь алгадах, нүүр, толгой уруу нь цохих, чихийг нь мушгих, хүчтэй олон удаа цохих, зодох зэрэг үйлдлүүд багтана.

Харин эцэг эхчүүдийн хүмүүжил, шийтгэлийн аргад хандаж буй хандлагыг тодорхойлох зорилготой асуултад нийт эцэг эхийн 9 хувь нь хүүхдийн хүмүүжилд бие махбодын шийтгэл байх нь зүйтэй гэж хариулсан. Хүйсийн хувьд эрэгтэй хүүхэдтэй эцэг эхчүүд илүү дэмжсэн хариулт өгсөн байна. Эцэг эхийн боловсролын түвшинтэй харьцуулж үзэхэд эцэг эхийн боловсролын түвшин нэмэгдэх хэрээр тус байр суурийг дэмжсэн байгаа нь мөн анхаарал татахуйц үзүүлэлт байв (Хүснэгт 59)

Хүснэгт 59. Эцэг эхчүүдийн бие махбодын шийтгэлд хандах хандлага

| | | Бие махбодын шийтгэл байх ёстой гэж үзсэн эцэг эхийн хувь | Нийт судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо |
|---|---|---|---|
| Бүгд | | 9.0 | 657 |
| Хүйс | Эрэгтэй | 11.1 | 333 |
| | Эмэгтэй | 6.8 | 324 |
| Age | 2-5 | 8.2 | 85 |
| | 6-9 | 9.8 | 235 |
| | 10-14 | 12.5 | 232 |
| | 15-17 | 0.0 | 105 |
| Аж байдлын индекс | Доогуур | 9.7 | 134 |
| | Дундаас доогуур | 9.1 | 143 |
| | Дундаж | 8.8 | 137 |
| | Дунджаас дээгүүр | 7.3 | 124 |
| | Дээгүүр | 10.1 | 119 |
| Зорилтот аймаг, дүүрэг | Дорнод аймаг | 8.2 | 110 |
| | Дархан аймаг | 10.4 | 134 |
| | Дундговь аймаг | 0.0 | 87 |
| | Хөвсгөл аймаг | 0.0 | 21 |
| | СХД | 11.8 | 305 |
| Өрхийн тэргүүлэгчийн шашин | Шүтдэггүй | 10.5 | 306 |
| | Будда | 8.3 | 266 |
| | Бусад | 8.1 | 62 |
| Эхийн боловсролын түвшин | Боловсролгүй | 7.9 | 76 |
| | Бага | 5.0 | 20 |
| | Суурь | 8.7 | 103 |
| | Дунд | 7.3 | 150 |
| | Мэргэжлийн | 13.5 | 52 |
| | Дээд | 10.1 | 179 |
| Эцгийн боловсролын түвшин | Боловсролгүй | 10.5 | 57 |
| | Бага | 13.8 | 29 |
| | Суурь | 5.7 | 87 |
| | Дунд | 11.8 | 127 |
| | Мэргэжлийн | 8.3 | 84 |
| | Дээд | 10.0 | 90 |

## 2.2 Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

Монгол Улс нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай” 182 дугаар Конвенцод, 2001 онд “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн конвенц”-д, 2002 онд “Насны доод хязгаарын тухай конвенц”-д нэгдэн орсон. “Монгол Улсын Үндсэн хууль”, “Хөдөлмөрийн тухай”, “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулиудад хүүхдийн хөдөлмөртэй холбоотой харилцааг зохицуулж өгсөн байдаг.

ҮСХ-оос 2006-2007 онд явуулсан "Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан"-аас үзэхэд Монгол Улсад 5-17 насны хүүхдийн 11,5 хувь буюу 71,330 хүүхэд ажил эрхэлж байна. Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин 2002-2003 оны байдлаар 10,1 хувь байснаа 2006-2007 онд 11,5 хувьд хүрч нэмэгдсэн. Ажил эрхэлж байгаа хүүхдийн 88,9 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна. Нийт ажил эрхэлж байгаа хүүхдийн 89,5 хувь нь өрхийн бизнесийн үйл ажиллагаанд цалин хөлсгүйгээр оролцогч, 8,8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1,6 хувь нь зохих цалин хөлстэй оролцогч хэлбэрээр ажил эрхэлдэг байв. Мөн нийт ажил эрхэлж байгаа хүүхдийн 16,0 хувь буюу 11400 орчим хүүхэд насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байранд, уртасгасан цагаар, эсвэл хүнд, хортой нөхцөлд ажиллаж байв[29]. Тиймээс 2011 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг баталсан[30]. 2016 оны Хөдөлмөрийн тухай хуулиар 15 нас хүртэлх насны хүүхэд ажил эрхлэхийг зөвшөөрөхгүй, харин 16 наснаас хүүхдүүд хөдөлмөрийн гэрээ байгуулж болно гэж тусгасан. Хөдөлмөрийн аюултай нөхцөлд зөвхөн 18 нас хүрсэн хүн л хөдөлмөр эрхлэхийг 2016 онд Хөдөлмөрийн сайдын А/36-р тогтоолоор баталж насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтаар баталсан байдаг.

2016 онд баталсан ТХЗ-ын 8-р зорилтын 7.1-д "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгах чиглэлээр шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авч, албадан хөдөлмөр хийлгэх явдлыг арилгаж, бүх хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр, түүний дотор хүүхдийг цэрэг болгон элсүүлэх, ашиглах явдлыг 2025 он гэхэд эцэс болгох” гэж заасан. Үүнийг тооцох аргачлал нь 5-17 насны нийт хүүхдийн тоонд уг насны, ажил хийсэн буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоог хувааж тооцно. ҮСХ 4 жил тутамд хүүхдийн хөдөлмөрийн судалгааг АХС-ны хавсарга байдлаар хийдэг. Хамгийн сүүлд Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2011-2012 онд гарсан. Уг судалгаанаас "Хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн эзлэх хувийг 15.9 хувь гэж тооцож гаргасан байдаг. Гэвч ТХЗ нь хөдөлмөрийн аюултай нөхцөлийг тооцдоггүй, мөн 5-14 насны хүүхдийн хувьд хүүхдийн хөдөлмөр гэж үзэх гэрийн ажилд зарцуулсан цагийн доод хэмжээг 21 гэж тогтоосон байдаг бол 15-17 насны хүүхдийн хувьд гэрийн ажлын доод хэмжээг тогтоогоогүй байдаг байна[31].

---

[29] https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_538142.pdf

[30] https://www.legalinfo.mn/annex/details/2937?lawid=7722

[31] Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, НҮБХС, ҮСХ, 2018

ОУХБ-аас гаргасан тооцоогоор 2016 оны байдлаар Монгол улсад 5-17 насны хүүхдүүдийн 10 хувь буюу 56000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагийн дийлэнх нь хөдөө аж ахуй, уул уурхай, барилгын салбарт ажиллаж байна. Мөн 15-17 насны хүүхдийн талаас илүү нь аюултай, хортой нөхцөлд ажиллаж байна, хөдөө орон нутагт ядуу өрх олон байхын хэрээр хүүхдүүд хөдөлмөр эрхлэх нь элбэг, хөвгүүд охидуудаас илүүтэй хөдөлмөр эрхэлж байна гэсэн дүгнэлт гаргажээ[32].

ҮСХ-оос хийсэн НҮТС-аар 2013 онд 5-17 насны хүүхдүүдийн 17 хувь нь хөдөлмөр эрхэлж байсан бол 2018 онд хэвээрээ байна. Үүнээс хөвгүүдийн ажил эрхлэлт нь 20.1 хувьтай байгаа бол охидын ажил эрхлэлт 13.2 хувь байна. Хүүхдийн үйлдлийн чадварын хувьд хүндрэлгүй хүүхдүүдийн хувь хөдөлмөр эрхлэлт 16.5 хувь, эсрэгээрээ хүндрэлтэй хүүхдүүдийн хувьд хөдөлмөр эрхлэлт нь 21.8 хувь байв. Сургуульд суралцдаг хүүхдүүдийн хувьд 16 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бол сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн хувьд 27.3 хувь байна. Тус судалгаагаар гарсан бас нэгэн сонирхолтой үр дүн бол Казах өрхийн тэргүүнтэй өрхийн хувьд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт 25.9 хувь байхад халх өрхийн тэргүүнтэй өрхийн хувьд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт 14.6 хувь буюу бараг 10 хувиар бага байна.

Харин тус судалгаанд хүүхдийн хөдөлмөрийг НҮТС-тай ижил аргачлалаар судалсан[33]. Судалгааны үр дүнгээр үйлдлийн чадварын хүндрэлтэй 6-17 насны 556 хүүхдүүдийн 19.1 хувь нь сүүлийн долоо хоногт ямар нэгэн хөдөлмөр эрхэлсэн байна.

Дүрс 33. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал




Нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн 8.6 хувь нь гэрийн ажил, мөн 8.6 хувь нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа эрхэлснээс 5.9 хувь нь аюултай гэж тооцогдохоор нөхцөлд ажилласан байна.

---

[32] ЮСВ: Хүүхдийн хөдөлмөрийг ойлгохуй: (ЮСВ) Зүүн өмнөд, Зүүн Азийн бүс нутаг дахь хүүхдийн хөдөлмөр, боловсролын хоцрогдлын талаарх хос сорилт: 2015 оноос чинагш дэлхий ертөнц (Ром, 2015)

[33] ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

**5-11 нас:** Долоо хоногт наад зах нь 1 цаг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон эсвэл наад зах нь 28 цаг гэрийн ажил хийсэн, эсвэл аюултай нөхцөлд ажилладаг.

**12-14 нас:** Долоо хоногт наад зах нь 14 цаг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон, эсвэл наад зах нь 28 цаг гэрийн ажил хийсэн, эсвэл аюултай нөхцөлд ажилладаг.

**15-17 нас:** Долоо хоногт наад зах нь 43 цаг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон, эсвэл наад зах нь 43 цаг гэрийн ажил хийсэн, эсвэл аюултай нөхцөлд ажилладаг. Эдийн засгийн үйл ажиллагаа гэдэгт өрхөөс гадуур эсвэл өрхийн мал аж ахуй, бизнест хөлстэй болон хөлсгүй ажил хийх орно. Гэрийн ажилд хоол хийх, гэр цэвэрлэх, хүүхэд асрах, түлээ түлш бэлтгэх, усанд явах зэрэг ажлууд орно.

## Дүрс 34. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүйсээр

| | ГЭРИЙН АЖИЛ | ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | АЮУЛТАЙ НӨХЦӨЛ |
|---|---|---|---|
| Эрэгтэй | 5.8 | 10.2 | 7.3 |
| Эмэгтэй | 11.3 | 7.1 | 4.6 |

Нийт хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийг хүйсээр нь харьцуулан харвал гэрийн ажлыг эмэгтэй хүүхдүүд илүү хийдэг, эрэгтэй хүүхдүүд эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд түлхүү оролцдог.

Эмэгтэй хүүхдүүдээс эрэгтэй хүүхдүүд илүү хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажилладаг байна.

## Дүрс 35. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, байршлаар, хувиар




Хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийг аймгаар нь харьцуулан харвал Дархан-Уул аймгаас үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн 23 хүртэл хувь ямар нэгэн хөдөлмөр эрхэлсэн байгаа нь хамгийн өндөр байна. Энэ үзүүлэлт нь Сонгинохайрхан дүүрэгт 19,3 хувь, Дундговь аймагт 19 хувь байна.

Дундговь, Дархан-Уул аймгуудад хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн дийлэнх нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцсон байна. Сонгинохайрхан дүүрэгт хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийн 9.7 хувь нь гэрийн ажил, 6.7 хувь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцсон байна. Сонгинохайрхан дүүргийн хувьд Дархан-Уул, Дундговь аймгуудыг бодвол эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцсон хүүхэд бага байгаа боловч хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажилладаг хүүхдийн хувь өндөр байна.

Хөвсгөл аймаг дахь үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул, Дундговь аймгуудаас бага байгаа боловч гэрийн ажил хийдэг, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцсон, хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажилладаг хүүхдүүдийн хувь жигд өндөр байна.

Дархан, Дундговь аймгуудад хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажилладаг хүүхдийн хувь аль аль нь өндөр байна.

Дүрс 36. 6-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт сургуульд хамрагдалтаар, хувиар




Судалгаанд хамрагдсан үйлдлийн чадварын хүндрэлтэй 556 хүүхдийн 544 нь сургуульд суралцсан. Сургуульд суралцсан 544 хүүхдийн 19.5 хувь нь сүүлийн долоо хоногт ямар нэгэн хөдөлмөр эрхэлсэн байна. Эдгээр хүүхдүүдийг хөдөлмөр эрхэлсэн байдлаар нь задлан харуулбал 8.8 хувь нь гэрийн ажил, мөн 8.8 хувь нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцсон бөгөөд 6.1 хувь нь хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажилладаг байна.

Сургууль завсардсан нийт 11 хүүхдийн дунд сүүлийн долоо хоног хөдөлмөр эрхэлсэн хүүхэд байхгүй байна. Харин тэдгээр хүүхдүүдийн 36.6 хувь нь гэрийн ажил хийсэн боловч өөрийн насны хязгаарт харгалзах хэмжээнээс давсан хугацаанд ажилласан хүүхэд байхгүй байна.